

ТАНИЛЦУУЛГА

*Татварын ерөнхий хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл*

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 89 дүгээр зүйлд татвар төлөгч болон татварын албаны хооронд үүсдэг маргааныг хянан шийдвэрлэх журмыг хуульчлах, одоо үйлчилж байгаа хуулийн хоёрдмол утга санаатай зохицуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор Татварын ерөнхий хуулийг шинэчлэн батлуулахаар холбогдох хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Татварын ерөнхий хуульд туссан татвар төлөгчийн эрх үүрэг нь татварын албаны эрх үүрэгтэй харилцан урвуу хамааралтай байх ёстой боловч өнөөгийн мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжид татвар төлөгч, татварын албаны хоорондын эрх үүргийн тэнцвэр алдагджээ.

Иймд Татварын ерөнхий хуульд туссан дээрх эрх, үүргийн тэнцвэрийг хангах зорилгоор холбогдох зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэх, тус хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай шинэ харилцааг хуульчлах нь зүйтэй байна. Түүнчлэн татварын хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой болгож, хуулийн давхардсан зохицуулалтыг арилгах нь зүйтэй байна. Тухайлбал, энэ хуулийн хүрээнд цоо шинээр бий болгох зохицуулалтаас дурдвал:

1. Татвар төлөгч сайн дурын үндсэн дээр тайлангаа засах эрхтэй болно. Татвар төлөгчийн татварын тайлангийн алдааг зөвхөн татварын хяналт шалгалт хийгдэж акт тавьсны дараа засварлах боломж үүсч байгааг өөрчлөн татвар төлөгчид өөрөө тайлангаа засах боломжийг олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Одоогийн үйлчилж байгаа хуулийн хүрээнд татвар төлөгч татварын тайлангаа нэгэнт буруу гаргасан бол уг тайлангаа засварлах боломжгүй байдаг. Бусад улсуудын туршлагаас үзэхэд татвар төлөгч нь татварын тайлангийн алдаагаа засах боломжийг олгосон байдаг тул холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

2. Татварын давуу эрхийн зарчмыг шинээр нэвтрүүлнэ. Татвар бол төрийн оршин тогтнох үндэс бөгөөд татварын орлогоор төрийн халамж, үйлчилгээг иргэдэд үзүүлж, эрүүл мэнд, боловсрол батлан хамгаалах зэрэг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд гол эх үүсвэр болдог. Энэ утгаараа татвар төлөх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний үндсэн үүрэг гэж заасан боловч энэхүү үүргийн хэрэгжилтийг хангах асуудлыг бусад салбар хуульд тодорхой заагаагүйгээс аливаа өр төлбөрөөс татварыг хэдийд гаргуулах талаар тодорхой дүрэм байдаггүй. Үүнээс шалтгаалан татварын өрийг бусад төрлийн авлага, хохирлыг барагдуулсны дараагаар гаргуулан авч байгаа нь зохимжгүй юм. Иймээс энэхүү шинэчлэлээр татварын өрийг гаргуулахдаа хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэл болон аливаа барьцаат эрхийн дараа нь хураах нь зүйтэй байна.

3. Татварын зорилгоор бусад улсуудтай мэдээлэл харилцан солилцдог болно. Европын холбооны комиссоос 2017 онд анх удаа гаргасан “Татварын

зорилгоор хамтарч ажилладаггүй бүс нутгуудийн жагсаалт”-д Монгол Улсыг оруулсан нь цаашид хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр байсан.

Иймд Засгийн газрын 2017 оны 350 дугаар тогтоолын дагуу Монгол Улс 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын зорилгоор мэдээлэл солилцоо, ил тод байдлын олон улсын форумд элсэн орсон. Энэхүү форумд элсэн орсноор цаашид татварын зорилгоор бусад улстай мэдээлэл солилцох, хамтран ажиллах томоохон боломж бий болж байгаа хэдий ч энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор татварын хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд тус байгууллагаас тавигддаг мэдээлэл солилцоо, ил тод байдал, мэдээллийн нууцлалтай холбоотой шаардлагуудыг хуулийн төсөлд тусгасан.

4. Эрсдэлтэй татварыг урьдчилан хураана. Одоогийн үйлчилж байгаа хуулийн зохицуулалтаар ногдуулах татварын хэмжээ нь тодорхой болсон татвар төлөгч нь татвар төлөхөөс зугтах, эсхүл зугтахыг оролдох зэргээр татварын өр хураах үйл ажиллагаанаас зайлсхийх бодитой эрсдэл учирдаг. Энэ үед Татварын алба тодорхой арга хэмжээг авч чадалгүй татварын орлогоо алдах явдал түгээмэл байна. Өөрөөр хэлбэл, татвар төлөгч татварын тайлан гаргахдаа татварын ногдлоо өөрөө тодорхойлсон боловч татвар төлөх хугацаа нь болоогүй байхад уг хуулийн этгээд нь татан буугдах бол татварын албанд ямар ч эрх хэмжээ байдаггүй. Иймд тодорхой эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд татварыг урьдчилан хураадаг зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

5. Татвар төлөгч татварын өрөө төлөлгүй хөрөнгөө бусдад шилжүүлэх бол уг этгээдээс татварын өрийг төлүүлнэ. Зарим тохиолдолд татвар төлөгч нь өөрийн хөрөнгө, үйл ажиллагаагаа үнэгүйдүүлж бусдад хэт бага үнээр, эсхүл үнэгүй шилжүүлснээр татварын өр төлөх чадваргүй болж татвар төлөх үүргээс зайлсхийж байна. Иймд татварын өрийг тэрхүү бусдад шилжүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны хэмжээнээс хамааруулж уг шилжүүлж авсан этгээдээс татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлдэг олон улсын туршлагыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Харин шилжүүлэн авсан этгээд нь татвар төлөгчтэй харилцан хамааралгүй бөгөөд уг хөрөнгөө цааш нь бусдад дамжуулан шилжүүлсэн бол энэхүү харилцаа хамаарахгүй.

6. Татвар төлөхөөс зайлсхийх явдлын эсрэг авах арга хэмжээг шинээр хуульчилна. Олон улсын туршлагаас харахад үндэстэн дамнасан корпорациуд татвар төлөх үүргээс зайлсхийх зорилгоор төрөл бүрийн арга замыг эрэлхийлж байна. Үүнээс гадна улс орнууд өөрсдийн татварын бааз сууриа хамгаалах зорилгоор татвар төлөхөөс зайлсхийхийн эсрэг арга хэмжээг дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, аливаа бизнес эрхлэгч нь Монгол Улсад хөрөнгө оруулахдаа бизнесийн зорилгогүйгээр татварын диваажин улсад цаасан дээрх компани байгуулж түүгээрээ дамжуулан үйл ажиллагааг удирдан явуулж байгаа нь манай улсын татварын суурь, татварын орлогыг багасгаж байна. Монгол Улс хууль ёсны дагуу хураах ёстой татвараа бүрэн авдаг байх, татварын сууриа хамгаалах зайлшгүй шаардлагаар энэхүү зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Түүнчлэн, одоо үйлчилж байгаа боловч зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай дараах зохицуулалт байна:

1. Татварын тайлангийн алдааг урьдчилан илрүүлж, татвар төлөгчид туслах үйл ажиллагааг нарийвчлан журамлах. Одоогийн хуулиар татвар ногдуулалтын хяналтыг татварын алба хэрхэн хэрэгжүүлэх, татвар төлөгчтэй харилцах журам тодорхойгүйгээс Татварын ерөнхий хуулийн татвар төлөгчид туслах үндсэн мөн чанар нь хэрэгжихгүй байна. Иймээс энэхүү зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийн төсөлд тодорхой үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж өгнө.

2. Үнэ шилжилтийн зарчмыг олон улсын стандартад нийцүүлж хуульчлах. Үнэ шилжилтийн талаарх зохицуулалт нь одоогийн хуульд ерөнхий байдлаар туссан байгаа нь өнөөдрийг хүртэл энэхүү заалт бүрэн утгаараа хэрэгжих боломжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үндэстэн дамнасан компаниуд нь харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийхдээ бодит бус үнэ хэрэглэх замаар Монгол Улсад төлөх татварын хэмжээг бууруулах явдал гардаг. Гэвч одоогийн хуулиар уг этгээдийн бусад улсуудад эрхэлж байгаа ажил гүйлгээний тайланг шаардах, түүнд дүн шинжилгээ хийх боломжгүй болгож байна. Иймд үнэ шилжилтийг бодитой тогтоох зорилгоор тусгайлсан тайлан авах, бусад улстай мэдээлэл солилцох асуудлыг хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

3. Татварын албаны хяналт шалгалтыг зөвхөн эрсдэлд үндэслэн хийх. Өнөөгийн үйлчилж байгаа хуулиар хяналт шалгалт нь төлөвлөгөөт бөгөөд энэ нь татварын улсын байцаагчийн хүсэл зоригоос тодорхой хэмжээгээр хамаарч байгаа нь зарим тохиолдолд аж ахуйн нэгжүүдэд дарамт учруулах, татварын албаны үргүй зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай байна. Иймд тогтсон төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бус татвар төлөгчийн эрсдэлийг тодорхой шалгуур, үзүүлэлтүүдээр гаргаж, татварын болон хөндлөнгийн мэдээллийн санд үндэслэн тооцож эрсдэлтэй гэж үнэлэгдсэн аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг явуулах нь зүйтэй байна.

4. Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг сунгах. Өнөөгийн хуулиар татварын өрийг хамгийн ихдээ 2 сараар хүндэтгэн үзэх шалтгааныг үндэслэн татварын албаны даргын тушаалаар сунгуулах боломжтой байдаг. Энэ хугацаа дуусмагц татварын албаны зүгээс татвар төлөгчийн дансыг хаах арга хэмжээг шууд авахаар зохицуулагдсан нь татвар төлөгчид өр барагдуулах хангалттай хэмжээний хугацааг олгохгүйгээр, татвар төлөгчийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулж, дарамт нэмэгдүүлдэг талаар ихээхэн шүүмжлэл дагуулдаг. Иймээс энэхүү хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор татвар төлөх энэхүү хугацааг тухайн татвар төлөгчид үүссэн нөхцөл байдалтай уялдуулан 2 жил хүртэлх хугацаагаар сунгах боломжийг хуульд тусгана.

5. Татварын албаны өр хураах ажиллагааны гүйцэтгэлийн эрх мэдлийг өөрчлөх. Татварын албаны хувьд маргах боломжгүй татварын өрийг шууд гаргуулах эрх хэмжээгүйгээс татвар төлөгч санаатайгаар төлбөрийн чадваргүй болох замаар татвар төлөх үүргээс зугтах, зайлсхийх эрсдэл маш өндөр байна. Тодруулбал, татварын алба дээрх үл маргах өрийг гаргуулахаар заавал шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлэх хуулийн заалттай байдаг. Харин шүүхээр дээрх өрийг гаргуулах зөвшөөрлийг өгөх хүртэл хугацаанд татварын өртэй этгээд өөрийн хөрөнгийг шилжүүлэх, зайлсхийх зохицуулалтыг хийж байгаа нь татварын алба уг өрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байх гол нөхцөл болж байна.

6. Маргаан таслах зөвлөлийн үе шатыг бууруулна. Татвар төлөгч татварын улсын байцаагчийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ талаар гомдлоо харьяалагдах татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлд гаргаж, хэрэв татвар төлөгч гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны маргаан таслах зөвлөлд дахин хянуулах зохицуулалттай байна. Энэ нь татвар төлөгчид үндсэндээ 2 шатны маргаан таслах зөвлөлөөр дамжиж, цаг хугацаа алдаж байгааг өөрчлөх шаардлагатай байна.

7. Татварын хяналт шалгалтаар тавих актыг давж заалдах гомдол гаргах журмыг тодорхой болгох. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн нийцлийг хангаж, маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэгдэх татварын нөхөн ногдуулалттай холбоотой зөрчлийг Татварын ерөнхий хуулиар зохицуулах нь зүйтэй байна. Одоогийн хүчин төгөлдөр хуулиуд нь татварын нөхөн ногдуулалттай холбоотой зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, гомдол гаргах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус, ойлгомжгүй байгааг өөрчилнө.

Татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураалтыг сайжруулах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай үр дүнтэй тэмцэх зорилгоор өнөөгийн мөрдөгдөж байгаа татварын хуулиудад туссан олон улсын татварын зохицуулалтуудыг шинэчлэх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх, татварын өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагааг үр дүнтэй хийх зайлшгүй шаардлага тулгараад байна. Тодруулбал, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд нь харилцан туслалцаа үзүүлж, мэдээлэл солилцох чиг үүрэгтэй боловч манай өнөөгийн эрх зүйн зохицуулалтаас болж мэдээлэл солилцох хүрээ, эрх хэмжээ тодорхойгүйгээс энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй байна.

Татварын албаны хүний нөөцийг илүү оновчтой удирдах, татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардлыг бууруулах үүднээс татварын хялбаршуулсан тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага байна. Түүнчлэн, татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэн хийх, татварын хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй, татвар төлөгчид чирэгдэл багатай хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж, татварын албаны хэрэгжүүлэх чиг үүрэг, татварын хяналт шалгалт, түүнд гомдол гаргах ажиллагаа нь хуулийн давхардмал зохицуулалтаас болж хэрэгжихэд хүндрэлтэй байна.

Хууль батлагдан гарснаар татвар төлөгч, татварын албаны эрх, үүргийн тэнцвэр хангагдаж, тэдгээрийн хооронд үүсдэг хууль хэрэглээтэй холбоотой маргаан буурах, улмаар татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардал буурна. Түүнчлэн, татварын алба татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, татвар төлөгчид чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

Нөгөө талаас, татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх зохицуулалтууд боловсронгуй болж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх боломжтой болно. Улмаар дунд болон урт хугацаанд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх суурь нөхцөлийг бий болгоно.

Хуулийг нэг мөр ойлгох хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хуулийг татварын алба, татвар төлөгчдөд хэрэгжүүлэхэд хялбар, харилцан ил тод болгохоор өөрчлөлтүүдийг оруулж өгсөн нь цаашид тус хуулийн хэрэгжилтийн шатанд үүсч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах үр нөлөөтэй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 89 дүгээр зүйлд татвар төлөгч болон татварын албаны хооронд үүсдэг маргааныг хянан шийдвэрлэх журмыг хуульчлах, одоо үйлчилж байгаа хуулийн хоёрдмол утга санаатай зохицуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор Татварын ерөнхий хуулийг шинэчлэн батлуулахаар холбогдох хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

Татварын ерөнхий хуульд туссан татвар төлөгчийн эрх үүрэг нь татварын албаны эрх үүрэгтэй харилцан урвуу хамааралтай байх ёстой боловч өнөөгийн мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжид татвар төлөгч, татварын албаны хоорондын эрх үүргийн тэнцвэр алдагджээ. Иймд Татварын ерөнхий хуульд туссан дээрх эрх, үүргийн тэнцвэрийг хангах зорилгоор холбогдох зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэх, тус хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай шинэ харилцааг хуульчлах нь зүйтэй байна. Түүнчлэн татварын хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой болгож, хуулийн давхардсан зохицуулалтыг арилгах нь зүйтэй байна. Тухайлбал, энэ хуулийн хүрээнд цоо шинээр бий болгох зохицуулалтаас дурдвал:

1. Татвар төлөгч сайн дурын үндсэн дээр тайлангаа засах эрхтэй болно. Татвар төлөгчийн татварын тайлангийн алдааг зөвхөн татварын хяналт шалгалт хийгдэж акт тавьсны дараа засварлах боломж үүсэж байгааг өөрчлөн татвар төлөгчид өөрөө тайлангаа засах боломжийг олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Одоогийн үйлчилж буй хуулийн хүрээнд татвар төлөгч татварын тайлангаа нэгэнт буруу гаргасан бол уг тайлангаа засварлах боломжгүй байдаг. Бусад улсуудын туршлагаас үзэхэд татвар төлөгч нь татварын тайлангийн алдаагаа засах боломжийг олгосон байдаг тул холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгана.

2. Татварын давуу эрхийн зарчмыг шинээр нэвтрүүлнэ. Татвар бол төрийн оршин тогтнох үндэс бөгөөд татварын орлогоор төрийн халамж, үйлчилгээг иргэдэд үзүүлж, эрүүл мэнд, боловсрол батлан хамгаалах зэрэг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд гол эх үүсвэр болдог. Энэ утгаараа татвар төлөх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний үндсэн үүрэг гэж заасан боловч энэхүү үүргийн хэрэгжилтийг хангах асуудлыг бусад салбар хуульд тодорхой заагаагүйгээс аливаа өр төлбөрөөс татварыг хэдийд гаргуулах талаар тодорхой дүрэм байдаггүй. Үүнээс шалтгаалан татварын өрийг бусад төрлийн авлага, хохирлыг барагдуулсны дараагаар гаргуулан авч байгаа нь зохимжгүй юм. Иймээс энэхүү шинэчлэлээр татварын өрийг

гаргуулахдаа хүний амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хорыг арилгуулах нэхэмжлэл болон аливаа барьцаат эрхийн дараа нь хураах нь зүйтэй байна.

3. Татварын зорилгоор бусад улсуудтай мэдээлэл харилцан солилцдог болно. Европын холбооны комиссоос 2017 онд анх удаа гаргасан “Татварын зорилгоор хамтарч ажилладаггүй бүс нутгуудийн жагсаалт”-д Монгол Улсыг оруулсан нь цаашид хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр байсан. Иймд Засгийн газрын 2017 оны 350 дугаар тогтоолын дагуу Монгол Улс 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Татварын зорилгоор мэдээлэл солилцоо, ил тод байдлын олон улсын форумд элсэн орсон. Энэхүү форумд элсэн орсноор цаашид татварын зорилгоор бусад улстай мэдээлэл солилцох хамтран ажиллах томоохон боломж бий болж байгаа хэдий ч энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор татварын хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Иймд тус байгууллагаас тавигддаг мэдээлэл солилцоо, ил тод байдал, мэдээллийн нууцлалтай холбоотой шаардлагуудыг хуулийн төсөлд тусгах болно.

4. Эрсдэлтэй татварыг урьдчилан хураана. Одоогийн үйлчилж буй хуулийн зохицуулалтаар ногдуулах татварын хэмжээ нь тодорхой болсон татвар төлөгч нь татвар төлөхөөс зугтах, эсхүл зугтахыг оролдох зэргээр татварын өр хураах үйл ажиллагаанаас зайлсхийх бодитой эрсдэл учирдаг. Энэ үед Татварын алба тодорхой арга хэмжээг авч чадалгүй татварын орлогоо алдах явдал түгээмэл байна. Өөрөөр хэлбэл, татвар төлөгч татварын тайлан гаргахдаа татварын ногдлоо өөрөө тодорхойлсон боловч татвар төлөх хугацаа нь болоогүй байхад уг хуулийн этгээд нь татан буугдах бол татварын албанд ямар ч эрх хэмжээ байдаггүй. Иймд тодорхой эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд татварыг урьдчилан хураадаг зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

5. Татвар төлөгч татварын өрөө төлөлгүй хөрөнгөө бусдад шилжүүлэх бол үг этгээдээс татварын өрийг төлүүлнэ. Зарим тохиолдолд татвар төлөгч нь өөрийн хөрөнгө, үйл ажиллагаагаа үнэгүйдүүлж бусдад хэт бага үнээр, эсхүл үнэгүй шилжүүлснээр татварын өр төлөх чадваргүй болж татвар төлөх үүргээс зайлсхийж байна. Иймд татварын өрийг тэрхүү бусдад шилжүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны хэмжээнээс хамааруулж уг шилжүүлж авсан этгээдээс татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлдэг олон улсын туршлагыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Харин шилжүүлэн авсан этгээд нь татвар төлөгчтэй харилцан хамааралгүй бөгөөд уг хөрөнгөө цааш нь бусдад дамжуулан шилжүүлсэн бол энэхүү харилцаа хамаарахгүй.

6. Татвар төлөхөөс зайлсхийх явдлын эсрэг авах арга хэмжээг шинээр хуульчилна. Олон улсын туршлагаас харахад үндэстэн дамнасан корпорациуд татвар төлөх үүргээс зайлсхийх зорилгоор төрөл бүрийн арга замыг эрэлхийлж байна. Үүнээс гадна улс орнууд өөрсдийн татварын бааз сууриа хамгаалах зорилгоор татвар төлөхөөс зайлсхийхийн эсрэг арга хэмжээг дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, аливаа бизнес эрхлэгч нь Монгол Улсад хөрөнгө оруулахдаа бизнесийн зорилгогүйгээр татварын диваажин улсад цаасан дээрх компани байгуулж түүгээрээ дамжуулан үйл ажиллагааг удирдан явуулж байгаа нь манай улсын татварын суурь, татварын орлогыг багасгаж байна. Монгол Улс хууль ёсны дагуу хураах ёстой татвараа бүрэн авдаг байх, татварын сууриа зайлшгүй шаардлагаар энэхүү зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Түүнчлэн, одоо үйлчилж байгаа боловч зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай дараах зохицуулалт байна:

1. Татварын тайлангийн алдааг урьдчилан илрүүлж, татвар төлөгчид туслах үйл ажиллагааг нарийвчлан журамлах. Одоогийн хуулиар татвар ногдуулалтын хяналтыг татварын алба хэрхэн хэрэгжүүлэх, татвар төлөгчтэй харилцах журам тодорхойгүйгээс Татварын ерөнхий хуулийн татвар төлөгчид туслах үндсэн мөн чанар нь хэрэгжихгүй байна. Иймээс энэхүү зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийн төсөлд тодорхой үйл ажиллагааны зохицуулалтыг тусгаж өгнө.

2. Үнэ шилжилтийн зарчмыг олон улсын стандартад нийцүүлж хуульчлах. Үнэ шилжилтийн талаарх зохицуулалт нь одоогийн хуульд ерөнхий байдлаар туссан байгаа нь өнөөдрийг хүртэл энэхүү заалт бүрэн утгаараа хэрэгжих боломжгүй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа томоохон үндэстэн дамнасан компаниуд нь харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийхдээ бодит бус үнэ хэрэглэх замаар Монгол Улсад төлөх татварын хэмжээг бууруулах явдал гардаг. Гэвч одоогийн хуулиар уг этгээдийн бусад улсуудад эрхэлж буй ажил гүйлгээний тайланг шаардах, түүнд дүн шинжилгээ хийх боломжгүй болгож байна. Иймд үнэ шилжилтийг бодитой тогтоох зорилгоор тусгайлсан тайлан авах, бусад улстай мэдээлэл солилцох асуудлыг хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

3. Татварын албаны хяналт шалгалтыг зөвхөн эрсдэлд үндэслэн хийх. Өнөөгийн үйлчилж буй хуулиар хяналт шалгалт нь төлөвлөгөөт бөгөөд энэ нь татварын улсын байцаагчийн хүсэл зоригоос тодорхой хэмжээгээр хамаарч байгаа нь зарим тохиолдолд аж ахуйн нэгжүүдэд дарамт учруулах, татварын албаны үргүй зардлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай байна. Иймд тогтсон төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бус татвар төлөгчийн эрсдэлийг тодорхой шалгуур, үзүүлэлтүүдээр гаргаж, татварын болон хөндлөнгийн мэдээллийн санд үндэслэн тооцож эрсдэлтэй гэж үнэлэгдсэн аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг явуулах нь зүйтэй байна.

4. Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг сунгах. Өнөөгийн хуулиар татварын өрийг хамгийн ихдээ 2 сараар хүндэтгэн үзэх шалтгааныг үндэслэн татварын албаны даргын тушаалаар сунгуулах боломжтой байдаг. Энэ хугацаа дуусмагц татварын албаны зүгээс татвар төлөгчийн дансыг хаах арга хэмжээг шууд авахаар зохицуулагдсан нь татвар төлөгчид өр барагдуулах хангалттай хэмжээний хугацааг олгохгүйгээр, татвар төлөгчийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулж, дарамт нэмэгдүүлдэг ихээхэн шүүмжлэл дагуулдаг. Иймээс энэхүү хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор татвар төлөх энэхүү хугацааг тухайн татвар төлөгчид үүссэн нөхцөл байдалтай уялдуулан 2 жил хүртэлх хугацаагаар сунгах боломжийг хуульд тусгана.

5. Татварын албаны өр хураах ажиллагааны гүйцэтгэлийн эрх мэдлийг өөрчлөх. Татварын албаны хувьд маргах боломжгүй татварын өрийг шууд гаргуулах эрх хэмжээгүйгээс татвар төлөгч санаатайгаар төлбөрийн чадваргүй болох замаар татвар төлөх үүргээс зугтах, зайлсхийх эрсдэл маш өндөр байна. Тодруулбал, татварын алба дээрх үл маргах өрийг гаргуулахаар заавал шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлэх хуулийн заалттай байдаг. Харин шүүхээр дээрх өрийг гаргуулах зөвшөөрлийг өгөх хүртэл хугацаанд татварын өртэй этгээд өөрийн хөрөнгийг шилжүүлэх, зайлсхийх зохицуулалтыг хийж байгаа нь татварын алба уг өрийг бүрэн төвлөрүүлж чадахгүй байх гол нөхцөл болж байна.

6. Маргаан таслах зөвлөлийн үе шатыг бууруулж, төрийн шат дамжлагыг бууруулна. Татвар төлөгч татварын улсын байцаагчийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрөөгүй бол энэ талаар гомдлоо харьяалагдах татварын албаны дэргэдэх маргаан таслах зөвлөлд гаргаж, хэрэв татвар төлөгч гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд дээд шатны маргаан таслах зөвлөлд дахин хянуулах

зохицуулалттай байна. Энэ нь татвар төлөгчид үндсэндээ 2 шатны маргаан таслах зөвлөлөөр дамжиж, цаг хугацаа алдаж байгааг өөрчлөх шаардлагатай байна.

7. Татварын хяналт шалгалтаар тавих актыг давж заалдах гомдол гаргах журмыг тодорхой болгох. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Татварын ерөнхий хуулийн нийцлийг хангаж, маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэгдэх татварын нөхөн ногдуулалттай холбоотой зөрчлийг Татварын ерөнхий хуулиар зохицуулах нь зүйтэй байна. Одоогийн хүчин төгөлдөр хуулиуд нь татварын нөхөн ногдуулалттай холбоотой зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, гомдол гаргах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхой бус, ойлгомжгүй байгааг өөрчилнө.

Татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураалтыг сайжруулах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай үр дүнтэй тэмцэх зорилгоор өнөөгийн мөрдөгдөж буй татварын хуулиудад туссан олон улсын татварын зохицуулалтуудыг шинэчлэх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх, татварын өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагааг үр дүнтэй хийх зайлшгүй шаардлага тулгараад байна. Тодруулбал, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд нь харилцан туслалцаа үзүүлж, мэдээлэл солилцох чиг үүрэгтэй боловч манай өнөөгийн эрх зүйн зохицуулалтаас болж мэдээлэл солилцох хүрээ, эрх хэмжээ тодорхойгүйгээс энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөлтэй байна.

Татварын албаны хүний нөөцийг илүү оновчтой удирдах, татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардлыг бууруулах үүднээс татварын хялбаршуулсан тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага байна. Түүнчлэн, татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэн хийх, татварын хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй, татвар төлөгчид чирэгдэл багатай хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж, татварын албаны хэрэгжүүлэх чиг үүрэг, татварын хяналт шалгалт, түүнд гомдол гаргах ажиллагаа нь хуулийн давхардмал зохицуулалтаас болж хэрэгжихэд хүндрэлтэй байна.

Иймд дээр дурдсан бүхий л үндэслэл, шаардлагаас болж татварын хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Хоёр. Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь татвар төлөгч, татварын албаны хооронд үүсэх татвартай холбогдсон харилцаанд баримтлах ерөнхий зарчим, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл үндсэн ерөнхий 2 анги, 14 бүлэг 87 зүйлээс бүрдэнэ. Үүнд:

➢ Хуулийн төслийн нэгдүгээр бүлгээр хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, татвар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох, нэр томьёо, татварын зарчим;

➢ Хуулийн төслийн хоёрдугаар бүлгээр албан татвар, төлбөр, хураамжийн тодорхойлолт, татвар ногдох зүйл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын хялбаршуулсан горим;

➤ Хуулийн төслийн гуравдугаар бүлгээр татвар төлөгчийн эрх, татвар төлөгчийн нууцлалын баталгаа, татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих, татварын хөөн хэлэлцэх хугацаа;

➤ Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлгээр татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээ, харилцан тохирох журам, гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам;

➤ Хуулийн төслийн тавдугаар бүлгээр татварын албанаас хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа, татварын алба мэдээ, мэдээлэл баримт цуглуулах үйл ажиллагаа, байр агуулахад нэвтрэн орох, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх;

➤ Хуулийн төслийн зургадугаар бүлгээр татвар төлөгчийн бүртгэл, татвар төлөгчийг бүртгэх нийтлэг журам, харилцан хамааралтай этгээд, татвар ногдуулалт, төлөлт, татварын тайлан үйлдэх, тушаах, татварын тайлан хүлээн авах, боловсруулалт хийх, татварын тайланд залруулга хийх;

➤ Хуулийн төслийн долдугаар бүлгээр татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, татварын мэдээллийн нэгдсэн санг хөтлөх үйл ажиллагаа, татварын албаны хөндлөнгийн мэдээллийн сан;

➤ Хуулийн төслийн наймдугаар бүлгээр татварын албаны эрсдэлийн удирдлага, татварын ногдлыг тодорхойлох боломжгүй тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ, үнэ шилжилтийн талаарх ерөнхий зарчим, үнэ шилжилтийн тайлан, үнэ шилжилтийн тохируулга хийх, үнэ шилжилтийн тохируулга хийх аргачлал;

➤ Хуулийн төслийн есдүгээр бүлгээр татварын хяналт, шалгалт, нөхөн ногдуулалтын акт, нөхөн ногдуулалтын актад гомдол гаргах, татварын хяналт, шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэх, НӨАТ-ын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт, шалгалт;

➤ Хуулийн төслийн аравдугаар бүлгээр маргаан таслах зөвлөл, маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх;

➤ Хуулийн төслийн арван нэгдүгээр бүлгээр татвар ногдуулалт, төлөлтийн бүртгэл, татварыг буцаан олгох, суутган тооцох, татварын өр, татварын нэхэмжлэх, татварын өр төлөх дараалал, татвар төлөх хугацааны хөнгөлөлт, эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагаа;

➤ Хуулийн төслийн арван хоёрдугаар бүлгээр татварын өр хураах үйл ажиллагаа, татварын давуу эрхийн зарчим, хоёрдогч этгээдийн татвар төлөх үүрэг, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр хураах нийтлэг журам, татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох, хөрөнгө битүүмжлэхэд баримтлах зарчим, битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого, хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасны битүүмжлэл, татварын өрийг үл маргах журмаар гаргуулах үйл ажиллагаа, авлагын битүүмжлэл, үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжлэл, биет бус хөрөнгийн битүүмжлэл, битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх, татварын өр хураахаар бусад байгууллагад суутгах хүсэлт гаргах, мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилах, татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бусад хуульд заасан эрх хязгаарлах, түдгэлзүүлэх арга хэмжээ авах, татварын албаны үндэслэлгүй хураасан мөнгөн хөрөнгө, алданги;

➤ Хуулийн төслийн арван гуравдугаар бүлгээр Монголын татварын алба, татварын улсын байцаагчийн баталгаа, татварын албаны чиг үүрэг, татвар төлөгчид

зөвлөгөө мэдээлэл өгөх, татварын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, Татварын албаны үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, хориглох зүйл, Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх, Татварын алба, татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичиг;

➤ Хуулийн төслийн арван дөрөвдүгээр бүлгээр татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх, төлөх татварын хэмжээг бууруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага, татвар суутгах үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, татварын улсын байцаагчийн хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тус тус тусгасан болно.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хууль батлагдан гарснаар татвар төлөгч, татварын албаны эрх, үүргийн тэнцвэр хангагдаж, тэдгээрийн хооронд үүсдэг хууль хэрэглээтэй холбоотой маргаан буурах улмаар татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардал буурна. Түүнчлэн, татварын алба татвар хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, татвар төлөгчид чирэгдэл багатай, эрсдэлд суурилсан байдлаар хийж гүйцэтгэх нөхцөл бүрдэнэ.

Нөгөө талаас, татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай тэмцэх зохицуулалтууд боловсронгуй болж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх боломжтой болно. Улмаар дунд болон урт хугацаанд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн үйл ажиллагааг дэмжих, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх суурь нөхцөлийг бий болгоно.

Хуулийг нэг мөр ойлгох хүрээнд хоёрдмол утга бүхий зохицуулалтыг засах замаар хуулийн хийдлийг арилган, хуулийг татварын алба, татвар төлөгчдөд хэрэгжүүлэхэд хялбар, харилцан ил тод болгохоор өөрчлөлтүүдийг оруулж өгсөн нь цаашид тус хуулийн хэрэгжилтийн шатанд үүсч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах үр нөлөөтэй.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг нөлөө байхгүй.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулсан болно. Хуулийн төсөлтэй хамт Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дампуурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ (шинэчилсэн найруулга)

I ХЭСЭГ ЕРӨНХИЙ АНГИ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба (цаашид “Татварын алба” гэх), татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Татварын хууль тогтоомж

2.1.Татварын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль , энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь татвар төлөгч, татварын алба болон татварын хууль тогтоомжийн дагуу түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдэд хамаарна.

3.2.Энэ хуулиар зохицуулаагүй, эсхүл энэ хуульд зааснаас өөрөөр татварын бусад хуульд заасан бол тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан татварын хуулийн зүйл, хэсэг, заалт давуу үйлчилнэ.

3.3.Энэ хуулийн 3.2-т заасны дагуу тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хууль, зүйл, хэсэг, заалтыг тодорхойлох боломжгүй бол аль сүүлд батлагдсан хууль, зүйл, хэсэг, заалтыг баримтална.

4 дүгээр зүйл. Татвар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох

4.1.Доор дурдсанаас бусад тохиолдолд татварыг зөвхөн Улсын Их Хурал татварын хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй:

4.1.1.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны дагуу тогтворжуулах;

4.1.2.чөлөөт бүсэд мөрдөгдөх татварын тусгай дэглэмийг Чөлөөт бүсийн тухай хуулиар тогтоож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг холбогдох татварын хуулиар зохицуулах.

4.2.Засгийн газар болон аймаг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал татварын хувь, хэмжээг тухайн төрлийн татварын хуульд заасан дээд, доод хязгаарт багтаан тогтоож болно.

4.3.Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээг өөрчлөхтэй холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн хуулийн төсөлтэй хамт боловсруулна.

5 дугаар зүйл.Татварын зарчим

5.1.Татварын хууль тогтоомж боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд зайлшгүй байх, тодорхой байх, шударга байх, татварын нэгдсэн тогтолцоо бүхий, ил тод, үр ашигтай байх дараахь зарчимд үндэслэнэ.

5.1.1.татвар төлөгч татвараа хугацаанд нь тайлагнаж, бүрэн төлдөг байх;

5.1.2.татвар ногдуулах, төлөх, суутган төлөх, тайлагнах дараалал тодорхой байх;

5.1.3.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх;

5.1.4.татвар төлөгчийг ялгаварлахгүй байх;

5.1.5.татвар төлөгчид нээлттэй татварын хууль тогтоомжийн нэгдсэн сантай байх;

5.1.6.татварын өр хураах, татвар төлөх зардал хамгийн бага байх.

6 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

6.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

6.1.1.“ажил гүйлгээний ашиг хуваах арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний ашгийг эдийн засгийн үндэслэлтэй хувааж, түүнтэй харьцуулагдахуйц бие даасан ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.2.“ажил гүйлгээний цэвэр ашгийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшингийн үзүүлэлтүүдийг түүнтэй харьцуулагдахуйц

бие даасан ажил гүйлгээний цэвэр ашгийн түвшингийн үзүүлэлтүүдтэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.3.“ажлын өдөр” гэж долоо хоногийн Бямба, Ням гараг болон нийтээр тэмдэглэх баярын өдрөөс бусад өдрийг;

6.1.4.“албадан гүйцэтгэх ажиллагаа” гэж шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, барьцааны эрхээс барьцаа гаргуулах, татвар төлөгчтэй холбоотой дампуурлын хэрэг үүсгэх, татварын өр хураах үйл ажиллагааг;

6.1.5.“албан татвар” гэж хууль тогтоомжийн дагуу аливаа этгээдийн орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, хариу төлбөргүйгээр төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.6. “бодит үнэ тодорхойлох зарчим” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөлийг түүнтэй ижил нөхцөлөөр хийх харилцан хамааралгүй этгээд хоорондын хийсэн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахыг;

6.1.7.“бодит үнийн арга” гэж бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу харилцан хамаарал бүхий этгээд хооронд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний үнийг тодорхойлохыг;

6.1.8.“групп” гэж санхүүгийн тайлагналын зорилгоор нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, эсхүл аль нэг аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, өмчлөл болон удирдлагын хувьд хамааралтай аж ахуйн нэгжүүдийг;

6.1.9.“дамжуулан борлуулах үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй борлуулалтын орлогын хувьд харьцуулагдахуйц бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.10.“дотоод харьцуулалт хийх ажил гүйлгээ” гэж татвар төлөгчийн харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээ болон бие даасан этгээдтэй хийсэн ажил гүйлгээг;

6.1.11.“жишиг үнийн арга” гэж татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагаа, орлого, зарлагын болон бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг, тийм татвар төлөгч байхгүй бол татварын алба өөрт байгаа мэдээллийг үндэслэн татварын ногдлыг шууд бусаар тодорхойлохыг;

6.1.12.“итгэмжлэгдсэн төлөөлөгч” гэж татвар төлөгчийн эрх ашгийг итгэмжлэл болон гэрээний үндсэн дээр төлөөлж, татварын албатай харилцах эрх, үүрэг бүхий итгэмжлэгдсэн этгээд, Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд заасан татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч болон мэргэшсэн зөвлөхийг;

6.1.13.“нөхөн ногдуулалт” гэж энэ хуульд заасны дагуу гүйцэтгэсэн татварын хяналт шалгалтын дүнд үндэслэн татварын албанаас тодорхойлсон татварын дүнг;

6.1.14. “нөхөн ногдуулалтын акт” гэж татварын албанаас тодорхойлсон нөхөн ногдуулалт, торгууль, алдангийн дүнг тусгасан татвар төлөгчид хүргүүлэх баримт бичгийг;

6.1.15. “нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт” гэж Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд зааснаар албан татвар суутган төлөгчийн татварын ногдуулалт, төлөлтийг татварын алба хянан, баталгаажуулсан баримт бичгийг;

6.1.16. “оршин суугчийн гэрчилгээ” гэж татвар төлөгчийг тухайн татварын жилийн хувьд тус улсын оршин суугч татвар төлөгч мөн болохыг нотолж тухайн улсын татварын албанаас тогтсон загварын дагуу үйлдсэн баримт бичгийг;

6.1.17. “өртөг дээр нэмэх арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний нийт ашгийн түвшинг түүнтэй зардлын хувьд харьцуулагдахуйц бие даасан ажил гүйлгээний нийт ашгийн түвшинтэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.18. “схем” гэж татварын ашиг хүртэх үндсэн зорилгоор хэрэгжүүлэх татвараас зайлсхийх үйл ажиллагааг;

6.1.19. “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг;

6.1.20. “татвар төлөгч” гэж татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх, эсхүл суутгах үүрэг бүхий татвар суутган төлөгч этгээдийг;

6.1.21. “татвар төлөгчийн гэрчилгээ” гэж татварын албаны бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас татвар төлөгчид олгосон, татвар төлөгчийн дугаартай, татварын төрлийн мэдээллийг тусгасан тусгай нууцлалын кодоор баталгаажсан, цахим болон цаасан баримт бичгийг;

6.1.22. “татвар төлөгчийн дугаар” гэж татварын албанаас татвар төлөгчид олгосон татвар төлөгчийн бүртгэлийн нэгдсэн системийн дахин давтагдашгүй дугаарыг;

6.1.23. “татвар төлөх үүрэг бүхий хоёрдогч этгээд” гэж татварын өрийг татвар төлөгчөөс хураах боломжгүй бөгөөд уг татвар төлөгчтэй үйл ажиллагаа, хөрөнгийн хувьд хамааралтай хуульд заасан нөхцөл, шаардлага хангасан татвар төлөх үүрэг бүхий этгээдийг;

6.1.24. “татвар төлөхөөс зугтах” гэж татвар төлөгч татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл нуух зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэхүйг;

6.1.25. “татвараас зайлсхийх арга хэмжээ” гэж татварын ногдлыг бууруулах, татварын суурь багасгах, эсхүл алдагдлыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан нөхцөлийг бүрдүүлж байгаа Монгол Улсын татвар төлөгчийн өөр бусад этгээдүүдтэй үүсгэх харилцааг;

6.1.26. “татварын алба” гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг нийслэл дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг;

6.1.27. “татварын акт” гэж татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, татварын буцаан олголтын актыг хамтад нь;

6.1.28. “татварын буцаан олголтын акт” гэж татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөн дүнд алданги тооцож олгоход үйлдэх баримт бичгийг;

6.1.29. “татварын жил” гэж хуанлийн жилийг;

6.1.30. “татварын тайлан” гэж татварын албанаас баталсан маягтын дагуу татвар төлөгчийн бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан татварын суурь, албан татвар, төлбөр, хураамжийн ногдлын хэмжээг тодорхойлж , тайлагнах хуудсыг;

6.1.31. “татварын улсын байцаагч” гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээх авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;

6.1.32. “татварын өр хураах зардал” гэж татварын өр барагдуулах үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн битүүмжлэл, суутгалын хүсэлт, битүүмжилсэн хөрөнгийн хадгалалт, тээвэрлэлт, дуудлага худалдаа явуулах, үнэт цаас болон биет бус хөрөнгийн эрхийг хураах, хуваарилахтай холбоотой гарсан зардлыг;

6.1.33. “татварын хялбаршуулсан горим” гэж татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааны нийлбэр цогцыг;

6.1.34. “татварын суурь” гэж тодорхой дүн, эсхүл хувиар татварын ногдлыг тодорхойлох орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдлыг мөнгөн дүнгээр илэрхийлсэн дүнг;

6.1.35. “татварын цахим баримт бичиг” гэж татварын хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр боловсруулсан, хадгалсан, илгээсэн, хүлээн авсан, цахим гарын үсгээр баталгаажсан баримт бичгийн иж бүрдлийг;

6.1.36. “тодорхой бизнесийн зорилгогүй татварын үйлдэл” гэж төлөх татварын хэмжээг багасгах, татвар төлөхөөс зайлсхийх болон татвар төлөх хугацааг хойшлуулсан ажил гүйлгээ хийх, төлөвлөн гүйцэтгэх татвар төлөгчийн үйлдлийг;

6.1.37. “төлбөр” гэж төрийн өмчийн газар, газрын хэвлий, байгалийн баялаг, ой, ургамал, рашаан, ашигт малтмал, газрын тосны нөөц, агаар, ус, хөрс ашигласны, бохирдуулсны, ан амьтан агнасны төлөө аливаа этгээдээс авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.38. “харьцуулагдах байдлын шинжилгээ” гэж харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний нөхцөлийг харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд хийсэн ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулан ялгаатай хүчин зүйлсийн нөлөө, зөрүүг арилгаж үнэн зөв залруулга хийх шинжилгээний аргыг;

6.1.39. “харьцуулагдах хяналтаас гадуурх үнийн арга” гэж хяналтад байгаа ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлсийг түүнтэй харьцуулагдахуйц, бие даасан ажил гүйлгээний үнэ болон үнэд нөлөөлөгч хүчин зүйлстэй харьцуулан тодорхойлохыг;

6.1.40. “харьцуулалтын тохируулга хийх” гэж бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу үнийг тодорхойлох явцад бодит зөрүү гарсан бол шууд бус аргаар тогтоох үнэ, эсхүл нөхцөлд тохируулга хийхийг;

6.1.41. “хураагч” гэж татварын улсын байцаагчийн нөхөн ногдуулалт хийх, хяналт шалгалт хийхээс бусад чиг үүргийг хэрэгжүүлж байгаа татварын албаны ажилтанг;

6.1.42. “хураамж” гэж төрийн байгууллагаас аливаа этгээдэд хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч төсөвт төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг;

6.1.43. “хүндэтгэн үзэх шалтгаан” гэж:

6.1.43.а. эмнэлгийн өвчтөний гар картад бичигдсэн бөгөөд лаборатори болон багажийн шинжилгээгээр эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдож эмчийн заавраар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа бол;

6.1.43.б. асран хамгаалагч зайлшгүй шаардлагатай талаарх эмнэлгийн байгууллагын магадалгаа бүхий энэ хуулийн 6.1.43.а-д заасны дагуу эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай өвчтөнг асарсан бол;

6.1.43.в. хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан;

6.1.43.г. хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон;

6.1.43.д. хуульд заасан эрх бүхий этгээдээс албан ёсоор зарласныг нотолсон галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг;

6.1.44. “хяналтад байгаа ажил гүйлгээ” гэж харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээг;

6.1.45. “хяналтаас гадуурх ажил гүйлгээ” гэж харилцан хамааралгүй этгээд хооронд хийсэн ажил гүйлгээг;

6.1.46. “цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1, 4.1.2-т заасныг;

6.1.47.“эдийн засгийн өгөөж олох” гэж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зардал хэмнэх, хүлээн авагчийн үйл ажиллагааны зардал, хугацааг багасгах замаар ашиг буюу ашигт ажиллагааг дээшлүүлсэн байхыг;

6.1.48.“эсэргүүцэл үзүүлсэн” гэж татварын улсын байцаагч, хураагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэж эсэргүүцсэн, дарамталсан санаатай үйлдэл, эс үйлдлийг;

6.1.49.“этгээд” гэж хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага болон тэдгээртэй адилтгах иргэний харилцаанд оролцогчийг;

6.1.50.“эцсийн эзэмшигч” гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТАТВАР

7 дугаар зүйл.Монгол Улсын татвар

7.1.Монгол Улсын татвар нь албан татвар, төлбөр, хураамж /цаашид “татвар” гэх/-аас бүрдэнэ.

8 дугаар зүйл.Татвар ногдох зүйл

8.1.Татвар ногдох зүйлд орлого, хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол зэрэг зүйл хамаарна.

8.2.Татвар ногдох зүйлийг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

9 дүгээр зүйл.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

9.1.Татварын алба татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг татвар төлөгчид дараахь хэлбэрээр эдлүүлнэ:

9.1.1.ногдуулсан татварыг хорогдуулах;

9.1.2.татварын хувь, хэмжээг бууруулах;

9.1.3.тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;

9.1.4.татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;

9.1.5.татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;

9.1.6.татварын хууль тогтоомжоор заасан бусад.

9.2.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх

үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл. Татварын хялбаршуулсан горим

10.1.Татварын алба, татвар төлөгч татварын хялбаршуулсан горимыг ашиглаж болно.

10.2.Татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгч нь татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.

10.3.Хуульд өөрөөр заагаагүй бол татварын хялбаршуулсан горимыг зөвхөн татварын жилээр тооцох бөгөөд тухайн татварын жилийн дундуур уг горимоос шилжихийг хориглоно.

10.4.Татварын хялбаршуулсан горимыг хэрэгжүүлэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ

11 дүгээр зүйл.Татвар төлөгчийн эрх

11.1.Татвар төлөгч дараахь эрх эдэлнэ:

11.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхтэй холбогдсон мэдээлэл, зөвлөгөө, чиглэл, татвар ногдуулах, төлөх, тайлагнах журам, аргачлал, маягтыг татварын алба, татварын улсын байцаагчаас авах;

11.1.2.татварын хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;

11.1.3.хууль тогтоомжийн дагуу татвар төлөх хугацааг сунгуулах;

11.1.4.илүү төлсөн татварыг буцаан авах, суутган тооцуулах, алданги тооцон нэхэмжлэн авах;

11.1.5.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, төлөөлүүлэх, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах;

11.1.6.татварын албанаас гаргасан татварын акт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо захиргааны болон шүүхийн журмаар гаргах;

11.1.7.татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

11.1.8.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг татварын алба, татварын улсын байцаагчаас шаардах, татварын албаны хууль бус шийдвэр, үйлдлийн улмаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

11.1.9.татварын алба, татварын улсын байцаагчийн хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаар гомдлоо түүнийг шууд захирдаг болон дээд шатны албан тушаалтанд, түүнчлэн шүүхэд гаргах. Ийнхүү гомдол гаргасан нь ногдуулсан татвар, торгууль, алдангийг төлөхийг зогсоох үндэслэл болохгүй;

11.1.10.татварын хууль тогтоомжоор ногдсон үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн итгэмжлэгдсэн нягтлан бодогч, татварын зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах;

11.1.11.хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан бол уг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд хувь, хэмжээг нь тогтворжуулсан татварыг тогтворжуулсан хувь, хэмжээнээс илүү хэмжээгээр төлөхгүй байх;

11.1.12.хууль тогтоомжид заасан бусад эрх.

11.2.Татварын алба энэ хуулийн 11.1.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор хяналт шалгалтад хамруулах эрсдэлийн үнэлгээний нарийвчилсан үзүүлэлтийг татвар төлөгчид мэдээлэхгүй.

12 дугаар зүйл. Нууцлалын баталгаа

12.1.Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахгүй.

12.2.Татварын алба, татварын улсын байцаагч, татварын албаны бусад ажилтан болон татварын албанд ажиллаж байсан этгээд, татварын албаны хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн татвар төлөгчийн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд доор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

12.2.1.татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын улсын байцаагч;

12.2.2.татварын хууль тогтоомж зөрчсөн зөрчил, гэмт хэргийг бүртгэх шалгах, хянах, шийдвэрлэх үүрэг хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгчид зөвхөн уг зөрчил, гэмт хэрэгт холбогдох асуудлаар;

12.2.3.олон улсын гэрээний дагуу харилцан мэдээлэл солилцох зорилгоор томилогдсон буюу сонгогдсон эрх бүхий албан тушаалтанд гэрээтэй холбоотой мэдээлэл солилцох асуудлаар.

12.3.Татвар төлөгч зөвшөөрсөн, эсхүл хууль болон сонгон шалгаруулалтын шаардлагаар олон нийтэд мэдээлэх татвар төлөгчийн нэр, дугаар, төлсөн татварын мэдээлэл, статистикийн зорилгоор татварын албанд нэгтгэсэн нэгдсэн тайлан, мэдээ энэ хуулийн 12.1-д хамаарахгүй.

12.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаанд зөрчлөө арилгаагүй, нэг зөрчлийг гурав болон

түүнээс дээш удаа давтан гаргасан, эсхүл эрэн сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.

12.5.Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн нууц мэдээллийн санд нэвтрэх эрхтэй татварын улсын байцаагчийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр томилж, тэдгээрийн мэдээллийн санд нэвтрэх болон мэдээлэл ашиглалтын байдлыг бүртгэж ажиллана.

13 дугаар зүйл.Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих

13.1.Татвар төлөх үүрэг дараахь тохиолдолд дуусгавар болно:

13.1.1.тухайн төрлийн татварын өрийг төлж дууссан;

13.1.2.бусад татварын илүү төлөлтийг тухайн төрлийн татварын өрд суутган тооцсон;

13.1.3.татвар төлөгч тухайн төрлийн татвараас хуулиар чөлөөлөгдсөн;

13.1.4.тухайн төрлийн татварын хууль хүчингүй болж татварын өрийг төлж дууссан;

13.1.5.нас барсан болон нас барсанд тооцогдсон татвар төлөгч хувь хүн нь өв залгамжлагчгүй, эсхүл өвлүүлэх хөрөнгөгүй нь шүүхээр тогтоогдсон.

13.2.Хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд татан буулгах комисс, дампуурсан тохиолдолд хэрэг гүйцэтгэгч төлөөгүй татварыг хуулийн этгээдийн хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж холбогдох төсөвт төлнө.

13.3.Хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон эрх, үүрэг өөрчлөн байгуулагдсаны үр дүнд бий болсон хуулийн этгээдэд шилжинэ.

13.4.Хуулийн этгээдийг тусгаарлах, хуваах замаар өөрчлөн байгуулсан тохиолдолд татвар ногдох зүйл, хуваарилагдсан хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн татвар ногдох үүрэг тэдгээрт шилжинэ.

13.5.Татан буугдаж байгаа хуулийн этгээдийг энэ хуулийн дагуу эрсдэлтэй гэж тооцсон тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулна.

13.6.Нас барсан болон нас барсанд тооцогдсон хувь хүний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь өвлөсөн хөрөнгөнд ногдох хэмжээгээр шилжих бөгөөд үүнд татварын торгууль хамаарахгүй.

14 дүгээр зүйл.Татварын хөөн хэлэлцэх хугацаа

14.1.Татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байх бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй.

14.2.Татвар, алданги, торгуулийн өр төлөх болон энэ хуулийн 12 дугаар бүлэгт заасан татварын өр хураах журам, түүнчлэн татвар төлөгчид гаргасан хүсэлтийнх нь дагуу төлсөн татварыг буцаан олгохтой холбогдсон харилцаанд энэ хуулийн 14.1-д заасан хугацаа хамаарахгүй.

14.3.Энэ хуулийн 14.1-д заасан хугацааг дараахь байдлаар тоолно:

14.3.1.тайлант жилийн эцэст нэг удаа гаргаж, татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд уг тайланг гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

14.3.2.тайланг сар, улирлаар гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс;

14.3.3.борлуулалт хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дотор татвар төлөхөөр хуульд заасан татварын төрөл болон суутгаж төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын тайлан гаргах өдрийн дараагийн өдрөөс;

14.3.4.тайлан гаргахгүй төлдөг татварын хувьд тухайн төрлийн хуульд заасан татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс.

14.4.Татвар төлөгч татварын асуудлаар маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан, хууль хяналтын байгууллагад хянан шалгагдаж байгаа хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацаа тасалдана.

14.5.Татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийх зорилгоор гадаад улсын татварын албанаас мэдээлэл гаргуулах ажиллагааны хугацаагаар татварын хөөн хэлэлцэх хугацааг тасалдсанд тооцно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОЛОН УЛСЫН ТАТВАРЫН ЗАРЧМЫН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

15 дугаар зүйл. Татвараас зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээ

15.1.Татварын алба дараахь тохиолдолд татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

15.1.1.татвар төлөгч нь дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран схем зохион байгуулсан;

15.1.2.энэ хуулийн 15.1.1-д заасан схемийн хүрээнд тухайн татвар төлөгч татвараас зайлсхийх замаар татварын ашиг хүртсэн.

15.2.Татвар төлөгч нь энэ хуулийн 15.1-д заасан хэлбэрээр татвараас зайлсхийж татварын ашиг хүртсэн бол татварын алба татвар төлөгчийн татварын ногдлын хэмжээг дээр дурдсан схемийг ашиглаагүй байх нөхцөлөөр дахин тодорхойлж татварын ногдолд залруулга хийнэ.

15.3.Татвар төлөгч энэ хуулийн 15.2-т заасан үйлдлийг бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлсэн бол уг хамтарсан этгээдийн татварын ногдлыг уг нөхцөлөөр дахин тодорхойлж, залруулга хийнэ.

15.4.Татварын алба энэ хуульд заасны дагуу залруулга хийсэн бол холбогдох татварыг нөхөн ногдуулна.

15.5.Нөхөн ногдуулалтыг энэ хуулийн 14.1-д заасан хөөн хэлэлцэх хугацаанд багтаан эхлүүлэх бөгөөд нөхөн ногдуулалтын хамрах хугацаа нь энэ хуулийн 15.3, 15.4-т зааснаар татварын ногдлыг тодорхойлсноос өмнөх 5 жилийг хамаарна.

15.6.Энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу татвар төлөгч нь дараахь хэлбэрээр схемийг ашигласан бол татварын ашиг хүртсэнд тооцно:

15.6.1.татварын суурийг бууруулах буюу татвараас чөлөөлөгдөх орлого, татварын хөнгөлөлт, суутган тооцоолол, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг бүртгэлийн аргаар өөрчлөх;

15.6.2.татвар төлөх үүргийг хойшлуулах;

15.6.3.татвар төлөх үүргийг хойшлуулснаар үүсэх давуу байдал олж авсан;

15.6.4.чөлөөлөгдөх орлого, эсхүл татвар ногдохгүй орлогын хэмжээг нэмэгдүүлэх замаар татвар ногдох орлогыг бууруулах;

15.6.5.татвар ногдох орлогод татвар ногдуулахгүй байх.

15.7.Энэ хуулийн 15.2, 15.3-т заасан залруулгыг хийхэд хуульд заасан татвар ногдуулах нийтлэг үйл ажиллагааны зарчмыг үл харгалзана.

15.8.Татварын алба энэ хуулийн 15.7-д заасан үйлдлийг энэ хуулийн дагуу татвар ногдуулах нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд хэрэглэнэ.

15.9.Татвараас зайлсхийхийн эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16 дугаар зүйл.Харилцан тохирох журам

16.1.Монгол Улсаас бусад улсуудтай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн харилцан тохирох журмыг хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын татварын албанаас гадаад улсын татварын албатай харилцан тохирох журмыг хэрэгжүүлнэ.

16.2.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улстай харилцан тохирох журмын асуудлаар олон улсын гэрээ байгуулаагүй гадаад улсын татвар төлөгчид энэ хуулийн 16.1 дэх хэсэгт хамаарахгүй.

16.3.Татварын харилцан тохирох журмыг Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, нэгдэн орсон олон улсын байгууллагаас тавигдах

шаардлагад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17 дугаар зүйл.Гадаад улсын эрх бүхий байгууллагатай харилцан мэдээлэл солилцох журам

17.1.Энэ зүйлд заасан дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

17.1.1.“мэдээллийг автоматаар солилцох” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хүрээнд гадаад улсын оршин суугч этгээдийн талаарх хэлэлцэн тохирсон мэдээллийг аливаа урьдчилсан хүсэлтгүйгээр тогтмол, тодорхой хугацааны давтамжтай хэлэлцэн тохирогч талууд хоорондоо солилцохыг.

17.1.2.“мэдээлэл” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор доор дурдсаны аль нэг, эсхүл бүгдийг нь агуулсан үйл баримт, тайлан, баримт, бүртгэлийг;

17.1.2.а.банк, санхүүгийн байгууллага, тэдгээрээс томилогдсон этгээд, хөрөнгө итгэмжилсэн этгээд, зуучлагч болон батлан даах чадвар бүхий этгээдийн мэдэлд байгаа баримт, тайлан, бүртгэлийг;

17.1.2.б.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, нөхөрлөл болон бусад этгээдэд хамааралтай үйл баримт, тайлан, баримт, бүртгэлийг;

17.1.2.в.хамтын хөрөнгө оруулалтын сангийн хувьд хувьцаа, хувь оролцоо, нэгж эрх болон бусад ашиг сонирхлын тухай мэдээллийг, итгэлцлийн сангийн хувьд төлбөр тооцоо гүйцэтгэгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, болон өгөөж хүртэж буй этгээдийн талаарх мэдээллийг.

17.1.3.“санхүүгийн байгууллага” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хүрээнд татварын албанд мэдээлэл хүргүүлэх үүрэг бүхий банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон кастодиан, хадгаламж, хөрөнгө оруулалтын болон даатгалын байгууллагыг;

17.1.4.“хэлэлцээр” гэж Монгол Улсаас бусад улстай байгуулсан татварын зорилгоор мэдээлэл солилцох, түүний дотор автоматаар мэдээлэл солилцох олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцыг;

17.1.5.“хүсэлт” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хүрээнд аль нэг тал нөгөө талдаа гаргасан өргөдлийг;

17.1.6.“хүсэлт гаргагч улс” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл авах хүсэлт гаргаж байгаа улсыг;

17.1.7.“цахим мэдээлэл” гэж энэ хуулийн 17.13-т заасан цахим аргаар боловсруулж хадгалсан бичлэгийг;

17.1.8.“эрх бүхий этгээд” гэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, эсхүл түүний томилсон эрх бүхий этгээдийг;

17.1.9.“эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээр” гэж энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хэлэлцээрийн зүйл, заалтыг тайлбарлах, тодруулах зорилгоор хэлэлцэн тохирогч талуудын томилсон эрх бүхий этгээд хооронд байгуулсан хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээрийг.

17.2.Монгол Улсаас бусад улстай байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь гадаад улсын эрх бүхий этгээдтэй зөвхөн татварын асуудлаар энэ хуулийн 17.1.2-д заасан мэдээлэл харилцан солилцоно.

17.3.Энэ хуулийн 17.1.8-д заасан эрх бүхий этгээд нь дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

17.3.1.энэ хуулийн 17.1.5-д заасан хүсэлтийг биелүүлэх зорилгоор дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

17.3.1.а.аливаа этгээдээс тайлан, мэдээ авах;

17.3.1.б.энэ зүйл болон хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл хүсэх этгээдэд холбогдох мэдээлэл болон нотлох баримтыг цуглуулан авч, хүргүүлэх;

17.3.1.в.баримт материалыг хүргүүлэх;

17.3.1.г. энэ зүйл болон гэрээнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээд нь энэ хуулийн 18, 19, 20, 21, 22, 23 дугаар зүйлд заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;

17.3.1.д.шаардлагатай бусад арга хэмжээ.

17.3.2.энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн дагуу хэлэлцэн тохирогч талуудтай татварын зорилгоор энэ хуулийн 17.1.2-т заасан мэдээлэл солилцох, мэдээлэл автоматаар солилцох, эрх бүхий этгээд хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлж ажиллах;

17.3.3.энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хүрээнд үүсэж болох зардлыг тодорхойлж, аливаа хүсэлттэй холбогдуулан гарах зардлыг тооцоолж тэнцвэртэй хуваарилах;

17.3.4.энэ хуулийн 17.1.4-т заасан хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор бусад улсын эрх бүхий этгээдтэй эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийг байгуулж, тэдгээртэй хамтран ажиллах журмыг батлах;

17.3.5.энэ зүйлд заасан бусад чиг үүрэг.

17.4.Эрх бүхий этгээд нь тухайн улстай байгуулсан хэлэлцээрийн нөхцөлийн дагуу хүсэлт гаргагч улсад туслалцаа үзүүлж ажиллана.

17.5.Энэ хуулийн 17.1.5-д заасан хүсэлтийг хүлээн авсны дараа эрх бүхий этгээд энэ зүйл болон холбогдох хэлэлцээрт нийцүүлэн хүсэлтийг биелүүлнэ.

17.6.Эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 17.1.6-д заасан хүсэлт гаргагч улсаас хүсэлтийн талаар нэмэлт мэдээлэл шаардаж болно.

17.7.Эрх бүхий этгээд нь хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр энэ хуулийн 17.1.2-т заасан мэдээллийг холбогдох бусад хууль тогтоомжид заасныг үл харгалзан мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр санхүүгийн байгууллагаас авч, хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

17.8.Энэ хуулийн 17.7-д заасан мэдэгдэлд дараахь мэдээллийг тусгаж болно:

17.8.1.мэдээлэл ирүүлэх хугацаа;

17.8.2.баримтын эх хувь, эсхүл түүний хуулбарыг авах эсэх талаарх эрх бүхий этгээдээс шаардсан хэлбэр;

17.8.3.баримтыг албан ёсоор баталгаажуулах эсэх.

17.9.Эрх бүхий этгээдийн хүсэлтийг үндэслэн энэ хуулийн 17.1.2-т заасан мэдээллийг гэрчийн мэдүүлэг хэлбэрээр авч болно.

17.10.Энэ хуулийн 17.8.1-д заасан хугацаа хуанлийн 14 хоногоос хэтрэхгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл эрх бүхий этгээд энэ хугацааг өөрөөр тогтоож болно.

17.11.Эрх бүхий этгээд нь энэ хуулийн 17.7-д заасан мэдээллийг хадгалж, хувилж, хуулбарлаж болно.

17.12.Хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллийг энэ хуулийн 17.7-д заасан мэдэгдлээр гаргуулахгүй.

17.13.Мэдэгдлийн хүрээнд авсан мэдээлэл цахим хэлбэрээр хадгалагдаж байгаа бол түүний агуулгыг өөрчлөлгүйгээр бичгэн хэлбэрт оруулж дахин боловсруулна.

17.14.Эрх бүхий этгээд нь тодорхой татварын асуудалтай холбогдсон мэдээллийг хүргүүлэхдээ дараахь шаардлагыг хангасан эсэхийг шалгана:

17.14.1.хүсэлт гаргасан тал нь Монгол Улстай харилцан мэдээлэл солилцдог байх;

17.14.2.хүсэлт гаргасан тал нь мэдээллийг нууцалдаг байх;

17.14.3.хүсэлтэд зааснаас өөр зорилгоор мэдээллийг ашиглах эрсдэлгүй байх;

17.14.4.Монгол Улсын эрх ашигт хохирол учруулах эрсдэлгүй байх;

17.14.5.хүсэлт гаргагч тал нь уг мэдээллийг олж авах бүхий л арга хэмжээгээ авсан байх.

17.15.Эрх бүхий этгээд ирүүлсэн хүсэлтийг холбогдох хэлэлцээр, эсхүл энэ хуулийн 17.14-т заасантай нийцэхгүй болохыг тогтоосон бол хүсэлтээс татгалзаж, энэ талаар хүсэлт гаргагч улсад нэн даруй мэдэгдэнэ.

17.16.Хүсэлтээс татгалзсан бол эрх бүхий этгээд болон хүсэлт гаргагч улсын зүгээс холбогдох хэлэлцээрт заасны дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

17.17.Баримт бичиг болон мэдэгдлийг холбогдох этгээдэд биечлэн, шуудангийн хаягаар, эсхүл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон хэлбэрээр хүргүүлж болно.

17.18.Бусад хууль тогтоомжид заасныг үл харгалзан эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл автоматаар солилцох зорилгоор эрх бүхий этгээд нь шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, тодорхой хэлбэрт нийцүүлж ирүүлэхийг энэ хуулийн 17.1.3-т заасан байгууллагаас шаардаж болно.

17.19.Энэ хуулийн 17.18-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран дараахь журмыг баталж, мөрдүүлж болно:

17.19.1.тайлан, мэдээлэл ирүүлэх шаардлагатай санхүүгийн байгууллагуудыг тодорхойлох;

17.19.2.тайлагнах шаардлагатай мэдээлэл, цахим мэдээллийн агуулга, загвар;

17.19.3.тайлагнах мэдээллийн иж бүрдэл, нарийвчлал зэргийг заасан стандарт;

17.19.4.мэдээлэл харилцан солилцох хэлэлцээрийг хэрэгжүүлэх журам;

17.19.5.мэдээллийн нууцлал, хадгалах үйл ажиллагааг зохицуулсан журам;

17.19.6.энэ хуулийн 17.16-д заасныг болон автоматаар мэдээлэл харилцан солилцохтой холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн журам.

17.20.Татварын албаны мэдээллийн нууцлалтай холбоотой харилцаанд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасныг баримтална.

17.21.Энэ хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй этгээд, эсхүл энэ ажлыг эрхэлдэг байсан этгээд нь энэ хуулийн 17 дугаар зүйл болон хэлэлцээрийн хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах үүрэгтэй бөгөөд зөвхөн энэ хууль болон хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийг ашиглаж болно.

17.22.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор эрх бүхий этгээдийн олж авсан мэдээллийг ашиглаж болно.

17.23.Энэ хуульд заасны дагуу мэдээллийг хүсэлтээр болон автоматаар солилцох зорилгоор нууц мэдээллийг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн бол уг үйлдэлтэй холбогдуулж мэдээлэл задруулсан үндэслэлээр бусад хуулиар хариуцлага хүлээлгэхгүй.

17.24.Энэ хуулийн 17.23-т заасны дагуу мэдээлэл өгч байгаа этгээдийн үйлдэл нь уг асуудлаар бусад этгээдтэй байгуулсан нууцлалын баталгааг зөрчсөн үйлдэл болохгүй бөгөөд энэ үйлдлийн төлөө тухайн этгээд болон түүний ажил олгогчид хариуцлага хүлээлгэхгүй.

17.25.Аливаа этгээд нь хууль зүйн давуу байдлаар олж авсан мэдээллээ бусдад задруулж иргэний болон эрүүгийн хэрэгт холбогдсон бол энэ хуулийн 17.23-т заасан хамгаалалтад хамаарахгүй.

17.26.Эрх бүхий этгээд, эсхүл түүний эрх олгосон этгээд нь энэ хуульд заасан албан үүргээ зохих журмын дагуу гүйцэтгэх явцад хийсэн үйлдэл, эс үйлдлийн улмаас хохирол учруулсан нь уг этгээдэд иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

17.27.Энэ зүйлийн заалтууд нь бусад хууль тогтоомжоор зохицуулж байгаа мэдээллийн нууцлалтай холбоотой хязгаарлалтаас үл хамааран давуу эрхтэй үйлчилнэ.

17.28.Энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд нь бусад хууль тогтоомжийн заалттай зөрчилдөж байгаа тохиолдолд энэ хууль болон хэлэлцээрийн заалтууд давуу эрхтэй үйлчилнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН АЛБАНААС ХЭРЭГЖҮҮЛЭХ НИЙТЛЭГ АЖИЛЛАГАА

18 дугаар зүйл.Татварын албанаас хэрэгжүүлэх нийтлэг ажиллагаа

18.1.Татварын улсын байцаагч татварын ногдлыг тодорхойлох болон татвар хураах зорилгоор татвар төлөгчийн байр агуулахад нэвтрэн орж мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх зэрэг нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэй.

18.2.Татварын улсын байцаагч энэ хуулийн 18.1-д заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааны зорилгыг тайлбарлана.

18.3.Энэ зүйлд заасан татварын улсын байцаагчийн хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаанд татвар төлөгч хүч хэрэглэж, эсхүл зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага Цагдаагийн албаны тухай хуулийн 15.1.7-д заасны дагуу дэмжлэг үзүүлнэ.

18.4.Энэ хуулийн 18.1-д заасан байр агуулахад нэвтрэн орж мэдээ мэдээлэл баримт цуглуулах, үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийхтэй холбогдсон журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

19 дүгээр зүйл.Байр, агуулахад нэвтрэн орох

19.1.Татварын улсын байцаагч нь татвар төлөгчийн орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татвартай холбогдолтой мэдээ, судалгаа, бусад баримтыг хадгалж байгаа, нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээний газар, албан байр, агуулах, зооринд нэвтрэн орж ажлын зураг авалт, үзлэг, тооллого хийх, баримт бичиг, эд хөрөнгийг түр хугацаагаар хураах, хяналт шалгалтын ажил хийх эрхтэй.

19.2.Татварын улсын байцаагч мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах зорилгоор байр, агуулахаас гадна татвар төлөгчийн орлого, зарлага, ажил гүйлгээний мэдээлэл бүхий компьютер, техник хэрэгсэл, програм хангамжид нэвтрэн орох эрхтэй.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан үйл ажиллагааг татвар төлөгчийн аль байр, агуулахад хийхийг удирдамжид тодорхой тусгаж харьяалах татварын албаны албан томилолтоор гүйцэтгэнэ.

19.4.Татварын улсын байцаагч нь бусдын байр, агуулах, компьютер, техник хэрэгсэл, програм хангамжид нэвтрэн орохдоо татварын улсын байцаагчийн үнэмлэхээ үзүүлнэ.

19.5.Гадаад орны дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын байр, дипломат эрх ямба бүхий албан тушаалтны ажлын байранд энэ хуулийн 19.1-д заасан ажиллагаа явуулахыг хориглоно.

20 дугаар зүйл.Мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах

20.1.Татварын алба мэдээ, мэдээлэл, баримт цуглуулахад дараахь журмыг баримтална:

20.1.1.татварын албаны шаардсан мэдээ, мэдээлэл, баримтыг эх хувиар түр хугацаагаар гаргуулахдаа тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулах;

20.1.2.шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, гэрэл зураг, дүрс, дууны болон бусад бичлэгээр баримтжуулах;

20.1.3.тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл ярилцлага хийсэн бол тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах;

20.1.4.энэ хуулийн 20.1.1-20.1.3-т заасантай адилтгах бусад мэдээ, мэдээлэл, баримт гаргуулах.

20.2.Татварын алба татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай магадалгаа, баримтын хуулбар, мэдээ, судалгаа, дансны хуулга, бусад холбогдох баримт бичиг, мэдээллийг татвар төлөгчөөс үнэ төлбөргүй гаргуулан авна.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан мэдээ, мэдээлэл, баримтыг хуулбарлах, баримтжуулахад бусдын техник хэрэгслийг ашигласан бол хөлсийг нь зах зээлийн, эсхүл харилцан тохиролцсон үнээр төлнө.

20.4.Татварын алба татвар төлөгчийн борлуулалт, худалдан авалт, хүний нөөц, техникийн үйлчилгээ, хоршсон үйлдвэрлэл, үйл ажиллагаанд ашигласан үнэ, төлбөр, хураамж, гэрээ хэлцэл зэрэг мэдээ, мэдээлэл, баримтыг гаргуулахаар татвар төлөгч болон түүнтэй хамтран үйл ажиллагаа явуулсан гуравдагч этгээдээс шаардах эрхтэй.

20.5.Татварын алба мэдээ, мэдээлэл баримт цуглуулах зорилгоор татвар төлөгчтэй харилцаа бүхий гуравдагч этгээдээс дараахь журмаар мэдээлэл гаргуулж болно:

20.5.1.мэдээлэл агуулж байгаа байр агуулах, баримт материал, компьютер зэрэгт бүрэн нэвтрэх;

20.5.2.бичгэн мэдээлэл болон баримт бичгийг шаардах;

20.5.3.тодорхой газар болон хугацаанд мэдээлэл өгүүлэхээр дуудан ирүүлэх.

21 дүгээр зүйл.Үзлэг хийх

21.1.Татварын алба үзлэг хийхэд дараахь журмыг баримтална:

21.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн, ашиг сонирхлын зөрчилгүй, татвар төлөгч, татварын алба, татварын улсын байцаагчтай захирах, захирагдах ёсны харилцаагүй хөндлөнгийн гэрчийг байлцуулах;

21.1.2.үзлэгт хамрагдаж байгаа бичиг баримт, эд хөрөнгийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулах;

21.1.3.үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэж оролцсон болон байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, хэрэв гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

21.2.Үзлэгт хамрагдах зүйлийн өмчлөл, эзэмшлийн ялгааг үл харгалзан Татварын алба, татварын улсын байцаагч нь үзлэг хийх эрхтэй.

21.3.Татварын алба үзлэг хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

22 дугаар зүйл.Тооллого явуулах

22.1.Татварын алба тооллого явуулахад дараахь журмыг баримтална:

22.1.1.бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгөний тооллого хийхдээ татвар төлөгч болон түүний хууль ёсны төлөөлөгч, нягтлан бодогч, эсхүл тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг байлцуулж, тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэх;

22.1.2.тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого хийсэн татварын улсын байцаагч болон тооллого явуулахад байлцсан бусад хүмүүс гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

22.2.Татварын алба тооллого хийх явцад татвар хураалт, хяналт шалгалтад ашиглах мэдээ, мэдээлэл, баримт цуглуулах эрхтэй.

23 дугаар зүйл.Ажлын зураг авалт хийх

23.1.Татварын алба ажлын зураг авалт хийхэд дараахь журмыг баримтална:

23.1.1. татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, орлого, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалтыг урьдчилан мэдэгдэж, эсхүл мэдэгдэхгүйгээр хийх;

23.1.2. ажлын зураг авалтад холбогдох мэргэжилтэн оролцуулж, шаардлагатай хэмжих хэрэгсэл ашиглах;

23.1.3. ажлын зураг авалтын тооцоо дүгнэлт хийж, тэмдэглэл үйлдэх, уг тэмдэглэлд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулах, гарын үсэг зурахаас татгалзвал шалтгааныг нь тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргах.

II ХЭСЭГ

ТАТВАРЫН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ГОРИМ

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТАТВАР ТӨЛӨГЧИЙГ БҮРТГЭХ, ТАТВАР НОГДУУЛАХ, ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ

24 дүгээр зүйл. Татвар төлөгчийн бүртгэл

24.1. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан татвар ногдох зүйл бүхий татвар төлөх, эсхүл татвар суутгах үүрэг бүхий этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

24.2. Монгол Улсын иргэн, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5-д заасан зорилгоор Монгол Улсад нэвтрэн орсон гадаад улсын иргэнд татвар төлөгчийн дугаар олгоно.

24.3. Татвар төлөгчийг бүртгэхдээ энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

24.4. Татвар төлөгчийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.

24.5. Оршин суугч бус этгээдийг түүний оршин суугчийн гэрчилгээг үндэслэн бүртгэнэ.

25 дугаар зүйл. Татвар төлөгчийг бүртгэх нийтлэг журам

25.1. Энэ хуулийн 26.1-д заасан татвар төлөх үүрэг бүхий этгээдийг татварын алба татвар төлөгчийн бүртгэлд бүртгэнэ.

25.2. Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийг бүртгэх эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн мэдээллийг үндэслэн татварын алба татвар төлөгчөөр бүртгэн татвар төлөгчийн дугаар, татвар төлөгчийн гэрчилгээг олгож, татвар төлөгчийн хувийн хэргийг цаасан болон цахим хэлбэрээр үүсгэнэ.

25.3. Татвар ногдох зүйлийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, эсхүл татвар ногдох зүйл бүхий этгээд, татвар төлөгчид олгосон болон өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээллийг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл, эсхүл татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн татварын алба тухай бүр татварын албаны бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

25.4.Татвар төлөгч нь татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, түүний өөрчлөлт, энэ хуулийн 25.2, 25.3-т заасан мэдээллийг өөрөө, эсхүл татварын албаны мэдэгдлийг үндэслэн татварын албаны бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэнээс 7 хоногийн дотор баталгаажуулах үүргийг хүлээж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлнэ.

25.5.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд баталгаажуулсан энэ хуулийн 25.4-т заасан мэдээллийн үнэн зөвийг татвар төлөгч хариуцна.

25.6.Өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн мэдээллийг татварын албанд цахим хэлбэрээр баталгаажуулж болно.

25.7.Энэ хуулийн 25.3, 25.4-т заасан мэдээллийг татварын алба бусад хөндлөнгийн мэдээлэлд үндэслэн өөрчилж болно.

25.8.Татвар төлөгчийн бүртгэлийн журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

25.9.Монгол Улсын хуулийн этгээд нь гадаад улсад орлого олох зорилгоор байгуулсан салбар, төлөөлөгчийн болон төлөөний газрыг татварын албанд бүртгүүлэх үүрэгтэй.

25.10.Монгол Улсын иргэн нь гадаад улсад орлого олох зорилгоор байгуулсан хуулийн этгээдийг татварын албанд бүртгүүлэх үүрэгтэй.

25.11.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээд өөрийн эцсийн эзэмшигчийн талаархи мэдээллийг татварын албанд бүртгүүлнэ.

25.12.Ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.

25.13.Энэ хуулийн 25.12-д заасныг үл харгалзан, өөрийн болон эцсийн эзэмшигчийн хувьцаа гадаад, дотоодын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагддаг бол ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч өөрийн эцсийн эзэмшигчийн өөрчлөлтийн тухай мэдээллийг татварын албанаас баталсан маягтын дагуу тухайн жилийн 7 дугаар сарын 20-ны өдөрт багтаан, жилийн эцсийн мэдээллийг дараагийн татварын жилийн 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд бүртгүүлнэ.

26 дугаар зүйл.Харилцан хамааралтай этгээд

26.1.Нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой доор дурдсан этгээдүүдийг хоорондоо харилцан хамааралтай этгээд гэж үзнэ:

26.1.1.Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан этгээдүүд;

26.1.2.энэ хуулийн 6.1.8-т заасан группд хамаарах этгээдүүд;
26.1.3.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;

26.1.4.ашиг, эсхүл татан буугдсаны дараахь үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээдүүд;

26.1.5.хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар эзэмшдэг аж ахуйн нэгжүүд;

26.1.6.ашиг, эсхүл татан буугдсаны дараахь үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй аж ахуйн нэгжүүд;

26.1.7.энэ хуулийн 26.1.1-д заасан этгээдийн шууд болон шууд бус эзэмшил дэх энэ хуулийн 26.1.3-26.1.6-д заасан харилцаа бүхий этгээдүүдийг;

26.1.8.дээр дурдсан этгээдүүд, тэдгээрийг томилох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх болон үүргийг шилжүүлэн хүлээж авсан, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;

26.1.9.дээр дурдсан аж ахуйн нэгжүүд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн салбар, төлөөний газар зэрэг;

26.1.10.Монгол Улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;

26.1.11.энэ хуулийн 26.1-д заасан агуулгаар тодорхойлогдох бусад этгээд.

26.2.Хувь нийлүүлэгчид шууд болон шууд бусаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргахад нэгдмэл байр суурьтай оролцохоор хэлцэл байгуулж, уг хэлцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг бол тухайн хувь нийлүүлэгчдийг энэ хуулийн 26.1.3-26.1.6-д заасан хувь, оролцооны хувьд нэг этгээд гэж үзнэ.

26.3.Шууд бус оролцоог тодорхойлохдоо шууд оролцооны хувиудын үржвэрээр тодорхойлно. Шууд оролцоо нь 50 хувиас дээш байвал 100 хувийн оролцоотой гэж үзнэ.

27 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлт

27.1.Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө.

27.2.Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж,

борлуулалтын мэдээллийг 7 хоногт багтаан татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.

27.3.Татвар төлөгч анхан шатны баримт бүрдүүлээгүй болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд холбогдоогүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй, эсхүл татвар ногдуулах орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардлыг тодорхойлохдоо бодит бус үнэ хэрэглэсэн тохиолдолд татварын алба татварын ногдлыг шууд бусаар тодорхойлж, холбогдох татварыг ногдуулна.

27.4.Татвар төлөгч татвар ногдох эд хөрөнгө, эрхийг бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлсэн болон шилжүүлж авсан тухай баримтыг шилжүүлсэн тухай бүр татварын албанд гаргаж өгөх үүрэгтэй.

27.5.Татвар төлөгч борлуулалт хийх бүртээ хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.

27.6.Татвар ногдуулах, суутган авах, төсөвт төлөх үүргийг хуулиар хүлээсэн этгээдэд үүргээ гүйцэтгэснийх нь төлөө хөлс төлөхгүй.

27.7.Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.

27.8.Татварыг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр бүртгэж, ногдуулж, тайлагнаж, төлнө.

27.9.Татвар ногдуулалт, төлөлттэй холбогдсон харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулна.

28 дугаар зүйл.Татварын тайлан үйлдэх, тушаах

28.1.Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараахь үүргийг хүлээнэ:

28.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх;

28.1.2.татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ гаргаж, тогтоосон хугацаанд татварын албанд хүргүүлэх;

28.1.3.суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах;

28.1.4.татварын тайлантай холбоотой баримт, мэдээллийг гадаад хэл дээр үйлдсэн бол монгол хэл дээр орчуулах бөгөөд ийнхүү орчуулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч өөрөө хариуцах;

28.1.5. татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээд нь уг баримт, бүртгэлийг татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгалах;

28.1.6. татварын тайланд тусгах, бүртгэх төлбөр тооцоо гадаад валютаар хийгдсэн тохиолдолд тухайн гүйлгээ хийсэн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцож төгрөгөөр илэрхийлэх.

28.2. Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна.

28.3. Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа долоо хоног бүрийн Бямба, Ням гариг, нийтээр тэмдэглэх баярын өдөртэй давхацсан тохиолдолд түүний өмнөх ажлын өдөр нь татвар төлөх, тайлагнах эцсийн өдөр байна.

28.4. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шаардлагатай тохиолдолд тайлан хүлээн авах хугацааг 7 хоног хүртэлх хугацаагаар сунгаж болох бөгөөд энэ тухайгаа олон нийтэд урьдчилан мэдэгдэнэ.

28.5. Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч татварын тайлан тушаах үүргээс чөлөөлөгдөхгүй бөгөөд уг татварын тайлан нь түүнийг тухайн төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах үндсэн баримт болно.

28.6. Татварын тайланд эрх бүхий албан тушаалтан, татвар төлөгч хувь хүн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, уг тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд гарын үсэг зурна.

28.7. Цахим хэлбэрээр татварын албанд илгээсэн татварын тайланг цахим гарын үсгээр баталгаажуулсан байх бөгөөд баталгаажуулаагүй тохиолдолд цаасан хэлбэрээр тушаана.

28.8. Цахим баримтыг тодорхойлох, түүнд тавих шаардлагыг тогтоох, цахим баримтыг хадгалах журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

29 дүгээр зүйл. Татварын тайлан хүлээн авах, тайлангийн боловсруулалт хийх

29.1. Татварын алба татвар төлөгч татварын тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд тушааж, татвараа үнэн зөв ногдуулж, төлж байгаа эсэхэд хяналт тавина.

29.2. Татварын алба тайланг хүлээн авахдаа татвар төлөгч татварын ногдуулалт, төлөлтийг үнэн зөв тодорхойлсон эсэхийг дараахь байдлаар нягтлан боловсруулалт хийнэ:

29.2.1. тайланг батлагдсан маягт, зааврын дагуу засваргүй үйлдэж татвар төлөгч болон холбогдох бусад этгээд гарын үсгээр, эсхүл тамга, тэмдэг дарж баталгаажуулсан, эсхүл цахимаар холбогдох журмын дагуу илгээсэн эсэх;

29.2.2.тайланг хуулиар тогтоосон хугацаанд тушаасан эсэх;
29.2.3.тайлангийн хавсралт баримт мэдээлэл бүрэн эсэх;
29.2.4.хуулийн этгээдийн хувьд нягтлан бодох бүртгэл, хувь хүний хувьд орлого, татварын бүртгэлийн дэвтэр болон холбогдох бусад баримтыг үндэслэн тайлангаа гаргасан эсэх;

29.2.5.нягтлан бодох бүртгэл болон татварын тайлангийн үзүүлэлтүүд хоорондоо тохирч байгаа эсэх;

29.2.6.татварын тайлан хоорондын үзүүлэлтийн дүн болон тайланд хавсаргасан баримт, мэдээллийн дүн тайлагнасан дүнтэй тохирч байгаа эсэх, тооцооны алдаа буй эсэх;

29.2.7.тайланд тусгасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн тооцож, тодорхойлсон эсэх;

29.2.8.тайланд тусгасан татварын тооцооны үлдэгдэл болон тухайн тайлангийн хугацаанд төлсөн татварын дүн татварын албаны бүртгэлтэй тохирч байгаа эсэх;

29.2.9.тухайн тайлангийн хугацаанд хамаарах татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн хөндлөнгийн мэдээлэл татварын тайлангийн мэдээлэлтэй тохирч буй эсэх.

29.3.Татварын алба энэ хуулийн 29.2-т заасны дагуу тайланг хянах бөгөөд мэдээлэл зөрүүгүй тохиолдолд тайланг хүлээж авах бөгөөд шаардлагатай тохиолдолд анхан шатны болон холбогдох бусад баримтыг шаардаж болно.

29.4.Татварын алба энэ хуулийн 29.2-т заасны дагуу тайланг хянаж зөрүү илэрвэл илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор мэдээллийн зөрүүг залруулах шаардлагыг татвар төлөгчид хүргүүлнэ.

29.5.Татвар төлөгч энэ хуулийн 29.4-т заасан шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах үүрэгтэй бөгөөд татварын алба тайланг хүлээн авна.

29.6.Татвар төлөгч шаардлагыг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа цахимаар, эсхүл бичгээр гаргаж, энэ хуулийн 29.5-д заасан хугацаанд багтаан татварын албанд ирүүлэх бөгөөд ийнхүү тайлбар ирүүлээгүй бол уг шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

29.7.Энэ хуулийн 29.6-д заасны дагуу татвар төлөгчөөс ирүүлсэн тайлбарыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан тайланг хүлээн авна.

29.8.Энэ хуулийн 29.7-д заасан тайлбар нь үндэслэлгүй гэж үзвэл татварын алба холбогдох мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх бөгөөд энэ нь тайлангийн хугацаанд хамаарах татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой асуудалд татварын хяналт шалгалт хийж тайлангийн ногдлыг тодорхойлох үндэслэл болно.

29.9.Тайлангийн боловсруулалт хийх хугацаанд тайланг хүлээн аваагүй нь алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.

29.10.Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

29.11.Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, тайлан нөхөх заавар, зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30 дугаар зүйл.Татварын тайланд залруулга хийх

30.1.Татвар төлөгч татварын тайланг дараагийн татварын жилд багтаан залруулж болно.

30.2.Хэрэв татвар төлөгч татварын тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийх бол уг залруулгыг нотлох анхан шатны болон холбогдох бичиг баримтын хамт залруулсан тайланг ирүүлнэ.

30.3.Татварын алба залруулсан тайланг хүлээн авахдаа энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

30.4.Татварын хяналт шалгалт хийхээр татвар төлөгчид мэдэгдсэнээс хойш энэ хуулийн 30.1-д заасан тайлангийн залруулгыг хийхгүй.

30.5.Татвар төлөгчийн хүсэлтээр тайланд залруулга хийсэн нь хуульд заасан хугацаанд төлөөгүй татварын алдангиас чөлөөлөх үндэслэл болохгүй.

30.6.Тайлангийн ногдлыг бууруулах залруулга хийсэн нь түүнийг хийхээс өмнө тооцсон алдангийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

31 дүгээр зүйл.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан

31.1.Татварын алба татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай байна. Татварын алба чиг үүргээ гүйцэтгэх, мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн систем, технологийг ашиглах бөгөөд тэдгээрийн нууцлал, найдвартай байдлыг бүрэн хангаж ажиллана.

31.2.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан дараахь зориулалттай байна:

31.2.1.татвар төлөгч болон татварын тайлан, ногдуулалт, төлөлт, татварын өрийг бүртгэх, хяналт тавих;

31.2.2.татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэх;

31.2.3.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдүүлэх;

31.2.4.татварын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

31.2.5.татвар төлөгчдөд үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах;

31.2.6.татварын албаны үйл ажиллагаанд болон татвар төлөгчид учирч болох эрсдэлийг тодорхойлох;

31.2.7.татварын удирдлага, түүний дотор мэдээллийн удирдлагын зардлыг багасгах, хөнгөн шуурхай, үр ашигтай, ил тод тайлагналыг хангах.

31.3.Татварын алба холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн бусад байгууллагуудын болон бусад гадаад, дотоод мэдээллийн эх үүсвэрийг ашиглаж болно.

31.4.Татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг бүртгэх, баяжуулах, түүний аюулгүй байдал, мэдээлэл ашиглалтад хяналт тавьж ажиллана.

32 дугаар зүйл. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх

32.1.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд дараахь мэдээлэл хамаарна:

32.1.1.татвар төлөгчийн бүртгэл, түүний өөрчлөлтийн мэдээлэл;

32.1.2.татвар, алданги, торгуулийн бүртгэл;

32.1.3.татварын тайлан, мэдээ, цахим төлбөрийн баримтын системийн мэдээлэл;

32.1.4.татварын улсын байцаагчийн үйлдсэн баримт бичиг, түүний биелэлтийн мэдээлэл;

32.1.5.татварын Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийн мэдээлэл;

32.1.6.татварын зөрчил, маргааныг хянаж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн мэдээлэл;

32.1.7.холбогдох байгууллагаас ирүүлсэн мэдээлэл;

32.1.8.хууль, журмын дагуу төрийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан мэдээлэл;

32.1.9.хөндлөнгийн мэдээлэл;

32.1.10.татварын хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичиг;

32.1.11.татварын албаны хүний нөөц, төсөв, хөрөнгийн мэдээлэл;

32.1.12.татварын өр, өр барагдуулалт, хураалтын үйл ажиллагааны мэдээлэл.

32.2.Татварын алба нь энэ хуулийн 32.1.2-т заасан бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх бөгөөд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, өрийг анхан шатны баримтад үндэслэн татварын бүртгэлд бүрэн тусгана.

32.3.Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах, ашиглалтад хяналт тавих журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

33 дугаар зүйл.Бусад байгууллагаас мэдээлэл гаргуулах, хамтран ажиллах

33.1.Татварын алба татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд энэ хуулийн 33.3-33.29-т заасан байгууллага, албан тушаалтан татварын албанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх, татварын зорилгоор хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

33.2.Байгууллага, албан тушаалтан татварын албаны хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор энэ хуулийн 33.3-33.29-т заасан мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлэх бөгөөд хугацааг тусгайлан өөрөөр заагаагүй бол сар бүрийн 10-ны дотор тогтмол мэдээлэх үүрэг хүлээнэ.

33.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага татвар төлөгчид хамааралтай санхүүгийн тайлангийн мэдээлэл, гадаадын санхүүжилттэй төсөл арга хэмжээ, төрийн сангийн зарцуулалтын мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээллийг тухай бүр хүргүүлнэ.

33.4.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад банк санхүүгийн эрх бүхий байгууллага нь дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.4.1.татвар төлөгчийн дансны мэдээлэл болон уг данстай холбоотой эзэмшигчийн талаарх мэдээллийг татварын албаны шаардсанаар тухай бүр;

33.4.2.татвар төлөгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо болон бусад банк санхүүгийн эрх бүхий байгууллагад шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, эсхүл өмнө нээсэн дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийлгэсэн бол энэ тухай мэдээллийг тухай бүр;

33.4.3.татвар төлөгчийн дансны гүйлгээний мэдээллийг татварын албанаас албан бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн.

33.5.Цагдаагийн байгууллага дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.5.1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон өөрт нь байгаа хувь хүний нууцад үл хамаарах мэдээ, судалгааг татварын албаны хүсэлтээр;

33.5.2.галт зэвсэг эзэмшигчийн болон галт зэвсгийн шилжилт хөдөлгөөн, хасалтын талаарх мэдээлэл, галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдан авах, улсын хилээр нэвтрүүлэх, зөвшөөрөлтэй хувь хүн хуулийн этгээдийн мэдээллийг.

33.5.3.гэрээт харуул хамгаалалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг;

33.5.4.жолооч бэлтгэх авто сургууль, курсын болон жолоодох эрхийн бүртгэлийн мэдээллийг;

33.5.5.татвараас зугтсан гэмт хэрэг, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг.

33.6.Цагдаагийн байгууллага татвар төлөхөөс зугтаж оргон зайлсан татвар төлөгчийн хаягийг тогтоох, эрэн сурвалжлах ажилд татварын албанд туслалцаа үзүүлж, хамтарч ажиллана.

33.7.Гаалийн байгууллага нь татвар төлөгчийн дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгуулж, экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг татварын албанд тухай бүр хүргүүлнэ.

33.8.Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.8.1.Монгол Улсын иргэний бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл;

33.8.2.Монгол Улсад бүртгэлтэй хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл;

33.8.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээлэл, өөрчлөлттэй холбоотой мэдээлэл.

33.9.Оюуны өмчийн асуудал хариусан төрийн захиргааны байгууллага оюуны өмч, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлнэ.

33.10.Гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.10.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суугаа хаяг, Монгол Улсын хилээр орсон, гарсан хугацааны болон түүнийг урьсан этгээдийн мэдээлэл, мөн тэдгээрийн хөрөнгийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр;

33.10.2.гадаадын хөрөнгө оруулалттай төрийн бус байгууллагын бүртгэл, өөрчлөлтийн талаархи мэдээллийг тухай бүр.

33.11.Төрийн захиргааны төв, орон нутгийн бусад байгууллага, тэдгээрийн удирдах албан тушаалтан дараахь үүрэг хүлээнэ:

33.11.1.татварын нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

33.11.2.хяналт шалгалт хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь албан үүргээ биелүүлэх явцад татварын хууль тогтоомжийг

зөрчсөн тухай мэдээлэл олж мэдсэн, илрүүлсэн бол энэ тухай мэдээллийг Татварын албанд тухай бүр хүргүүлэх;

33.11.3.тусгай зөвшөөрлийн бүртгэл, өөрчлөлтийн мэдээлэл, нөөц хөрөнгө болон сангуудаас олгосон санхүүжилтийн мэдээллийг Татварын албанд тухай бүр хүргүүлэх;

33.11.4.татварын хяналт шалгалтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай бусад мэдээллээр татварын албыг хангаж, хамтран ажиллах.

33.12.Хөрөнгийн бирж дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.12.1.хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн тархалтын тухай мэдээллийг тухай бүр;

33.12.2.хувьцаат компанийн хувьцааны борлуулалтын талаарх мэдээллийг тухай бүр.

33.13.Санхүүгийн зохицуулах хороо дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.13.1.тус хорооноос олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн бүртгэл, өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тухай бүр;

33.13.2.үнэт цаасны арилжааны мэдээллийг татварын албанд тухай бүр;

33.13.3.тус хороонд бүртгэлтэй санхүүгийн зах зээл дээр ажиллах эрх бүхий иргэдийн бүртгэл, дэлгэрэнгүй мэдээллийг.

33.14.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.14.1.үнэт цаасны бүртгэл, өөрчлөлтийн болон төлбөр тооцооны мэдээллийг тухай бүр;

33.14.2.төвлөрсөн хадгаламжийн дансны өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр;

33.14.3.хувьцаат компаниудын ногдол ашгийн олголтын мэдээллийг тухай бүр.

33.15.Ашигт малтмал, газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.15.1.ашигт малтмалын болон газрын тосны чиглэлээр холбогдох мэдээллийг тухай бүр;

33.15.2.тусгай зөвшөөрөл эзэмшигч, уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчтэй холбоотой болон стратегийн ач холбогдол бүхий ордын мэдээллийг тухай бүр.

33.16.Улсын хил хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын хилээр нэвтэрсэн иргэний талаарх мэдээллийг татварын албаны хүсэлтийг үндэслэн гаргаж, хүргүүлнэ.

33.17.Улсын хил хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага татварын албаны хүсэлтээр татварын өртэй гадаадын иргэн, хуулийн этгээдийг хилээр нэвтрүүлэхийг саатуулах арга хэмжээ авна.

33.18.Авто тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Монгол Улсын автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, түүний өөрчлөлтийн талаарх мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

33.19.Автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага татварын албаны автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр хураах ажилд дэмжлэг үзүүлж, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна.

33.20.Монголбанк дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.20.1.алт тушаалтын мэдээлэл, зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, гадны байгууллага, иргэдээс зээлсэн зээлийн гэрээний бүртгэлийн мэдээллийг тухай бүр;

33.20.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг батлагдсан маягт, журмын дагуу гаргаж тухай бүр.

33.21.Сорьцын алба алт тушаалт болон бусад шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлнэ.

33.22.Нотариат болон гэрээ, хэлцлийг бүртгэх чиг үүрэг бүхий бусад этгээд татвар ногдох зүйлтэй холбоотой гэрээ, хэлцэл, гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг гаргаж татварын албанд хүргүүлнэ.

33.23.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага газрын төлбөр төлөгчийн, газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийн бүртгэл, газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийн болон газраас авах үл хөдлөх эд хөрөнгийн татвар ногдуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албатай харилцан мэдээлэл солилцоно.

33.24.Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.

33.25.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг татварын албанд тухай бүр цахим хэлбэрээр хүргүүлнэ.

33.26.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ:

33.26.1.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бараа ажил үйлчилгээний гүйцэтгэл, худалдан авах ажиллагаанд оролцсон хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл, төсөвт өртөг, гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр;

33.26.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр.

33.27.Барилга хот байгуулалт, газар, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигч хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг тухай бүр гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

33.28.Худалдан авах ажиллагаа хариуцсан төрийн захиргааны байгууллага төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан хувь хүн, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл болон ажлын гүйцэтгэлийн мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.

33.29.Төрийн байгууллага, төр, орон нутгийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шаардлагатай мэдээллийг татварын албаны шаардсан даруйд гаргаж, хүргүүлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН АЛБАНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

34 дүгээр зүйл.Татварын албаны эрсдэлийн удирдлага

34.1.Татварын алба нь татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад татварын харилцаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

34.2.Татварын алба нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

34.2.1.Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд Татварын албаны өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, түүний хэрэгжилтийг хангахад хамгийн бага эрсдэлтэй байхад чиглэх;

34.2.2.эрсдэлийн удирдлага нь нэгдмэл, тасралтгүй байх;

34.2.3.эрсдэлийн удирдлага нь байгууллагын төлөвлөлт, шийдвэр гаргалтын нэг хэсэг болох;

34.2.4.эрсдэлийн удирдлага нь байгууллагын нөөцийн үр ашигтай зөв хуваарилалт, хэмнэлттэй байдлыг бий болгоход чиглэх.

34.3.Татварын албаны эрсдэлийн удирдлага гэж татварын харилцаанд оролцогчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх үйлдэл, эс үйлдэл, нөхцөл байдлыг урьдчилан тодорхойлон шинжлэх, шалтгаан нөхцөлийг нь тогтоох, үнэлэх, улмаар шийдвэрлэх оновчтой арга замыг сонгох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн тасралтгүй, цогц үйл ажиллагааг хэлнэ.

34.4.Татварын алба нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- 34.4.1.нөхцөл байдлыг тодорхойлох;
- 34.4.2.эрсдэлийн тодорхойлж, бүртгэх;
- 34.4.3.эрсдэлийг үнэлэх, шинжлэх;
- 34.4.4.эрсдэлийг удирдах ба хяналтын арга хэмжээгтодорхойлох;
- 34.4.5.эрсдэлийн удирдлагын үйл явцыг хянах.

34.5.Татварын албаны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь татварын хууль тогтоомжийн хүрээнд татварын албаны удирдлага, мэргэжил арга зүйн үйл ажиллагаанд ашиглагдах тооцооллын цахим системд тулгуурласан үйл ажиллагааны иж бүрдэл юм.

34.6.Энэ хуулийн 34.4.3-т заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээг татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хийнэ.

34.7.Эрсдэл тооцох шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх, хүчингүй болгох талаар хэлэлцэх, татварын албаны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах, хэрэгжилтийг нь хянах, эрсдэлийн шинжилгээний үр дүнтэй танилцах ажлыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын хороо ажиллана.

34.8.Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны даргын тушаалаар томилж, чөлөөлөх бөгөөд уг хороонд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулна.

34.9.Эрсдэлийн үнэлгээ, шинжилгээнд ашиглагдах шалгуур үзүүлэлтийг татварын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоох бөгөөд Эрсдэлийн удирдлагын хороогоор хэлэлцүүлсний үндсэн дээр, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

34.10.Энэ хуулийн 34.4.3-д заасан эрсдэлийн үнэлгээ, шинжилгээний үр дүнг үндэслэн татварын хяналт, шалгалтад хамруулах татвар төлөгчийг сонгоно.

34.11.Татварын албаны эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хорооны журмыг эрсдэлийн удирдлагын стандартад нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

35 дугаар зүйл.Татварын ногдлыг тодорхойлох боломжгүй байх

35.1.Татвар төлөгчийн татварын ногдлыг үнэн зөв тодорхойлох боломжгүй тохиолдолд татварын алба татвар төлөгчийн татварын ногдлыг шууд бус аргаар тооцоолж, нөхөн ногдуулалтын акт үйлдэнэ.

35.2.Дараахь үндэслэлээр татварын ногдлыг шууд бусаар тодорхойлно:

- 35.2.1.татвар төлөгч хуульд заасны дагуу тайлан, бүртгэл хөтлөөгүй;
- 35.2.2.татвар төлөгч тайлан, бүртгэлийг дутуу буюу буруу хөтөлсөн;
- 35.2.3.татвар төлөгчийн тайлан, бүртгэл алдагдсан буюу устсан;

35.2.4. татвар төлөгчийн татварын тайлангийн үзүүлэлт нь санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй харьцуулахад татварын ногдол дутуу тодорхойлогдсон нь илт байгаа;

35.2.5. харилцан хамааралтай этгээдийн хооронд хийсэн ажил гүйлгээнд бодит бус үнэ хэрэглэсэн;

35.2.6. татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн системд холбогдоогүй.

35.3. Татвар төлөгчдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь энэ хуулийн 35.2.1-35.2.4-д заасан нөхцөлөөр тодорхойлогдох боломжгүй тохиолдолд татварын алба өөрт байгаа мэдээлэлд үндэслэн энэ хуулийн 6.1.11-д заасан жишиг үнийн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлно.

35.4. Харилцан хамааралтай этгээдийн хооронд хийсэн ажил, гүйлгээнд бодит бус үнэ хэрэглэсэн бол энэ хуулийн 6.1.7-д заасан бодит үнийн аргыг хэрэглэнэ.

35.5. Татварын ногдлыг шууд бус аргаар тодорхойлох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

36 дугаар зүйл. Үнэ шилжилтийн ерөнхий зарчим

36.1. Хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцөлийг хяналтаас гадуурх ажил гүйлгээний нөхцөлтэй харьцуулахад орлого, ашиг болон татварын суурьд нөлөөлөх үзүүлэлтүүд нь ялгаатай бөгөөд үүнээс хамаарч татварын суурь буурсан бол уг буурсан дүнгийн зөрүүгээр татварын суурийг нэмэгдүүлж, холбогдох татварыг нөхөн ногдуулна.

36.2. Хяналтад байгаа ажил гүйлгээнд хамаарах татварын суурь нь түүнтэй харьцуулагдах хяналтаас гадуурх ажил гүйлгээнд хамаарах татварын сууриас багагүй байна.

36.3. Энэ хуулийн 36.2-т зааснаар хяналтад байгаа ажил гүйлгээний татварын суурийг тодорхойлохдоо уг ажил гүйлгээтэй харьцуулагдаж болох хяналтаас гадуурх ажил гүйлгээний нөхцөлтэй нийцэж байгаа эсэхийг дараахь байдлаар тогтооно:

36.3.1. ажил гүйлгээний үнэ, нөхцөл;

36.3.2. ажил гүйлгээ хийх бодит шаардлага байсан эсэх;

36.3.3. талууд харилцан хүлээсэн үүргээ биелүүлсэн, эсхүл бодит ажил гүйлгээ хийгдсэн эсэх.

36.4. Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн гэрээний нөхцөл болон бодит гүйцэтгэлийн хооронд зөрүү үүссэн тохиолдолд гэрээний талуудын оролцоо, чиг үүрэг, гүйцэтгэл, зарцуулсан хөрөнгө, хүлээсэн эрсдэл зэрэг бодит гүйцэтгэлийг харгалзан татварын суурьт тохируулгыг хийнэ.

37 дугаар зүйл. Үнэ шилжилтийн тайлан

37.1. Үнэ шилжилтийн тайланг дараахь байдлаар ангилна:

- 37.1.1.үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлан;
- 37.1.2.дотоод үнэ шилжилтийн тайлан;
- 37.1.3.ерөнхий үнэ шилжилтийн тайлан;
- 37.1.4.улс бүрээр тайлан.

37.2.Татвар төлөгч хяналтад байгаа ажил гүйлгээний мэдээллийг хадгалах, тайлагнах үүрэг хүлээнэ.

37.3.Татвар төлөгч татварын хяналт шалгалт хийхээс өмнө болон хийгдэх үед үнэ шилжилтийн тайлантай холбогдох татварын албаны шаардсан нэмэлт мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

37.4.Татвар төлөгч үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ.

37.5.Дотоод үнэ шилжилтийн тайлан дараахь мэдээллийг агуулна:

37.5.1.Монгол Улсад байрладаг татвар төлөгч, эсхүл төлөөний газрын бизнесийн үйл ажиллагаа болон бизнесийн стратеги, бодлогын талаарх мэдээлэл;

37.5.2.хяналтад байгаа ажил, гүйлгээний харьцуулагдах байдлын шинжилгээ хийхэд шаардагдах мэдээлэл, харьцуулагдах боломжтой хяналтаас гадуурх ажил гүйлгээний мэдээлэл, ашигласан үнэ шилжилтийн аргачлал болон холбогдох бусад мэдээлэл;

37.5.3.Монгол Улсад байрладаг татвар төлөгчтэй холбогдох ажил, гүйлгээний санхүүгийн мэдээлэл;

37.5.4.энэ хуулийн 37.9-д заасан шаардагдах бусад мэдээлэл.

37.6.Ерөнхий үнэ шилжилтийн тайлан дараахь мэдээллийг агуулна:

37.6.1.групп болон группийн оролцогчдын хувьцаа, хувь оролцооны шууд болон шууд бус эзэмшлийн бүтэц;

37.6.2.групп болон группийн оролцогчдын үйл ажиллагаа явуулж буй газар зүйн байрлал;

37.6.3.бизнесийн үндсэн үйл ажиллагаа, борлуулалт, худалдан авалт, нийлүүлэлтийн суваг, нэмүү өртөг үүсгэхэд ашиглагдаж байгаа голлох хөрөнгө, групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүрэг, хүлээх эрсдэл, тухайн санхүүгийн жилд гарсан бүтцийн өөрчлөлтөд нөлөөлсөн томоохон ажил гүйлгээний мэдээлэл;

37.6.4.групп болон группийн оролцогчдын эзэмшиж байгаа биет бус хөрөнгө, тэдгээрийн эзэмшлийн бүтэц, биет бус хөрөнгөтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;

37.6.5.групп болон группийн оролцогчдын хооронд хийгдсэн санхүүгийн ажил гүйлгээ болон үүнтэй холбогдуулан баримталж байгаа үнэ шилжилтийн бодлого;

37.6.6.групп, түүний оролцогчид, эсхүл тухайн татвар төлөгчийн санхүүгийн болон татварын асуудлаар баримталж байгаа бодлого, бусад улсын татварын албатай байгуулсан нэг болон хоёр талт үнэ урьдчилан тохиролцох гэрээний мэдээлэл;

37.6.7.харилцан хамааралтай этгээдүүдийн энэ хуулийн 37.6.1-37.6.6-д заасантай адилтгах, энэ хуулийн 37.9-д заасан мэдээлэл.

37.7.Улс бүрээр тайлан гаргах этгээд, тайлагнах нарийвчилсан харилцааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

37.8.Дараахь татвар төлөгч энэ хуулийн 37.1.2, 37.1.3-т заасан тайланг жилийн эцсийн татварын тайлангийн хамт харьяалах татварын албанд хүргүүлнэ:

37.8.1.өмнөх татварын жилд 6 болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;

37.8.2.группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд үйл ажиллагаа нь тусгагддаг бөгөөд өмнөх татварын жилд нэгтгэсэн санхүүгийн тайлангаар тус групп нь 6 болон түүнээс дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон;

37.8.3.гадаадын хөрөнгө оруулалттай.

37.9.Энэ хуулийн 37.1-д заасан үнэ шилжилтийн тайлан тус бүрийн маягтын загвар, маягт нөхөх заавар, тайлагнах нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, жишиг баримт бичгүүдэд нийцүүлэн татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

38 дугаар зүйл. Үнэ шилжилтийн тохируулга хийх

38.1.Татвар төлөгч нь үнэ шилжилтийн тайлан гаргаагүй, эсхүл татварын ногдлоо дутуу тодорхойлж тайлагнасан бол татварын алба нь үнэ шилжилтийн үндсэн тохируулга хийж, татварыг нөхөн ногдуулж, хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

38.2.Татварын алба энэ хуулийн 38.1-д заасан үндсэн тохируулгыг хийхээс гадна хувь хүний орлогын албан татвар болон аж ахуй нэгжийн орлогын албан татварын зорилгоор тохируулгын үр дүнд бий болсон үнийн зөрүүг ногдол ашиг гэж үзэж хоёрдогч тохируулгыг хийнэ.

39 дүгээр зүйл. Үнэ шилжилтийн тохируулга хийх аргачлал

39.1.Үнэ шилжилтийн тохируулга хийхэд дараахь аргыг ашиглана:

39.1.1.харьцуулагдах хяналтаас гадуурх үнийн арга;

39.1.2.дамжуулан борлуулах үнийн арга;

39.1.3.өртөг дээр нэмэх арга;

39.1.4.ажил гүйлгээний цэвэр ашгийн арга;

39.1.5.ажил гүйлгээний ашиг хуваах арга;

39.1.6.энэ хуулийн 36 дугаар зүйлд заасан үнэ шилжилтийн ерөнхий зарчимд нийцсэн бусад арга.

39.2.Татварын алба энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан үнэ шилжилтийн тохируулгыг хийхдээ энэ хуулийн 39.1-т заасан аргуудаас хамгийн тохиромжтой гэж үзсэн аргыг ашиглах бөгөөд доор дурдсан нөхцөлийг харгалзан бодит үнэ тодорхойлох зарчимд үндэслэн тогтооно:

39.2.1.хяналтад байгаа ажил гүйлгээний онцлог;

39.2.2.энэ хуулийн 36.3-д заасан нөхцөл;

39.2.3.бие даасан гүйлгээтэй харьцуулж болохуйц бодит мэдээлэл;

39.2.4.хяналтад байгаа болон хяналтаас гадуурх ажил гүйлгээний харьцуулагдах түвшин.

39.3.Хяналтад байгаа ажил гүйлгээнд тохируулга хийх аргыг сонгоход уг аргын давуу болон сул талыг харьцуулах замаар энэ хуулийн 39.1-т заасан аргын дангаар, эсхүл хослуулж ашиглана.

39.4.Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

39.5.Татварын хууль тогтоомж болон энэ хуулийн 39.4-д заасан журмаар зохицуулаагүй бөгөөд энэ хууль, түүнтэй нийцүүлж гаргасан эрх зүйн баримт бичигтэй зөрчилдөөгүй тохиолдолд татварын алба үнэ шилжилтийн тохируулга хийх асуудалд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Үнэ шилжилтийн зөвлөмж баримт бичгийг ашиглаж болно.

39.6.Татвар төлөгч үл мэдээлэгч улсын жагсаалтад байгаа улсын хуулийн этгээдтэй хяналтад байгаа ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн, эсхүл энэ хуулийн 38.1-д заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл үнэ шилжилтийн тайланг буруу мэдээлсэн тохиолдолд татварын алба дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

39.6.1.татвар төлөгчтэй харьцуулагдаж болохуйц гэж үзсэн татвар төлөгчийн нийтэд ил тод байгаа, эсхүл өөрт байгаа мэдээллийн сангаас сонгож харьцуулах замаар нөхөн ногдуулалт хийх;

39.6.2. татвар төлөгчийн мэдээллийг задруулахгүйгээр түүний ажил гүйлгээний үнийг харьцуулалт хийх зорилгоор авч болох бөгөөд энэ тохиолдолд уг этгээдийн мэдээллийг нууцална.

39.7.Энэ хуулийн 39.6-д заасан үл мэдээлэгч улс, бүс нутгийн жагсаалтад Монгол Улстай татварын зорилгоор мэдээлэл солилцдоггүй болон эрсдэлтэй татварын тогтолцоотой улс, бүс нутгийг хамруулах бөгөөд энэхүү жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жагсаалтад өөрчлөлт орсон бол ажлын 10 хоногийн дотор татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага албан ёсны цахим хуудсаараа нийтэд мэдээлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ

40 дүгээр зүйл.Татварын хяналт шалгалт

40.1.Татвар төлөгч татварын хууль тогтоомжид заасны дагуу төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг татварын алба хянан шалгана.

40.2.Татварын алба татварын хяналт шалгалтыг ерөнхий болон тусгай удирдамж, томилолттой хийх бөгөөд бүрэн, эсхүл хэсэгчилсэн хэлбэрээр олон улсын жишиг, хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

40.3.Татвар төлөгчийн эрсдэлд үндэслэн хялбаршуулсан хяналт шалгалт хийж болно.

40.4.Татварын алба эрсдэлд, эсхүл татвар төлөгчийн хүсэлтэд үндэслэн татвар төлөгчийн хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгана.

40.5.Татварын хяналт шалгалт хийх талаар татвар төлөгчид ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

40.6.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь татвар төлөгчийн улс, орон нутгийн төсөвт оруулж буй орлогын хэмжээ, татварын төрөл, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан хяналт шалгалтын харьяаллыг тогтоож болно.

40.7.Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зорилгоор Татварын албанаас хэрэгжүүлэх дараахь ажиллагаа энэ хуулийн 40.5-т хамаарахгүй:

40.7.1.Онцгой албан татварын тэмдэгийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

40.7.2.татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд холбогдсон эсэхэд хяналт тавих;

40.7.3.цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, олгох, илгээх, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих.

40.8.Татварын алба нь татварын улсын байцаагчийн мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлага, ашиг сонирхлын зөрчилд өртөхгүй байх нөхцөлийг харгалзан татварын хяналт шалгалтыг зохион байгуулж, томилгоо хийж, удирдамжийг батална.

40.9.Татварын хяналт шалгалтыг хоёр болон түүнээс дээш татварын улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэнэ.

40.10.Татварын алба нь татварын хяналт шалгалт хийх зорилгоор дараахь эрх хэмжээг хэрэгжүүлэх эрхтэй:

40.10.1.татвар төлөгч болон түүний харилцагч этгээдийг үндэслэл бүхий шалтгаанаар дуудан ирүүлж, тайлбар авах;

40.10.2.энэ хуулийн 6 дугаар бүлэгт заасан нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэх;

40.10.3.татварын болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, данс бүртгэл, санхүүгийн бусад баримт болон татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлтэй холбоотой тайлбар, лавлагаа гаргуулан авах.

40.11.Татварын алба, татварын улсын байцаагч хяналт шалгалт хийхдээ дараахь ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:

40.11.1.энэ хуулийн 40.4-т зааснаас бусад үндэслэлээр хяналт шалгалт хийх;

40.11.2.татварын улсын байцаагч татвартай холбогдсон эрүү, захиргааны хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох.

40.12.Татвар төлөгч нь татварын хяналт шалгалтад дараахь эрх, үүрэгтэй байна:

40.12.1.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо биечлэн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөхөөрөө дамжуулан хамгаалах, татварын хяналт шалгалтад биечлэн байлцах, нотолгоо, үндэслэл гаргах;

40.12.2.татвар ногдуулалт, төлөлт, татварын хяналт шалгалтын явц, үр дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

40.12.3.татварын хяналт шалгалтад шаардлагатай санхүүгийн болон бусад баримтыг шаардсаны дагуу цахим болон цаасан хэлбэрээр татварын албанд гарган өгч, татварын хяналт шалгалтад хамрагдах.

40.13.Татварын алба татварын хяналт шалгалтын явцад энэ хуулийн 77.2-т заасан татвар төлөгчид хүргүүлсэн татварын албаны зөвлөмж, чиглэлд тусгасан асуудлаар зөвлөмж, чиглэл өгсөн этгээдээс тодруулга авч болно.

40.14.Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, мөрдүүлнэ.

41 дүгээр зүйл.Нөхөн ногдуулалтын акт

41.1.Татварын улсын байцаагч энэ хуулийн 15.3, 35.1, 36.1, 40.1-д заасан үндэслэлээр нөхөн ногдуулалтын акт, эсхүл илтгэх хуудас үйлдэх бөгөөд нөхөн ногдуулалтын акт нь тэмдэглэх, тогтоох хэсгээс, илтгэх хуудас нь тэмдэглэх хэсгээс бүрдэнэ.

41.2.Нөхөн ногдуулалтын актаар татвар төлөгчийн татварын ногдлыг нэмэгдүүлэх, эсхүл бууруулах өөрчлөлт хийх бөгөөд ногдол бууруулсан зөрүүг нөхөн ногдуулалтын акт үйлдсэн татварын жилийн татварын үлдэгдлийн тооцоололд оруулан тооцно.

41.3.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудас нь нэгдсэн бүртгэл, дугаартай байх бөгөөд хавсралтын хамт хүчинтэй байна.

41.4.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудаст хяналт шалгалт хийсэн татварын улсын байцаагч гарын үсэг зурж, хариуцсан нэгжийн дарга хянан баталгаажуулж гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

41.5.Татварын алба, татварын улсын байцаагч нь албан ёсны маягтад эцэслэн баталгаажуулаагүй нөхөн ногдуулалтын актыг татвар төлөгчид урьдчилан танилцуулахгүй.

41.6.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор гардуулж, гардуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ.

41.7.Татвар төлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 41.6-д заасан хугацаанд гардуулах боломжгүй, эсхүл гардан аваагүй бол татварын алба уг хугацаа өнгөрснөөс хойш 7 хоногийн дотор татвар төлөгчийн хувийн хэрэгт бүртгүүлсэн хаягт шуудангаар илгээнэ.

41.8.Нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсыг энэ хуулийн 41.7-д заасны дагуу илгээсэн өдрөөс хойш Шуудангийн тухай хуулийн 20.3-т заасан хугацаанд гардуулсанд тооцно.

41.9.Татварын улсын байцаагч нь нөхөн ногдуулалтын актын хамт татварын хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчилтэй холбогдуулан цаашид татварын хууль тогтоомжийг зөв хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгнө.

42 дугаар зүйл.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргах

42.1.Татвар төлөгч нөхөн ногдуулалтын актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхгүй бол нөхөн ногдуулалтын актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж болно.

42.2.Татвар төлөгч энэ хуульд заасан хугацаанд нөхөн ногдуулалтын актыг гардан аваагүй нь шүүхийн болон захиргааны журмаар гомдол гаргах хугацааг хуульд заасан журмын дагуу тоолохгүй байх үндэслэл болохгүй.

42.3.Татвар төлөгч энэ хуулийн 42.1-д заасны дагуу гомдол гаргасан нь ногдуулсан татвар, алданги, торгууль төлөхийг зогсоох үндэслэл болохгүй.

42.4.Татварын алба нь татварын улсын байцаагчийн үйлдсэн нөхөн ногдуулалтын акт болон шийтгэлийн хуудсын биелэлтийг хангуулж хяналт тавин ажиллана.

43 дугаар зүйл.Татварын хяналт шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэх

43.1.Татварын хяналт шалгалтыг хийх явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

44 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хяналт шалгалт

44.1.Татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хүсэлтийг харьяа татварын алба хүлээн авч, хянаж

шалган, баталгаажуулж, саналыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгжид шилжүүлнэ.

44.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын том татвар төлөгч хариуцсан нэгж нь энэ хуулийн 44.1-д заасан саналыг хүлээн авч нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянан шалгаж, баталгаажуулсан акт үйлдэнэ.

44.3.Татвар төлөгч энэ хуулийн 44.2-т заасан шийдвэрийг зөвшөөрөхгүй бол энэ хуулийн 45.1-д заасан Маргаан таслах зөвлөлд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

44.4.Татварын улсын байцаагчийн үйлдсэн нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан актыг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон нь Татварын алба нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг дахин баталгаажуулах үндэслэл болно.

АРАВДУГААР БҮЛЭГ МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ

45 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөл

45.1.Татварын албаны дэргэд татвар төлөгчөөс энэ хуулийн 6.1.27-д заасан татварын акттай холбогдуулан гаргасан гомдол, Захиргааны ерөнхий хуулийн 94.2-т заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий татварын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага, татварын алба, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Татварын маргаан таслах зөвлөл /цаашид “Маргаан таслах зөвлөл” гэх/ ажиллана.

45.2.Маргаан таслах зөвлөл нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

45.3.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу татвар төлөгчийн гаргасан гомдлыг харьяаллын дагуу татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл тус тус шийдвэрлэнэ.

45.4.Маргаан таслах зөвлөл нь 9, эсхүл 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.

45.5.Маргаан таслах зөвлөлийг тухайн байгууллагын удирдлагатай зөвшилцсөний үндсэн дээр дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулна:

45.5.1.аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд нутгийн захиргааны байгууллага, татварын албаны төлөөлөл, татвар төлөгчийг төлөөлөх төрийн бус байгууллагын төлөөлөл;

45.5.2.татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүнд татварын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын албаны төлөөлөл, татвар төлөгчийн төлөөлөл болох төрийн бус байгууллагын төлөөлөл.

45.6.Маргаан таслах зөвлөлийн гишүүн нь нягтлан бодогч, санхүүч, эдийн засагч, эсхүл эрх зүйч мэргэжилтэй, мэргэжлээрээ гурваас дээш жил ажилласан туршлагатай байна.

45.7.Маргаан таслах зөвлөлийн дэргэд татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх зорилгоор татварын асуудлаар дүн шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий хараат бус магадлагч ажиллах бөгөөд магадлагч нь тухайн шатны татварын албаны дарга томилсон татварын улсын байцаагчийн эрхтэй этгээд байна.

45.8.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн даргаар нь татварын улсын байцаагчийн эрхтэй этгээдийг Маргаан таслах зөвлөлийн даргын санал болгосноор тухайн шатны татварын албаны дарга томилно.

45.9.Аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн болон даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.

46 дугаар зүйл.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах, шийдвэрлэх

46.1.Татвар төлөгч, эсхүл түүний эрх олгосон итгэмжлэгдсэн төлөөлөгч, мэргэшсэн зөвлөх татварын актыг гардаж авснаас хойш энэ хуулийн 42.1, 74.4-т заасан хугацаанд харьяалах Маргаан таслах зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

46.2.Гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

46.3.Нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа уг актаар нөхөн ногдуулсан татварын хүлээн зөвшөөрөөгүй дүнгийн 10 хувийг төсөвт төлөх ба уг төлөх дүн нь 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

46.4.Энэ хуулийн 46.1-д заасан гомдлыг дараахь харьяаллын дагуу шийдвэрлэнэ:

46.4.1.аймаг, нийслэлийн татварын албанд харьяалагдах татвар төлөгчийн гомдлыг тухайн аймаг, нийслэлийн татварын албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөл;

46.4.2.том татвар төлөгч хариуцсан нэгжид харьяалагддаг татвар төлөгчийн гомдлыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөл.

46.5.Маргаан таслах зөвлөл нь холбогдох татварын акт, ирүүлсэн гомдол, хүсэлт болон бусад баримт бичиг, мэдээллийг хянаж, 3 хоногийн дотор харьяаллыг тогтоож, харьяаллын бус бол маргааныг холбогдох Маргаан таслах зөвлөлд энэ хуулийн 46.4-т заасан харьяаллын дагуу шилжүүлнэ.

46.6.Маргаан таслах зөвлөлийн хуралдааны бүх гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэйгээр хуралдуулна.

46.7.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хуралдаанаараа хэлэлцэж, , хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

46.8.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 45.1-д заасан гомдлыг татвар төлөгчийн гомдлын хүрээнд хянан шалгаж, шийдвэр гаргана.

46.9.Маргаан таслах зөвлөл нь татварын актаар баталгаажуулсан дүнг өөрчлөх, хүчингүй болгох, хэвээр үлдээх шийдвэрийн аль нэгийг гаргах бөгөөд уг шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

46.10.Маргаан таслах зөвлөл нь гомдлыг хэлэлцэх явцад татварын актын бичилтийн болон тооцооны алдааг илрүүлсэн, асуудлыг дутуу шийдвэрлэсэн, маргаан таслах зөвлөлийн магадлан судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл тухайн татварын албанд дахин шалгуулахаар актыг буцааж болно.

46.11.Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь маргаан таслах зөвлөлийн хэлэлцсэн асуудал болон гаргасан шийдвэрийн үндэслэлийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, зөвлөлийн шийдвэрийг татвар төлөгч, татварын улсын байцаагч, магадлагч зэрэг хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хувийн мэдээллийг таних боломжгүйгээр цахим хуудсаар тухай бүр мэдээлнэ.

46.12.Маргаан таслах зөвлөл нь маргаан үүссэн шалтгаан, түүний нөхцөлийг арилгуулах, татварын хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж гаргаж, татварын албанд хүргүүлэх эрхтэй.

46.13.Маргаан таслах зөвлөл нь татвар төлөгчийн гомдол гаргаснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг шийдвэрлэж, уг шийдвэрийг маргааны оролцогч талуудад гардуулна.

46.14.Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 46.13-т заасан шийдвэр гаргах хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

46.15.Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан татвар төлөгч нь энэ хуулийн 46.13, 46.14-т заасан хугацаанд магадлагч татварын улсын байцаагчийн шаардсан нотлох баримтыг ирүүлээгүй тохиолдолд ирүүлсэн нотлох баримтын хүрээнд гомдлыг хянан шийдвэрлэнэ.

46.16.Маргаан таслах зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвхөн шүүхийн шийдвэрээр өөрчилнө.

46.17.Татвар төлөгч нь Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд хандах эрхтэй.

46.18.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.3-т заасантай адилтгах шалтгаанаар маргаан таслах зөвлөл татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх боломжгүй бол татварын актыг хэлэлцэхийг түдгэлзүүлж болно.

Тайлбар: “тооцооны алдаа” гэж татварын актад бичигдсэн тоон илэрхийллийг арифметик, оронгийн гэх мэт илт тооцооны алдаа гаргасан байхыг ойлгоно.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ ТАТВАРЫН НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ, ТАТВАРЫН ӨР

47 дугаар зүйл.Татвар ногдуулалт, төлөлтийн бүртгэл

47.1.Татварын алба нь татвар, торгууль, алдангийн ногдуулалт, төлөлтийг татвар төлөгч бүрээр бүртгэнэ.

47.2.Татварын алба нь татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдуулалт, төлөлт, хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын өрийг татварын тайлан болон шийтгэлийн хуудас, нөхөн ногдуулалтын актад үндэслэн бүртгэнэ.

47.3.Татварын хяналт шалгалтын үр дүнд тайлангийн ногдол буурсан тохиолдолд татварын алба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдох өөрчлөлтийг хийнэ.

47.4.Татварын орлого бүртгэх, орлогын данснаас татвар хооронд суутган тооцох журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

48 дугаар зүйл.Татварыг буцаан олгох, суутган тооцох

48.1.Татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг доор дурдсан дарааллын дагуу шийдвэрлэнэ:

48.1.1.буцаан олгох;

48.1.2.тухайн хугацаанд төлбөл зохих бусад татварт суутган тооцох;

48.1.3.татвар төлөгч зөвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох.

48.2.Татвар төлөгч татварын өртэй бол энэ хуулийн 48.1-д заасан дарааллыг үл харгалзан татварын өрийг түрүүлж суутган тооцно.

48.3.Татварыг суутган тооцохдоо энэ хуулийн 51.1-д заасан дарааллыг баримтална.

48.4.Илүү төлсөн татварыг буцаан олгох харилцааг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулж болно.

48.5.Илүү төлсөн татварыг суутган тооцсон бол татварын алба энэ тухай татвар төлөгчид мэдэгдэнэ.

48.6.Энэ хуулийн 48.1.1-д заасан буцаан олголт нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

48.7.Татварын алба татварын хөнгөлөлт, илүү төлөлтийг хуулийн дагуу буцаан олгох зориулалттай харилцах данстай байх бөгөөд данс хөтлөх, түүнтэй

холбоотой харилцааг зохицуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

49 дүгээр зүйл.Татварын өр

49.1.Доор дурдсан хугацаанд төлөөгүй татвар, алданги, торгууль, (цаашид “татварын өр” гэх)-ийг татварын өрд хамруулна:

49.1.1.татвар төлөгчийн тайлангаар тодорхойлсон татварын хувьд татварын хууль, тогтоомжид зааснаар татвараа төлж, тайлагнасан байх ёстой өдөр;

49.1.2.тайлан боловсруулалтаар болон татвар төлөгчийн хүсэлтээр хийсэн залруулгын тайлангаар тодорхойлсон татварын хувьд залруулгын тайлан хүлээн авсан өдөр;

49.1.3.нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаар тогтоосон татвар, алданги, торгуулийн хувьд уг шийдвэрийг гардуулснаас хойш ажлын 15 өдөр;

49.1.4.татварын хууль тогтоомжоор тайлагнадаггүй татварын хувьд татварын хууль тогтоомжоор татвараа төлсөн байх ёстой өдөр.

49.2.Нөхөн ногдуулалтын актыг маргаан таслах зөвлөл, шүүхийн шийдвэрээр эцэслэн тогтоосон тохиолдолд энэ хуулийн 49.1.3-т заасан өрийн хэмжээг уг шийдвэрийг үндэслэн өөрчилнө.

50 дугаар зүйл.Татварын нэхэмжлэх

50.1.Татварын алба энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан татварын өрийг төлүүлэхээр татварын нэхэмжлэх (цаашид “нэхэмжлэх” гэх)-ийг татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

50.1.1.татвар төлөгчийн нэр;

50.1.2.татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

50.1.3.нэхэмжлэх хүргүүлсэн хугацаа;

50.1.4.татварын өр төлөх үндэслэл;

50.1.5.татварын өр, алдангийн хэмжээ, татварын өр төлөх эцсийн хугацаа;

50.1.6.татварын өр төлөх газар, дансны нэр, дугаар;

50.1.7.нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 10 өдөрт багтаан татварын өрийг төлөх тухай сануулга;

50.1.8.татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад мэдээлэл.

50.2.Татварын алба нэхэмжлэхийг татварын өр үүссэн хугацаанаас хойш ажлын 30 өдөрт багтаан татвар төлөгчид хүргүүлнэ.

51 дүгээр зүйл.Татварын өр төлөх дараалал

51.1.Татварын өрийг доор дурдсан дарааллаар барагдуулна:

- 51.1.1.татварын үндсэн өр;
- 51.1.2.алданги;
- 51.1.3.торгууль.

52 дугаар зүйл.Татвар төлөх хугацааны хөнгөлөлт

52.1.Доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үүсэж татвар төлөгч татварын өрийг төлөх боломжгүй болох нь тогтоогдсон бол тэрхүү нөхцөл байдлаас бий болсон бодит зардал, хохирол, алдагдалтай тэнцэх хэмжээгээр хязгаарлан, татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн харьяа татварын алба татвар төлөх хугацааг 1 жил хүртэлх хугацаагаар сунгаж хөнгөлөлт үзүүлж болно:

52.1.1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д заасан гамшиг болон үер, газар хөдлөлт, гал түймэрт өртсөн;

52.1.2.энэ хуулийн 6.1.43.а, 6.1.43.б-д заасан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас татвар төлөгч хувь хүний хувьд өмнөх жилийн татвар ногдох орлогоос илүү хэмжээтэй эмчилгээний зардал гаргасан;

52.1.3.татвар төлөгч эрхэлж буй үйл ажиллагаагаа зогсоосон;

52.1.4.татвар төлөгчийн үйл ажиллагаанд 3 жил дараалан их хэмжээний алдагдал хүлээсэн, төлбөрийн чадвар муудсан .

52.2.Татвар төлөгч энэ хуулийн 52.1-д заасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өрийг төлөх боломжгүй хүндэтгэн үзэх нөхцөл үүссэн тохиолдолд татвар төлөгчийн хүсэлтийг үндэслэн харьяалах татварын алба хугацааг дахин сунгаж болно. Сунгах хугацаа нь анхны хөнгөлөлтийг оруулан нийт 2 жилээс илүүгүй байна.

52.3.Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлт үзүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

52.3.1.татвар төлөх хугацааны хөнгөлөлтөд хамаарах татварын өрийн дүн нь 10.0 сая төгрөгөөс доош, эсхүл хөнгөлөх хугацаа нь 3 сар хүртэлх татварын өрд барьцаа хөрөнгө шаардахгүй бөгөөд бусад тохиолдолд сунгасан хугацаанд хамаарах алдангийн хэмжээг оруулсан дүнгээс багагүй хэмжээний барьцаа хөрөнгийг шаардана;

52.3.2.барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө, засгийн газрын бонд байх ба барьцаалах ажиллагааг Иргэний хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ;

52.3.3.энэ хуулийн 52.3.1-д заасан барьцааны оронд бусад этгээдийн батлан даалтыг ашиглаж болно;

52.3.4.татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтэд хөрөнгийн байдал, санхүүгийн чадавхийг тэмдэглэн, түүнд үндэслэн гаргасан хөнгөлөлтийн хугацаанд татварын өр төлөх хуваарийг тусгана.

52.4.Татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн бол тухайн татварын өрийг хураах энэ хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй.

52.5.Энэ хуулийн 52.1, 52.2-т заасны дагуу татварын өр төлөх хугацааг хөнгөлсөн тохиолдолд хөнгөлөлтийн хугацаанд тооцох алдангийг 20 хувиар хөнгөлнө.

52.6.Энэ хуулийн 52.1, 52.2-т зааснаар татвар төлөгч сунгасан хугацаанд эрсдэлтэй татвар гэж үзэх нөхцөл байдал үүссэн, эсхүл хуваарийн дагуу татварын өрийг төлөөгүй, барьцааны зүйлийг өөрчлөхийг зөвшөөрөөгүй болон түүний дараа гарах нөхцөл байдлын өөрчлөлт нь хөнгөлөлтийг үргэлжлүүлэхэд зохистой бус гэж үзсэн тохиолдолд татварын албаны дарга хөнгөлөлтийг цуцалж, барьцааны зүйлээс татварын өрийг гаргуулна.

52.7.Энэ хуулийн 52.6-д заасны дагуу хөнгөлөлтийг цуцалсан тохиолдолд эхний ээлжид үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас зэрэг татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах бөгөөд уг хөрөнгөөс гаргуулж хүрэлцэхгүй тохиолдолд батлан даагчаас татварын өрийг гаргуулах зарчим баримтална.

52.8.Батлан даагчаас татварын өрийг гаргуулахдаа энэ хуулийн 60.1, 60.2-т заасны дагуу мэдэгдэх хуудсыг хүргүүлнэ. Батлан даагч нь батлан даасан үүрэгт хамаарах татварыг мэдэгдэх хуудсанд заасан хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэх хүргүүлнэ. Батлан даагч тухайн нэхэмжлэхэд заасан хугацаанд татварын өрийг төлөөгүй бол татварын өр хураах ажиллагааг эхлүүлнэ.

52.9.Татварын өр төлөх хугацааны хөнгөлөлтийг зөвшөөрсөн болон цуцалсан талаар татварын албаны даргын шийдвэрийг өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

52.10.Татварын өр төлөх хугацааг хөнгөлөх журам, энэ үйл ажиллагаатай холбогдох маягтын агуулга, загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

53 дугаар зүйл.Эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагаа

53.1.Доор дурдсан нөхцөл байдлын аль нь нэг үүсэж, татвар төлөгч татвараа төлөхгүй нь тодорхой болсон тохиолдолд ногдол нь тодорхой татварыг татварын алба урьдчилан хурааж болно:

53.1.1.татвар төлөгчийн хөрөнгөнд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа эхэлсэн;

53.1.2.татвар төлөгч татан буулгах шийдвэр гаргасан;

53.1.3.татвар төлөгч Монгол Улсад оршин суух хаяггүй болсон;

53.1.4.татвар төлөгч хууль бус үйлдлээр татвар төлөхөөс зугтах, эсхүл зугтахыг оролдох, татварын буцаан олголт авах, эсхүл авахыг оролдох, залилангийн шинжтэй үйлдлээр хөрөнгө шилжүүлэх, санаатайгаар дампуурах зэргээр татварын өр хураах үйл ажиллагаанаас зугтах, эсхүл зугтахыг оролдсон.

53.2.Энэ хуулийн 53.1-д заасны дагуу татварыг ажлын 3 хоногт багтаан төлүүлэхээр урьдчилан нэхэмжлэх хуудас хүргүүлнэ.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ ТАТВАРЫН ӨР ХУРААХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

54 дүгээр зүйл. Татварын өр хураах үйл ажиллагаа

54.1. Татварын алба дараахь тохиолдолд татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлнэ:

54.1.1. татвар төлөгч татварын өрийг нэхэмжлэхэд заасан хугацаанд бүрэн төлөөгүй;

54.1.2. татвар төлөгч энэ хуулийн 53.2-т заасан урьдчилан нэхэмжлэх хуудсаар тогтоосон хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;

54.1.3. өв залгамжлагч нэхэмжлэхэд заасан хугацаанд татвараа бүрэн төлөөгүй;

54.1.4. татвар төлөх хугацаанаас хойш нэхэмжлэх хүлээн авсан татвар төлөгчид энэ хуулийн 53.1-д заасан нөхцөл байдал үүссэн.

54.2. Татварын алба татварын өрийг хураахдаа татвар төлөгчид нэхэмжлэх хүргүүлэх, хөрөнгө болон авлага битүүмжлэх, татварын өрийг үл маргах журмаар гаргуулах, битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх, орлогыг хуваарилах, хууль тогтоомжид заасны дагуу эрх хязгаарлах, түдгэлзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

55 дугаар зүйл. Татварын давуу эрхийн зарчим

55.1. Энэ хуулийн 55.2-55.7-д зааснаас бусад тохиолдолд татварыг аливаа авлагаас түрүүлж гаргуулна.

55.2. Татвар төлөгчийн хөрөнгөд энэ хуулийн 6.1.4-т заасан албадан гүйцэтгэх үйл ажиллагаа явуулж, хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн тохиолдолд тухайн мөнгөн хөрөнгөөс татварын алба татварын өрийг гаргуулах хүсэлт гаргасан бол татварын өрийг тухайн үйл ажиллагааны зардлын дараа хураана.

55.3. Татвар төлөгчийн хөрөнгийг татварын өр хураах үйл ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс татвар хураах шууд зардлыг энэ хуулийн 55.4, 55.5.3, 55.6, 55.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

55.4. Онцгой албан татвар болон автобензин, дизелийн түлшний албан татвар ногдох зүйлийг албадан гүйцэтгэх ажиллагааны дагуу мөнгөн хэлбэрт шилжүүлсэн бол тухайн мөнгөн хөрөнгөөс шилжүүлгийн дүнд үүссэн онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний албан татварыг энэ хуулийн 55.5-55.7-д заасныг үл харгалзан бусад татвар болон авлагаас түрүүлж хураана.

55.5. Татварын өр хураах үйл ажиллагаагаар хийсэн битүүмжлэлд хамаарах хоёр болон түүнээс дээш татварын албанд бүртгэлтэй татвар төлөгчийн татварын өрийг дараахь байдлаар хураана:

55.5.1. тухайн татварын өрийг хураах зорилгоор хөрөнгө битүүмжилсэн бол битүүмжлэлд хамаарах татварыг суутгуулах хүсэлт гаргасан бусад татварын өрөөс түрүүлж;

55.5.2. хэд хэдэн суутгуулах хүсэлт гаргасан татварын өрийн хувьд хүсэлт гаргасан дарааллаар татварын өрийг түрүүлж;

55.5.3. татвар төлөгч татвар төлөх хугацааг хөнгөлүүлж, хөрөнгө барьцаалсан бол энэ хуулийн 55.5.1, 55.5.2-т заасныг үл харгалзан барьцаалсан татварын өрийг түрүүлж.

55.6. Татвар төлөгчийн барьцаа, ипотекийн барьцаа зэрэг гуравдагч этгээдээс давуу эрхтэйгээр шаардах эрхтэй хөрөнгөөс татварын өрийг гаргуулах тохиолдолд татварын өрийг эдгээр авлагын дараа хураана.

55.7. Бүртгүүлэх боломжгүй барьцаа, эсхүл бүртгэл хийгдээгүй ч түрүүлж авах шаардах эрхийн хувьд албадан гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад нотолсон тохиолдолд энэ хуулийн 55.6-д заасан давуу эрх үйлчилнэ.

55.8. Энэ хуулийн 55.7-д заасан этгээд нь баримт нотолгоо гаргаагүй бол энэ хуульд заасан давуу эрхийг эдлэхгүй.

55.9. Бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах бол энэ хуульд заасныг үл харгалзан татвар, авлагаас түрүүлж уг хохирлыг барагдуулна.

56 дугаар зүйл. Үйл ажиллагааг шилжүүлэн авсан харилцан хамааралтай хоёрдогч этгээдийн татвар төлөх үүрэг

56.1. Татвар төлөгч үйл ажиллагаагаа харилцан хамаарал бүхий этгээдэд гэрээгээр шилжүүлж, шилжүүлж авсан этгээд нь татвар төлөгчтэй ижил, эсхүл ойролцоо төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд татварын өрийг татвар төлөгчийн хөрөнгөөс гаргуулахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн үйл ажиллагааг шилжүүлэн авсан этгээд татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд байна.

56.2. Энэ хуулийн 56.1-д заасан татвар төлөх үүрэг бүхий хоёрдогч этгээд нь шилжүүлж авсан хөрөнгийн хэмжээгээр татвар төлөх үүрэгтэй.

56.3. Татварын өр үүссэн хуулийн хугацаанаас өмнөх нэг жилийн хугацаанд татвар төлөгчийн үйл ажиллагааг шилжүүлэн авсан бол татвар төлөх хоёрдогч этгээдийн үүрэг үүснэ.

57 дугаар зүйл. Үнэгүй, эсхүл хэт бага үнээр өмчлөх эрх шилжүүлэн авсан хоёрдогч этгээдийн татвар төлөх үүрэг

57.1. Өртэй татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хураахад уг хөрөнгө хүрэлцэхгүй болох нь тогтоогдож, татварын өр үүссэн хуулийн хугацаанаас өмнөх нэг жилийн хугацаанд өртэй татвар төлөгч хөрөнгөө үнэгүй, эсхүл хэт бага үнээр бусдад шилжүүлсэн, бусдаас авах авлагаа хүчингүй болгох зэргээр гуравдагч этгээдэд ашигтай байдлыг бий болгосон бол тухайн этгээд нь доор дурдсан нөхцөлд татвар төлөх хоёрдогч этгээдийн үүрэг хүлээнэ:

57.1.1.гуравдагч этгээд өртэй татвар төлөгчтэй харилцан хамааралтай бол эрх олж авсан, эсхүл үүргээс чөлөөлөгдөхөд хүртсэн ашгийн хэмжээгээр;

57.1.2.гуравдагч этгээд өртэй татвар төлөгчтэй харилцан хамааралгүй бол мэдэгдэх хуудас хүргүүлэх үед уг этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлсэн хөрөнгө болон эрх нь бодитоор байгаа бол шилжүүлж авсан хөрөнгө, эрхийн үнийн дүнгээр.

58 дугаар зүйл.Хамтарсан үйл ажиллагаа эрхлэгч хоёрдогч этгээдийн татвар төлөх үүрэг

58.1.Доор дурдсан этгээд нь татвар төлөгчийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай хөрөнгийг эзэмшдэг боловч тухайн хөрөнгийн үр шимийг татвар төлөгч хүртдэг бөгөөд тухайн үйл ажиллагаанд хамаарах татварын өрийг хураахад татвар төлөгчийн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд уг этгээд нь татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд байна:

58.1.1.татвар төлөгч хувь хүн бол түүний гэр бүлийн гишүүд;

58.1.2.татвар төлөгч гэр бүлийн гишүүдийн оролцоотой хуулийн этгээд бол Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасан түүний гэр бүлийн гишүүн үндсэн хувь эзэмшигч, эсхүл хуулийн этгээдийн ажилтан.

58.2.Энэ хуулийн 59.1-д заасан этгээд нь тухайн хөрөнгийн хэмжээгээр татвар төлөх үүрэг хүлээнэ.

Тайлбар: “зайлшгүй шаардлагатай хөрөнгө” гэж уг хөрөнгө байхгүйгээр татвар төлөгч үйл ажиллагаагаа явуулах боломжгүй болохыг ойлгоно.

59 дүгээр зүйл.Татан буугдсан этгээдийн хөрөнгийг шилжүүлэн авсан хоёрдогч этгээдийн татвар төлөх үүрэг

59.1.Татан буугдсан татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хураахад уг хөрөнгө хүрэлцэхгүй бол уг этгээдийг татан буулгахад татварын өрийг төлөлгүй үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэн авсан этгээд татвар төлөх үүрэг бүхий хоёрдогч этгээд байна.

59.2.Энэ хуулийн 59.1-д заасан үлдэгдэл хөрөнгийг шилжүүлэн авсан этгээд нь шилжүүлсэн хөрөнгийн хэмжээгээр татвар төлөх үүрэг хүлээнэ.

60 дугаар зүйл.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өр хураах нийтлэг журам

60.1.Татвар төлөгчийн татварын өрийг төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс татварын өрийг гаргуулахаар тухайн этгээдэд доор дурдсан агуулга бүхий мэдэгдэх хуудас хүргүүлнэ:

60.1.1.өртэй татвар төлөгчийн нэр;

60.1.2.татварын өр үүссэн хугацаа, татварын төрөл, татварын өрийн дүн, татвар төлөх эцсийн хугацаа;

60.1.3.татварын өр төлөх газар, дансны нэр, дансны дугаар.

60.2.Энэ хуулийн 60.1.2-т заасан татварын өр төлөх эцсийн хугацаа нь мэдэгдэх хуудас хүргүүлснээс хойш ажлын 20 өдөр байна.

60.3.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээд энэ хуулийн 60.1.2-т заасан хугацаанд төлөөгүй бол татварын алба эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагааг явуулахаас бусад тохиолдолд нэхэмжлэх хүргүүлнэ.

60.4.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдэд энэ хуулийн 52, 53 дугаар зүйл нэгэн адил үйлчилнэ.

60.5.Хөрөнгийн үнэ цэнэ огцом буурах магадлалтайгаас бусад тохиолдолд татварын өрийг өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдийн хөрөнгөөс татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлж болохгүй.

60.6.Татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс өртэй татвар төлөгчийн татварын өрийг гаргуулсан бол тухайн өртэй татвар төлөгчөөс нэхэмжлэх эрхтэй.

60.7.Татварын өрийг татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдээс гаргуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

61 дүгээр зүйл.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоох

61.1.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өртэй татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг дараахь аргаар тогтооно:

61.1.1.хөрөнгийн байдлын талаар асуулга явуулах;

61.1.2.татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн хөрөнгийн байдлыг тогтоох;

61.1.3.ажлын байранд үзлэг, тооллого явуулах;

61.1.4.хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтыг гуравдагч этгээдийн мэдээлэл, лавлагаанд үндэслэн тогтоох.

61.2.Энэ хуулийн 61.1.1-д заасны дагуу дараахь этгээдэд асуулга явуулж, шаардлагатай тохиолдолд тухайн этгээдийн хөрөнгийн талаарх бичиг баримтыг шалгаж болно:

61.2.1.өртэй татвар төлөгч;

61.2.2.өртэй татвар төлөгчийн хөрөнгийг эзэмшигч гуравдагч этгээд, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гэж үзэх хангалттай шалтгаан бүхий гуравдагч этгээд;

61.2.3.өртэй татвар төлөгчтэй авлага, эсхүл өглөгийн харилцаатай этгээд, өртэй татвар төлөгчийн хөрөнгийг авсан гэж үзэх хангалттай шалтгаан бүхий этгээд;

61.2.4.өртэй татвар төлөгчийн хувь нийлүүлсэн, хөрөнгө оруулсан хуулийн этгээд.

61.3.Энэ хуулийн 61.1.3-т заасан үзлэг, тооллогыг явуулахдаа энэ хуульд заасан үзлэг, тооллого явуулах журмыг баримтална.

61.4.Энэ хуулийн 61.1.4-т заасан хөрөнгийн талаарх мэдээлэл, лавлагааг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас гаргуулж авна.

61.5.Татварын улсын байцаагч татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд өртэй татвар төлөгчийн оршин суугаа газар болон тухайн хөрөнгийг нуусан байж болзошгүй газарт үзлэг хийж болно.

61.6.Татварын улсын байцаагч үзлэг хийх явцад татварын өртэй этгээд болон гуравдагч этгээдээр хаалга, сейф, бусад агуулах савыг нээлгүүлэх, татвар төлөгч уг ажиллагааг хийхээс татгалзсан тохиолдолд татварын улсын байцаагч нээх шаардлагатай арга хэмжээг авч болно.

62 дугаар зүйл.Хөрөнгө битүүмжлэхэд баримтлах зарчим

62.1.Өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэхдээ барьцааны эрхгүй хөрөнгөөс эхлэн битүүмжлэх зарчим баримтална.

62.2.Энэ хуулийн 62.1-д заасан барьцааны эрхгүй хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй тохиолдолд барьцааны эрхтэй хөрөнгийг битүүмжилж болно.

62.3.Гуравдагч этгээдийн эрхтэй хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд тухайн гуравдагч этгээдээс татварын албанд ирүүлсэн хүсэлтийг үндэслэн өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгийг татварын өрийг хураах боломжтой, түргэн борлогдох болон гуравдагч этгээдийн эрхийн үйлчлэлгүй хөрөнгөөр сольж болно.

62.4.Татварын алба татварын өр хураах зардал бага байх, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгийг түрүүлж битүүмжлэх замаар татварын өрийг хураана.

62.5.Татварын өр хураахад шаардлагатайгаас бусад хөрөнгийг битүүмжилж болохгүй.

62.6.Битүүмжлэх хөрөнгийн үнийн дүн нь битүүмжлэх болон татварын өр хураах зардал, тухайн татварын өрөөс өмнө хураагдах барьцааны эрх бүхий гуравдагч этгээдэд төлөх өрийн нийлбэр дүнд хүрэхгүй болох нь тодорхой байгаа тохиолдолд тухайн хөрөнгийг битүүмжлэхгүй.

62.7.Татварын алба өртэй татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжилсэн бол битүүмжлэх актыг үйлдэнэ. Битүүмжилсэн хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, авлага, шаардах эрх бүхий биет бус хөрөнгө байгаа тохиолдолд битүүмжлэх актын хуулбарыг өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.

62.8.Удаан хадгалах боломжгүй, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн, хуучирч элэгдэн хэрэгцээ хангахгүй болсон эд зүйлийг битүүмжлэхгүй.

62.9.Хөрөнгө битүүмжлэх, түүнтэй холбогдох харилцааг зохицуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: “шаардах эрх бүхий биет бус хөрөнгө” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоонд оруулсан хөрөнгө, хувьцаа худалдах, худалдах авахаар брокер дилерт өгсөн захиалга зэрэг хамаарна.

63 дугаар зүйл.Битүүмжлэхийг хориглох хөрөнгө, орлого

63.1.Дараахь хөрөнгийг битүүмжлэхийг хориглоно:

63.1.1.өртэй татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн өдөр тутамд хэрэглээний хувцас, хэрэглэл;

63.1.2.өртэй татвар төлөгчийн байнга амьдран суугаа зөвхөн нэг орон сууц болон өртэй татвар төлөгчийн хүйтний улиралд хэрэглэж байгаа түлээ, түлш;

63.1.3.газар тариалан, мал аж ахуй, гар урлал эрхэлдэг этгээдийн хувьд амьжиргааны эх үүсвэр болдог үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эд зүйлс, тоног төхөөрөмж, мал, малын тэжээл.

63.1.4.гамшиг, аюулт үзэгдэл, осол, онцгой нөхцөл байдлын улмаас үзүүлж байгаа тусламж, тэтгэлэг, хандив;

63.1.5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмж;

63.1.6.донорын олговор;

63.1.7.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээний хүрээнд олгосон тусламж, дэмжлэг

64 дүгээр зүйл.Хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасны битүүмжлэл

64.1.Хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжлэхдээ татварын улсын байцаагч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд авч хэрэгжүүлнэ. Битүүмжлэлийн үйлчлэл нь татварын улсын байцаагч хөрөнгийг татварын албаны мэдэлд авснаар үүснэ.

64.2.Татварын улсын байцаагч мөнгөн хөрөнгө битүүмжилсэн тохиолдолд мөнгөн хөрөнгийн хэмжээгээр хязгаарлан өртэй татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

64.3.Үнэт цаас битүүмжилсэн тохиолдолд татварын алба тухайн үнэт цаасыг борлуулж татварын өрийг хурааж болно. Үнэт цаасыг борлуулсан орлогын хэмжээгээр өртэй татвар төлөгчөөс татварын өрийг хураасан гэж үзнэ.

64.4.Өртэй татвар төлөгчийн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг гэр бүлийн гишүүн, харилцан хамааралтай этгээдээс бусад гуравдагч этгээд эзэмшдэг бөгөөд тухайн гуравдагч этгээд нь шилжүүлэхээс татгалзсан тохиолдолд битүүмжлэхгүй.

64.5.Татвар төлөгчийн хөрөнгөөс татварын өрийг хурааж хүрэлцэхгүй бол татвар төлөгчийн гуравдагч этгээдэд эзэмшүүлсэн хөдлөх эд хөрөнгө болон үнэт цаасыг Татварын албаны мэдэлд авна.

64.6.Энэ хуулийн 64.5-д заасныг хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдэд хөрөнгийг ажлын 5 хоногийн дотор шилжүүлэх тухай бичгээр үүрэг болгож энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

64.7.Энэ хуулийн 64.6-д заасны дагуу гуравдагч этгээд хөрөнгийг шилжүүлээгүй тохиолдолд татварын улсын байцаагч тухайн хөдлөх эд хөрөнгө, үнэт цаасыг битүүмжилж болно.

64.8.Хөрөнгө шилжүүлэх үүрэг хүлээн авсан гуравдагч этгээд нь өртэй татвар төлөгчтэй гэрээ байгуулсан түрээсийн эрх, үнэгүй түрээслэх эрх болон бусад хөдлөх хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олох эрхэд суурилсан эзэмшлийн эрхтэй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл гэрээг цуцлахгүйгээр 3 сараар хязгаарлан тухайн хөдлөх хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох 2 нөхцөлөөс аль нэгийг нь сонгох боломжтой.

64.9.Татварын алба шаардлагатай тохиолдолд битүүмжилсэн хөдлөх хөрөнгө, үнэт цаасыг өртэй татвар төлөгч, эсхүл тухайн хөрөнгийг эзэмшиж буй гуравдагч этгээдэд хадгалуулж болно. Хадгалсан газар нь энэ хуулийн 64.1-д зааснаас үл хамааран лацдах, олон нийтэд мэдээлсэн болон бусад битүүмжлэл тодорхойлох аргаар битүүмжилсэн болохыг илэрхийлсэн тохиолдолд битүүмжлэл үйлчилж эхэлсэн гэж үзнэ.

64.10.Энэ хуулийн 64.9-д заасны дагуу битүүмжилсэн хөрөнгийг хадгалуулсан тохиолдолд татварын өр хураахад хүндрэл үүсэхгүй нь тодорхой бол татвар төлөгчид уг хөрөнгийг ашиглах, эсхүл ашиг орлого олохыг зөвшөөрч болно.

64.11.Татварын улсын байцаагч үнэт цаасыг битүүмжлэх актыг тухайн үнэт цаасыг арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдэд хүргүүлж гүйцэтгэнэ.

Тайлбар: “мэдэлд авах” гэж татварын алба татварын өртэй этгээдийн хөрөнгийн өмчлөл, эзэмшлийг өөрчлөхгүйгээр тухайн хөрөнгийг захиран зарцуулах, эзэмших ашиглах эрхийг хязгаарлан битүүмжилсэн тухай тэмдэглэгээ үйлдэх арга хэмжээг ойлгоно.

65 дугаар зүйл.Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах

65.1.Үл маргах журмаар татвар төлөгчийн банкин дахь дансыг битүүмжлэхэд дараахь журмыг баримтална:

65.1.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкн дахь мөнгөн хөрөнгөөс хураах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг татварын албаны даргаар батлуулан харилцагч банкинд хүргүүлнэ;

65.1.2.энэ хуулийн 65.1.1-д заасан битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, харилцагч банкны нэр,

хаяг, татварын өр хураах үндэслэл, татварын өрийн дүн, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох тухай заана;

65.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд өртэй татвар төлөгчийн нэг буюу түүнээс дээш дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлнэ;

65.1.4.банкин дахь мөнгөн хөрөнгө нь татварын өрийг төлөхөд хүрэлцэхээргүй бол уг данснаас төлөгдөх шүүхийн шийдвэрээр төлөх үүрэг бүхий авлагыг хамруулсан бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож, тухайн данснаас татварын өрийг битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлнэ.

66 дугаар зүйл.Авлага битүүмжлэх

66.1.Авлага битүүмжлэх ажиллагааг өртэй татвар төлөгчид өглөгтэй гуравдагч этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлснээр хэрэгжүүлнэ. Авлага битүүмжлэх ажиллагаа авлага битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргэснээр эхэлнэ.

66.2.Авлагыг нийт дүнгээр нь битүүмжлэх боловч татварын өр авлагаас бага тохиолдолд хэсэгчлэн битүүмжилж болно.

66.3.Цалин хөлс, болон тэдгээртэй адилтгах байнгын орлогыг битүүмжлэх ажиллагаа битүүмжилсний дараа орж ирэх орлогоос хураавал зохих татварын өрийг бүрэн хураах хүртэл хугацаанд үргэлжилнэ.

66.4.Татварын улсын байцаагч авлага битүүмжлэхдээ шаардлагатай тохиолдолд холбогдох бичиг баримтыг хурааж болно.

66.5.Татварын улсын байцаагч татварын өрийг битүүмжилсэн авлагаас гаргуулан хураах эрхтэй.

66.6.Цалин хөлс (цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого хамаарна)-ийг битүүмжлэхэд дараахь журмыг баримтална.

66.6.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн цалин хөлснөөс гаргуулахын тулд цалин хөлсийг олгох үүрэгтэй хувь хүн, хуулийн этгээдэд битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлэх;

66.6.2.битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, битүүмжлэгдсэн цалин хөлсийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, татвар төлөгчид цалин хөлсийг олгох хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын өрийн дүн, төлбөр хийх хуваарь, битүүмжлэх мэдэгдэх хуудсыг гардуулсан огноог тус тус заах;

66.6.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан хувь хүн, хуулийн этгээд нь цалин хөлсийг олгох өдөр төлбөрийн хуваарийн дагуу суутгаж, суутгал хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх;

66.6.4.татварын өрийг шүүхийн шийдвэрээр төлөх үүрэгтэй авлагыг хамруулсан бусад авлагаас түрүүлж шилжүүлэх;

66.6.5.өртэй татвар төлөгч ажлаас чөлөөлөгдсөн, эсхүл халагдсан бол ажлын 7 өдрийн дотор татварын өрд суутгасан дүн болон өртэй татвар төлөгчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг татварын албанд хүргүүлэх;

66.6.6.цалин хөлсний тухайд өртэй татвар төлөгч болон түүний гэр бүлийн гишүүдэд ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний орлоготой тэнцэх хэмжээнээс илүү гарсан хэсгийг хураах.

66.7.Татвар төлөгч зөвшөөрсөн тохиолдолд энэ хуулийн 66.6.6 дахь заалтыг хэрэгжүүлэхгүй байж болно

67 дугаар зүйл.Үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх

67.1.Үл хөдлөх эд хөрөнгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох харилцааг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

67.1.1.үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэх хуудас хүргүүлэн хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд битүүмжлэх ажиллагаа нь тухайн битүүмжлэх хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхэлнэ;

67.1.2.Татварын алба үл хөдлөх эд хөрөнгийн битүүмжилсэн талаар бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Бүртгэлийг битүүмжлэх хуудас хүргүүлэхээс өмнө хийсэн бол энэ хуулийн 67.1.1-д заасныг үл хамааран бүртгүүлснээр битүүмжлэх ажиллагаа үүснэ;

67.1.3.татвар төлөгч битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах, ашиг орлого олох боломжтой боловч үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэнийг огцом бууруулах магадлалтай үйлдэл хийх гэж байгаа нь тогтоогдсон тохиолдолд татварын алба тухайн үл хөдлөх хөрөнгийн ашиглалт болон ашиг олох үйл ажиллагааг хязгаарлаж болно. Энэ заалтыг битүүмжилсэн үл хөдлөх эд хөрөнгийг ашиглах болон ашиг орлого олох эрхтэй гуравдагч этгээдэд хэрэглэнэ.

67.2.Агаарын хөлгийг битүүмжлэх, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн агаарын хөлгийг түр зогсоох ажиллагааг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

67.2.1.агаарын хөлгийг битүүмжлэхдээ энэ хуулийн 67.1.1, 67.1.2-д заасныг баримтална;

67.2.2.нислэг үйлдэхэд бэлэн байгаа агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг татварын албаны шийдвэрээр түр хугацаагаар зогсоож болно;

67.2.3.татварын өр хураах үйл ажиллагаанд шаардлагатай бол битүүмжилсэн агаарын хөлгийг хамгаалах, хадгалах арга хэмжээ авч болно;

67.2.4.энэ хуулийн 67.2.3-т заасан арга хэмжээг битүүмжлэх хуудас хүргүүлэхээс өмнө авсан бол тухайн арга хэмжээг авах үед битүүмжлэх ажиллагаа эхэлнэ;

67.2.5.Татварын албаны даргын шийдвэрээр агаарын хөлгийг битүүмжилсэн, эсхүл энэ хуулийн 67.2.2-д заасны дагуу зогсоосон агаарын хөлгийг хүндэтгэх шалтгаантай бол хөдөлгөх зөвшөөрөл олгож болно.

67.3.Автомашин, барилгын тоног төхөөрөмжийн битүүмжлэх ажиллагаа, үйлчлэлийн хугацаа болон битүүмжилсэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хөдөлгөх, ашиглах ажиллагааг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

67.3.1.улсын бүртгэлд бүртгэлтэй автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэхдээ энэ хуулийн 67.1.1, 67.1.2, 67.1.2-т заасныг баримтална;

67.3.2.автомашин, барилгын тоног төхөөрөмж битүүмжлэхэд энэ хуулийн 67.2.3, 67.2.4-т заасныг дагаж мөрдөнө;

67.3.3.Татварын албаны шийдвэрээр автомашин, барилгын тоног төхөөрөмжийг битүүмжлэх бөгөөд энэ тохиолдолд өртэй татвар төлөгч тухайн хөрөнгийг татварын албаны мэдэлд шилжүүлж болно;

67.3.4.энэ хуулийн 67.3.3-т заасны дагуу автомашин, барилгын тоног төхөөрөмжийг татварын албаны мэдэлд шилжүүлсэн тохиолдолд энэ хуулийн 64.1, 64.5-д заасныг дагаж мөрдөнө;

67.3.5.татварын алба энэ хуулийн 67.3.3-т заасны дагуу мэдэлдээ авсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг өртэй татвар төлөгч болон тухайн хөрөнгийг эзэмшиж байгаа гуравдагч этгээдэд хадгалуулж болно. Энэ тохиолдолд, лацдах, болон бусад олон нийтэд мэдэгдэх аргыг хэрэглэн автомашин, барилгын тоног төхөөрөмжийг Татварын алба мэдэлдээ авсныг тодорхой болгоно;

67.3.6.Татварын алба энэ хуулийн 67.3.3, 67.3.5-д заасны дагуу мэдэлдээ авсан, эсхүл хадгалуулсан автомашин, барилгын тоног төхөөрөмжийг хүндэтгэн үзэх шалтгаантай бол ашиглуулахыг зөвшөөрч болно. Ашиглуулахыг зөвшөөрөөгүй тохиолдолд ашиглуулахгүй байх талаар зохих арга хэмжээг авна.

Тайлбар: “агаарын хөлөг хадгалах, хамгаалах” гэж тухайн агаарын хөлгийг нислэг үйлдэх боломжгүй болгож байрлуулах, эсхүл агаарын хөлгийн бүртгэлийн баримт бичиг бусад хөдөлгөөнд оролцоход шаардагдах бичиг бичиг баримтыг хураан авахыг хэлнэ.

68 дугаар зүйл.Биет бус хөрөнгө битүүмжлэх

68.1.Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээд ашиглаагүй тохиолдолд уг хөрөнгийг битүүмжлэх ажиллагааг дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

68.1.1.патентын эрх, зохиогчийн эрх болон бусад гуравдагч этгээд ашиглаагүй хөрөнгийг битүүмжлэхдээ өртэй татвар төлөгчид битүүмжлэх хуудсыг

хүргүүлнэ. Энэ тохиолдолд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэх хуудсыг өртэй татвар төлөгчид хүргүүлснээр эхэлнэ;

68.1.2. татварын албаны даргын шийдвэрээр хөрөнгийн эрхийн шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийг битүүмжилсэн тохиолдолд холбогдох байгууллагад бүртгүүлнэ;

68.1.3. энэ хуулийн 68.1.2-т заасан битүүмжлэх ажиллагааны бүртгэл нь битүүмжлэх хуудас хүргүүлэхээс өмнө хийгдсэн тохиолдолд энэ хуулийн 68.1.1-д зааснаас үл хамааран тухайн битүүмжлэх ажиллагааг бүртгүүлснээр үйлчлэл нь үүснэ;

68.1.4. захиран зарцуулах эрхийн хязгаарлалтыг бүртгүүлэх шаардлагатай хөрөнгийн битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь энэ хуулийн 68.1.1, 68.1.3-т зааснаас үл хамааран бүртгүүлэхэд үүснэ.

68.2. Биет бус хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн ашиглалт байгаа бол уг хөрөнгийг битүүмжлэх үйл ажиллагаа, үйлчлэлийн хугацаанд дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

68.2.1. хэвлэх эрх, хувьцаа болон бусад гуравдагч этгээдийн ашиглалт бүхий хөрөнгийг битүүмжлэхдээ гуравдагч этгээдэд битүүмжлэх хуудсыг хүргүүлэн хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд битүүмжлэх ажиллагааны үйлчлэл нь тухайн битүүмжлэх хуудсыг гуравдагч этгээдэд хүргүүлснээр эхэлнэ;

68.2.2. энэ хуулийн 68.2.1-т заасан хөрөнгийг шилжүүлэх зорилгоор бүртгүүлэх шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 68.1.2, 68.1.3-т заасныг баримтална.

69 дүгээр зүйл. Татварын өр хураахаар бусад байгууллагад суутгах хүсэлт гаргах

69.1. Татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн бол татварын алба тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа байгууллагад татварын өрийг суутгах хүсэлтийг хүргүүлнэ. Суутгах хүсэлт хүргүүлснээр тухайн татвар төлөгчид болон хөрөнгийн барьцаалсан эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

69.2. Татвар төлөгчид татварын өр хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд хялбар, гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүй өөр хөрөнгөтэй, тухайн хөрөнгөөс татварын өрийг хураах боломжтой болох нь тогтоогдвол татварын алба суутгах хүсэлтийг гаргахгүй.

70 дугаар зүйл. Битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа

70.1. Татварын алба татварын өр хураах зорилгоор битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар, эсхүл шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлж, мөнгийг холбогдох төсөвт төвлөрүүлнэ. Дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

70.2.Татварын алба битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах тухайгаа дуудлага худалдаа явуулахаас ажлын 10 өдрийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар нээлттэй зарлана. Дуудлагаар худалдах хөрөнгөтэй холбогдсон их хэмжээний хадгалалтын зардал гарч, хөрөнгийн үнэ, цэнийг бууруулах магадлалтай бол дээрх хугацааг богиносгож болно.

70.3.Татварын алба битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаанд оруулахдаа тухайн хөрөнгийн анхны үнийг тогтооно. Хөрөнгийн анхны үнийг татварын өр болон тухайн хөрөнгийн зах зээлийн үнэтэй уялдуулж тогтооно. Шаардлагатай тохиолдолд хөрөнгийн анхны үнийг тогтооход мэргэжлийн байгууллага болон мэргэжилтний туслалцаа авч болно.

70.4.Дуудлага худалдаанд оролцох хүсэлтэй этгээд нь татварын албаны тогтоосон дэнчинг төлнө. Дуудлага худалдаанд оролцогч дэнчинг төлөөгүй тохиолдолд дуудлага худалдаанд оролцох эрхгүй.

70.5.Шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг дараахь нөхцөлд явуулна:

70.5.1.тухайн хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулахад тохиромжгүй, эсхүл түргэн гэмтэж муудахаар байх;

70.5.2.хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах бүрэн боломжтой байх;

70.5.3.дуудлага худалдааг зохион байгуулсан боловч оролцогч байхгүй, худалдах үнэ нь хөрөнгийн анхны үнэд хүрэхгүй, эсхүл худалдан авагч төлбөр төлөх хугацаандаа төлбөрөө төлөөгүйгээс худалдан авах шийдвэрээ цуцалсан.

70.6.Татвар төлөгч мөнгөн хэлбэрт шилжүүлэх өөрийн хөрөнгийг шууд болон шууд бус байдлаар худалдан авах эрхгүй. Татварын албаны татварын улсын байцаагч, ажилтан, албан хаагч шууд болон шууд бусаар худалдан авах эрхгүй.

70.7.Дуудлага худалдаагаар болон шууд гэрээгээр борлуулсан хөрөнгийн орлого нь татварын өрийг хураахад хүрэлцэхээргүй бол татвар төлөгч уг татварын өрийн үлдсэн хэсгийг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

70.8.Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

71 дүгээр зүйл.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилах

71.1.Мөнгөн хэлбэрт шилжүүлсэн хөрөнгийг хуваарилахдаа дараахь зарчмыг баримтална:

71.1.1.татварын алба битүүмжилсэн хөрөнгийн борлуулсан орлогын дүн болон үнэт цаас, авлага, эсхүл биет бус хөрөнгийн битүүмжлэлийн дагуу гуравдагч этгээдээс хүлээн авсан мөнгөн хөрөнгийг (цаашид “шилжүүлсэн мөнгөн

хөрөнгө” гэх) битүүмжлэлтэй татвар, суутгах хүсэлт гаргасан татвар, битүүмжилсэн хөрөнгөнд хамаарах барьцаа, ипотекийн эрх, түрүүлж авах давуу эрхийн дагуу барьцаалагдсан авлагад хуваарилна;

71.1.2.битүүмжилсэн мөнгөн хөрөнгө болон суутгалын хүсэлтээр хүлээн авсан мөнгөн хөрөнгийг тухайн битүүмжлэл, эсхүл суутгалын хүсэлтэд хамаарах татварт шилжүүлнэ;

71.1.3.энэ хуулийн 71.1.1, 71.1.2-т заасны дагуу хуваарилсан мөнгөн хөрөнгөөс үлдсэн тохиолдолд тухайн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг өртэй татвар төлөгчид олгоно;

71.1.4.шилжүүлсэн мөнгөн хөрөнгө нь энэ хуулийн 71.1.1-д заасан татвар болон бусад авлагын нийт үнийн дүнд хүрэлцэхгүй бол энэ хуульд заасан татварын давуу эрхийн зарчим, Иргэний хууль болон бусад хуульд заасан дараалал, үнийн дүнг тогтоон хуваарилна;

71.1.5.энэ хуулийн 71.1.1, эсхүл 71.1.2-т заасны дагуу татварын хуваарилалт хийгдсэн мөнгөн хөрөнгийг татвар, алданги, торгуульд хуваарилахдаа энэ хуульд заасан татвар өр барагдуулах дарааллыг баримтална.

71.2.Авлагатай этгээдээс татварын албанд гаргасан хүсэлтийг дараахь байдлаар хянана:

71.2.1.энэ хуулийн 71.1.1-д заасан авлагатай этгээд хөрөнгө худалдах шийдвэр гаргахаас өмнө татварын албанд хандан авлагын хүсэлт гаргана;

71.2.2.татварын алба энэ хуулийн 71.2.1-д заасан авлагын хүсэлтийг хүлээн авч, нягтална. Энэ тохиолдолд бүртгэгдсэн барьцаат авлагын эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах давуу эрх болон бүртгэх боломжгүй барьцаа, эсхүл түрүүлж авах давуу эрх нь мэдэгдэж байгаа этгээд авлагын хүсэлт гаргаагүй тохиолдолд татварын албаны дарга тухайн авлагын хэмжээг тодорхойлно;

71.2.3.энэ хуулийн 71.1.1-д заасан битүүмжилсэн хөрөнгийн барьцаат эрх, ипотекийн зээлийн эрх, түрүүлж авах эрхийг нь барьцаалах эрх бүхий авлагын хувьд энэ хуулийн 71.2.2-т заасан авлагаас бусад авлагатай этгээд борлуулах шийдвэр гаргах хүртэл авлагын хэмжээтэй холбоотой хүсэлт гаргаагүй бол тухайн авлагатай этгээдэд хуваарилахгүй.

71.3.Хуваарилалтын тооцооллын акт үйлдэх, шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгоход дараахь байдлаар хэрэгжүүлнэ:

71.3.1.Татварын алба энэ хуулийн 71.1-д заасны дагуу хуваарилахдаа хууль тогтоомжийн дагуу хуваарилах авлага, энэ хуулийн 71.2.2-т заасны дагуу татварын албаны тодорхойлсон дүн, энэ хуулийн 71.3.2-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан хуваарилалтын тооцооллын акт үйлдэн, түүний хуулбарыг мөнгөн хөрөнгийг шилжүүлснээс хойш ажлын 3 өдөрт багтаан авлагын хүсэлт гаргасан этгээд болон энэ хуулийн 71.2.2-д заасны дагуу авлагын хэмжээг тодорхойлсон авлагатай этгээд, өртэй татвар төлөгчид илгээнэ;

71.3.2.шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг авлагатай этгээдэд олгох хугацаа нь хуваарилалтын тооцооллын актын хуулбарыг хүргүүлснээс хойш ажлын 7 өдрийн дараагийн өдөр гэж үзнэ;

71.3.3.татварын алба шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн хуваарилалтын тооцооллын актын хугацааг үндэслэн олгоно. Хуваарилалтын тооцооллын акттай холбоотой санал гомдлыг шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг олгохоос өмнө гаргаж болно.

72 дугаар зүйл.Татварын өр хураах үйл ажиллагааг шилжүүлэх

72.1.Татварын алба битүүмжилбэл зохих хөрөнгө болон битүүмжилсэн хөрөнгө нь тухайн албаны харьяаллын бус байвал тухайн хөрөнгө байршиж байгаа татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

72.2.Татварын алба битүүмжилсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай бол бусад татварын албанд татварын өр барагдуулах үйл ажиллагааг шилжүүлж болно.

72.3.Энэ хуулийн 72.1, 72.2-т заасны дагуу шилжүүлсэн тохиолдолд шилжүүлэн авсан татварын алба энэ тухай өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

73 дугаар зүйл.Бусад хууль тогтоомжид заасан эрх хязгаарлах болон түдгэлзүүлэх арга хэмжээ авах

73.1.Татварын алба энэ хуульд заасан татварын өрийг хураах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө татварын өрийн хэмжээнээс хамаарч татвар төлөгчид сануулах байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг авч болно.

73.2.Доор дурдсан нөхцлүүд нэгэн зэрэг бий болсон тохиолдолд Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.7-д зааснаар татварын алба татварын өртэй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татварын өрөө төлж дуустал хилээр үл нэвтрүүлэх, саатуулахаар улсын хил хамгаалах байгууллагад хандах эрхтэй:

73.2.1.татварын өртэй этгээдэд татварын өр барагдуулах хөрөнгө, авлагагүй;

73.2.2.татварын өрийн хэмжээ нь 20 сая төгрөг ба түүнээс дээш байх.

73.3.Энэ хуулийн 73.1-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх журмыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

74 дүгээр зүйл.Татварын албаны үндэслэлгүй илүү хураасан мөнгөн хөрөнгө

74.1.Нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгосон буюу өөрчилсний улмаас бүрэн буюу хэсэгчлэн буцаан олгох татвар, торгууль, алдангийг татварын буцаан олголтын актаар баталгаажуулна.

74.2.Энэ хуулийн 74.1-д заасан актаар баталгаажуулснаас хойш ажлын 45 өдрийн дотор илүү төлсөн татварыг буцаан олгоно.

74.3.Энэ хуулийн 74.1-д заасан мөнгөн хөрөнгийг татвар төлөгч зөвшөөрвөл энэ хуулийн 48.1.2, 48.1.3-т заасан журмаар шийдвэрлэх бөгөөд энэ нь тухайн илүү төлөлтийн дүнд энэ хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу алданги тооцохгүй байх үндэслэл болохгүй.

74.4.Энэ хуулийн 74.1-д заасан буцаан олгох дүнг татвар төлөгч эс зөвшөөрвөл татварын буцаан олголтын актыг гардан авснаас хойш маргаан таслах зөвлөлд 30 хоногийн дотор гомдол гаргаж болно.

75 дугаар зүйл.Алданги

75.1.Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тус тус алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан дараахь зарчмыг үндэслэн тогтооно:

75.1.1.татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар;

75.1.2.татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн арилжааны банкнаас олгож байгаа зээлийн хүүгийн дундаж байхаар.

75.2.Алданги тооцох хугацааг доор дурдсанаар тодорхойлно:

75.2.1.татварын хууль тогтоомжид заасны дагуу тухайн татварыг төлбөл зохих өдрөөс түүнийг төлсөн өдрийг хүртэлх хоногийн тоогоор;

75.2.2.Татварын албаны илүү хураасан энэ хуулийн 75.1-д заасан мөнгөн хөрөнгийг хураасан өдрөөс эхлэн түүнийг буцаан олгох шийдвэр гарсан өдөр хүртэлх хоногийн тоогоор.

75.3.Татварын алданги, торгуульд алданги тооцохгүй.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБАНЫ ТОГТОЛЦОО

76 дугаар зүйл.Монголын татварын алба

76.1.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

76.2.Монголын татварын алба /цаашид “Татварын алба” гэх/ нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын газар, хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагчаас бүрдэнэ.

76.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь том татвар төлөгчтэй харилцах, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи, сургалт, татварын үйлчилгээ хариуцсан харьяа нэгжтэй байж болно.

76.4.Татварын алба нь өөрийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, татварын болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

76.5.Татварын алба нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

77 дугаар зүйл.Татварын албаны чиг үүрэг

77.1.Татварын алба дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

77.1.1.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах;

77.1.2.татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

77.1.3.төсвийн орлогыг бүрдүүлэх.

77.2.Татварын алба нь татвар төлөгчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэн, татвар ногдуулах, төлөх, тайлагнах үйл ажиллагаатай холбогдуулан түүнд дараахь хэлбэрээр хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, туслалцаа үзүүлэх, заавар өгөх үүрэгтэй:

77.2.1.татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх аргачлал, заавар, чиглэл, журам, гарын авлага, маягт, мэдээллээр татвар төлөгчийг хангах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;

77.2.2.татвар төлөгчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу тодорхой мэдээлэлд үндэслэн тухайн асуудалд хамаарах заавар, тодруулга, лавлагаа өгөх;

77.2.3.татварын хууль тогтоомжийн талаар татвар төлөгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлж, биечлэн, утсаар, цахимаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

77.3.Энэ хуулийн 77.2.1-д заасны дагуу татвар төлөгчид хүргүүлсэн чиглэлийг доод шатны татварын алба нь хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд уг чиглэлийг хэрэгжүүлэх асуудлаар чиглэл гаргасан этгээдээс зохих тодруулгыг авч болно.

77.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах эрхтэй.

77.5.Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх харилцааг Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.

77.6.Татварын алба татварын хууль, тогтоомжийг олон нийтэд танин мэдүүлэх зорилгоор татварын хууль тогтоомж, заавар, аргачлалын талаар сургалт зохион байгуулна.

77.7.Татварын алба цахим хуудсандаа татварын хууль тогтоомжийг байршуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтийг хамарсан сурталчилгаа, сургалт, мэдээллийн нэвтрүүлэг зохион байгуулах, нийтлэл гаргана.

77.8.Татварын алба бүх нийтийн татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

78 дугаар зүйл.Татварын албаны үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, хориглох зүйл

78.1.Татварын алба нь үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

78.1.1.хууль дээдлэх;

78.1.2.бусдын нөлөөнд үл автах;

78.1.3.татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, түүнийг хэрэгжүүлэх боломжийг хангах, тэдэнд итгэл үзүүлэх;

78.1.4.доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагадаа шууд захирагдах.

78.2.Татвар төлөгч нь хууль тогтоомж болон татварын албанаас баталсан дүрэм, журам, заавар, аргачлал, маягт, зөвлөмжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

78.3.Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтан татварын алба, татварын улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

78.4.Татварын алба, татварын улсын байцаагч энэ хуулийн 78.3-т заасныг зөрчсөн этгээдийн талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж, учирсан хохирлыг барагдуулахаар шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

78.5.Татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

78.6.Хуульд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээхийг хориглоно.

78.7.Татварын алба бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон ажиллах бөгөөд татварын алба энэхүү үүргээ хэрэгжүүлэхгүй бол татвар төлөгч хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг шаардах эрхтэй.

78.8.Татварын алба, татварын улсын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

78.9.Татварын алба, татварын улсын байцаагч, хураагч хуульд заасны дагуу татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх, татварын ногдлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд оролцохгүй.

78.10.Татварын улсын байцаагч, хураагч нь хувийн зорилгоор татвар төлөгчтэй холбогдож түүнд аливаа хэлбэрээр зөвлөгөө өгөх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайланг гаргах, аудит хийх, татвараас зайлсхийхэд туслах, шаардахыг хориглоно.

79 дүгээр зүйл.Татварын албаны удирдлага, түүний бүрэн эрх

79.1.Татварын алба нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

79.2.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, аймаг, нийслэлийн татварын газар, хэлтэс татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, дүүргийн татварын хэлтэс, сумын татварын хэлтэс, тасаг, татварын улсын байцаагч, хураагч нь аймаг, нийслэлийн татварын газар, хэлтсийн удирдлага доор тус тус ажиллана.

79.3.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, төсөв хөрөнгөөр хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

79.4.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргыг татварын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

79.5.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

79.6.Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн даргыг санхүү, эдийн засаг, эсхүл нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй иргэнийг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулна.

79.7.Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь татварын улсын ерөнхий байцаагч байх бөгөөд энэ хуулийн 78 дугаар зүйлд заасан эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

79.7.1.татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрхийн хэрэгжилтийн ажлыг зохион байгуулалтын удирдлага болон төсөв хөрөнгөөр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;

79.7.2.татварын хууль тогтоомжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг мөр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

79.7.3.энэ хууль болон татварын бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд тушаал гаргах, нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлал, акт, маягтын загварыг баталж мөрдүүлэх, зөвлөмж гаргах;

79.7.4. татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл хүлээлгэх;

79.7.5. татварын хууль тогтоомжийн төсөл боловсруулахад оролцох, тэдгээрийг татварын албанаас хэрэгжүүлэх арга, хэлбэр, боломжийн талаарх саналаа бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

79.7.6. орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээрийн төсөлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

79.7.7. татварын алба, улсын байцаагчийн шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл өөрчлөх, хүчингүй болгох;

79.7.8. татварын албаны ажилтныг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл хүлээлгэх;

79.7.9. татварын албаны дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

79.7.10. хууль тогтоомжид заасны дагуу татварын мэргэшсэн зөвлөх бэлтгэх, эрх олгох ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

79.7.11. татварын улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, татварын улсын байцаагчийн эрх олгох;

79.7.12. татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;

79.7.13. татварын албыг гадаад, дотоодод болон шүүх, арбитраж төлөөлөх;

79.7.14. Татварын албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулж, батлах,

79.8. Татварын ерөнхий газрын дарга бөгөөд татварын улсын ерөнхий байцаагч нь энэ хуулийн 79.7.3, 79.7.4, 79.7.8, 79.7.12, 79.7.14-т зааснаас бусад 79.7 дахь хэсэгт заасан бүрэн эрхээс нийслэл, аймаг, дүүргийн татварын албаны удирдлагад тушаалаар шилжүүлж болно.

79.9. Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын эзгүйд түүнийг дэд дарга орлоно.

80 дугаар зүйл. Татварын алба, татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичиг

80.1. Татварын албанаас татвар хураах, хяналт тавих, татварын шалгалт хийхтэй холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэрийг мэдэгдэл, шаардах хуудас, битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, нөхөн ногдуулалтын акт, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулсан акт, илтгэх хуудас, тэмдэглэл, татварын буцаан олголтын акт, нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, мэдэгдэх хуудас, шаардлага, суутгалын хүсэлт, хуваарилалтын тооцооллын акт, зарлан дуудах хуудас битүүмжлэх мэдэгдэх хуудас, зөвлөмж болон татварын албаны үйлдэх бусад баримт бичиг үйлдэн баталгаажуулна.

80.2.Энэ хуулийн 80.1-д заасан баримт бичигт үйлдсэн холбогдох албан тушаалтны нэр, гарын үсэг, гаргасан шийдвэр, тухайн шийдвэрийг гаргах үндэслэл, биелүүлэх хугацаа, уг баримтыг гардуулсан он, сар, өдрийг тусгана.

80.3.Энэ хуулийн 80.1-д заасан баримт бичгийг татвар төлөгчид биечлэн гардуулсан болон түүний оршин байгаа, эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар шууданд хийснээр, эсхүл цахимаар илгээснээр уг баримт бичгийг татвар төлөгчид гардуулсанд тооцох бөгөөд татвар төлөгчийн оршин байгаа газрыг холбогдох бүртгэх байгууллагад хамгийн сүүлд бүртгүүлсэн хаягаар тодорхойлно.

80.4.Энэ хуулийн 80.1-д заасан баримт бичгийг дараахь үндэслэл, журмын дагуу үйлдэнэ:

80.4.1.татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичих бөгөөд түүнд татвар төлөгчийн болон татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, татварын албанд ирэх хугацаа, уг мэдэгдэл үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг тусгана;

80.4.2.татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардах хуудас бичих бөгөөд түүнд шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгаж, хариу өгөх хугацаа, уг шаардах хуудсыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгана;

80.4.3.татвар төлөгчид хууль тогтоомжийн дагуу татварыг нөхөн ногдуулж хариуцлага хүлээлгэх, алданги тооцоход нөхөн ногдуулалтын акт үйлдэх бөгөөд түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэслэл, уг актыг үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгана;

80.4.4.татварын хяналт шалгалтаар татварын хууль тогтоомж зөрчөөгүй нь тогтоогдвол илтгэх хуудас үйлдэх бөгөөд түүнд шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч, татвар төлөгч гарын үсэг зурж, үйлдсэн он, сар, өдөр, дугаарыг тусгана;

80.4.5.татварын алба бүрэн эрхийнхээ хүрээнд татвар төлөгчийн байр, агуулахад үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх, хөрөнгө битүүмжлэх, ярилцлага хийх, нөхөн ногдуулалтын актыг гардуулахдаа тэмдэглэл үйлдэх ба түүнд хяналт шалгалт хийсэн холбогдох нэгжийн дарга болон татварын улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэглэл үйлдсэн он, сар, өдөр, татвар төлөгчийн хаягийг тодорхой тусгаж, шаардлагатай гэж үзвэл тэмдэглэл үйлдэхэд байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулна;

80.4.6.татварын албаны үндэслэлгүйгээр илүү хураасан мөнгөнд алданги тооцож татвар төлөгчид олгоход татварын буцаан олголтын акт үйлдэж, буцаан олгох дүнг тогтоосон татварын улсын байцаагч гарын үсэг зурна. Түүнд мөнгөн дүн, алданги тооцсон хугацаа, тооцсон алдангийн дүн, илүү төлсөн мөнгө, алдангийг тусгана;

80.4.7.татварын алба татвар төлөгчийн татварын өрийг төлүүлэхээр нэхэмжлэх, урьдчилан нэхэмжлэх хуудас, татвар төлөх хоёрдогч үүрэг бүхий

этгээд, батлан даагчаас гаргуулахдаа мэдэгдэх хуудас, татварын өрийг үл маргах журмаар болон авлагаас гаргуулахдаа битүүмжлэх мэдэгдэх хуудас бичих бөгөөд түүнд татварын өрийн хэмжээ, төлөх эцсийн хугацаа, татварын өрийг төлөх банкны данс болон татвар төлөгчийн харилцах банк болон дансны дугаар, татвар төлөгчийн болон татвар төлөгчийн нэрийн өмнөөс татварын өрийг төлөх хувь хүн, хуулийн этгээдийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдөр зэрэг энэ хуульд заасан мэдээллийг тусгана;

80.4.8. татварын алба энэ хуулийн 29 дугаар зүйлийг хэрэгжүүлэхээр шаардлага үйлдэх бөгөөд түүнд шаардлага бичсэн шалтгаан, нөхцөл, татвар төлөгчийн, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн болон шаардлага үйлдсэн улсын байцаагчийн нэр, гарын үсэг, үйлдсэн болон гардуулсан он, сар, өдрийг бичнэ;

80.4.9. татварын өрийг татвар төлөгчийн хөрөнгөөс гаргуулахдаа энэ хуульд заасны дагуу битүүмжлэх акт болон битүүмжлэлийн хуудас үйлдэнэ. Битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудаст татварын өрд хамаарах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа болон хэмжээ, битүүмжилсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар, байршил; өртэй татвар төлөгчийн нэр, хаягийг тусгана;

80.4.10. өртэй татвар төлөгчийн хөрөнгийг албадан гүйцэтгэх ажиллагаагаар мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаа эхлүүлсэн байгууллагад татварын өрийг суутгахаар суутгалын хүсэлтийг хүргүүлнэ. Суутгалын хүсэлтэд өртэй татвар төлөгчийн нэр, хаяг, суутгуулах татварын тайлант хугацаа, татварын төрөл, төлөх хуулийн хугацаа, хэмжээ, суутгалын хүсэлтэд хамаарах албадан гүйцэтгэлээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эхлүүлсэн хөрөнгийн нэр төрөл, тоо, шинж чанар болон хаягийг тусгана;

80.4.11. татварын өр хураах зорилгоор татвар төлөгчийн хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг хуваарилахад хуваарилалтын тооцооллын акт үйлдэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, хуваарилбал зохих нийт мөнгөн хөрөнгө, битүүмжлэлд хамаарах татварын дүн, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн, авлагын хүсэлт гаргасан этгээдийн нэр, хаяг, авлагын хэмжээ, хуваарилах дараалал, хуваарилах мөнгөн дүн; хуваарилалтыг олгох хугацааг тусгана;

80.4.12. татварын хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгчид уг зөрчлийг цаашид гаргуулахгүй байх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж үйлдэх бөгөөд түүнд татварын төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгана;

80.4.13. татварын хяналт шалгалтад шаардагдах магадалгаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулга зэрэг эдгээртэй адилтгах нотлох баримтыг татвар төлөгчтэй харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн, санхүүгийн байгууллагаас гаргуулан авах зорилгоор зарлан дуудах хуудас үйлдэж, татвар төлөгчид хүргүүлэх бөгөөд түүнд татвар төлөгчийн нэр, хаяг, татварын улсын байцаагчийн нэр, хүргүүлсэн он, сар өдрийг тусгана.

80.5. Татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичгийн загварыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

80.6.Энэ хуулийн 80.4-т заасан баримт бичгийг батлагдсан загварын дагуу дахин давтагдахгүй нэгдсэн дугаартайгаар ашиглах бөгөөд татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд заавал бүртгэнэ.

80.7.Татварын алба, татварын улсын байцаагч нь энэ зүйлд заасан баримт бичгийн хэвлэмэл хуудас, маягтыг зөвшөөрөлгүй хэвлэн ашиглах, хүчингүй буюу хуурамч хуудас хэрэглэх, зориулалт бусаар ашиглахгүй.

80.8.Татвар төлөгч нь энэ зүйлд заасан шийдвэрийг биелүүлж ажиллана.

81 дүгээр зүйл.Татварын улсын байцаагчийн эрхийн баталгаа

81.1.Татварын улсын байцаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, ажлын үр дүнгийн шагнал, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэв, цол, эрдмийн зэргийн болон хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ.

81.2.Татварын албаны албан хаагчдад үр дүнгийн шагнал олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төсвийн тухай хуульд нийцүүлэн батална.

81.3.Татварын улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дараахь буцалтгүй тусламж, албан тушаалын цалингийн зөрүүг олгоно:

81.3.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүү;

81.3.2.хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй болсны тэтгэвэр, албан тушаалын цалингийн зөрүү;

81.3.3.амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 60 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж.

81.4.Татварын улсын байцаагчид доор дурдсан цол олгож болно:

81.4.1.татварын жинхэнэ зөвлөх;

81.4.2.татварын итгэмжит зөвлөх;

81.4.3.татварын зөвлөх.

81.5.Татварын албаны ажилтан нь тухайн албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хувцас, хэрэглэлээр хангагдсан байна.

81.6.Татварын улсын байцаагчид хувцас, хэрэгсэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

82 дугаар зүйл.Татвар төлөгчийн гомдлыг хянан шийдвэрлэх

82.1.Татварын алба болон татварын улсын байцаагчийн гаргасан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад шийдвэрийн талаар татвар төлөгч нь захиргааны журмаар дараахь харьяаллаар гомдол гаргаж, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй:

82.1.1.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын актаас бусад шийдвэртэй холбогдсон гомдлыг тухайн байцаагчийг шууд харьяалах татварын албаны даргад;

82.1.2.татварын албаны шийдвэрийн талаарх гомдлыг түүний дээд шатны татварын албаны даргад;

82.1.3.татварын улсын байцаагчийн үйлдсэн татварын акттай холбогдсон гомдлыг харьяаллын дагуу Маргаан таслах зөвлөлд;

82.1.4.Маргаан таслах зөвлөлийн шийдвэртэй холбогдсон гомдлоо шүүхэд

82.2.Энэ хуулийн 82.1.1, 82.1.2-т заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл татвар төлөгч нь гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

83 дугаар зүйл.Төлөх татварын хэмжээг бууруулсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

83.1.Татвар төлөгч нь татвар төлөхгүй байх, төлөх татварын хэмжээг бууруулах, эсхүл татвар ногдох зүйлийг нуух зорилгоор татвар ногдуулаагүй буюу татварын ногдлыг бууруулсан бол татварын улсын байцаагч татварыг нөхөн төлүүлж, дараахь хэмжээгээр торгоно:

83.1.1.төлөх ёстой татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын 30 хувиар;

83.1.2.төлөх ёстой татварын дүнг 50 ба түүнээс дээш хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын 50 хувиар.

83.2.Энэ хуулийн 83.1-д заасан зөрчлийг давтан үйлдсэн бол давтан зөрчилд холбогдуулж, зайлсхийсэн нийт татварыг дахин 100 хувиар нэмэгдүүлж торгоно.

84 дүгээр зүйл.Татвар суутгах үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлага

84.1.Суутгах ёстой татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй татвар суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй.

84.2.Энэ хуулийн 84.1-д заасан этгээдийг нөхөн төлөх ёстой татварын 50 хувиар торгоно.

84.3.Энэ хуулийн 83.1-д заасан зөрчлийг давтан үйлдсэн бол давтан зөрчилд холбогдуулж, зайлсхийсэн нийт татварыг дахин 100 хувиар нэмэгдүүлж тооцно.

85 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

85.1.Дараахь үйлдэл, эс үйлдлийн улмаас төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй бол төлөх ёстой татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлөх татварын 50 хувиар торгоно:

85.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх шаардлагыг хангасан боловч гэрчилгээ авалгүйгээр бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн;

85.1.2.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн хувь хүн, хуулийн этгээд үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй;

85.1.3.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч үйлдвэрлэсэн буюу борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээндээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан боловч уг татварыг төсөвт төлөөгүй;

85.1.4.нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлээгүй этгээд бараа үйлдвэрлэсэн буюу борлуулсан, түүнчлэн ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бөгөөд тэдгээрт албан татвар ногдуулсан боловч түүнийг төсөвт төлөөгүй;

85.1.5.төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг бууруулах, эсхүл буцаан авах татварын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, төлбөрийн баримтын мэдээллийг зөрүүтэй гаргасан, эсхүл падаан, төлбөрийн баримтыг үйлдээгүй.

85.2.Энэ хуулийн 83.1-д заасныг давтан үйлдсэн бол зайлсхийсэн татварыг дахин 100 хувиар нэмэгдүүлж торгоно.

86 дугаар зүйл.Татварын улсын байцаагчийн хариуцлага

86.1.Татварын улсын байцаагч, хураагчийн үйлдсэн доор дурдсан зөрчилд холбогдуулж Захиргааны ерөнхий хуулийн 105, 106, 107 дугаар зүйлд заасан зарчмаар хариуцлага хүлээлгэнэ:

86.1.1.татварын акт нь энэ хуулийн дагуу зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон;

86.1.2.энэ хуулиар хамгаалагдсан татвар төлөгчийн мэдээллийн нууцыг задруулсан;

86.1.3.энэ хуулиар заасан албан тушаалын эрхээ хэтрүүлсэн, эсхүл үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй.

86.2.Татварын улсын байцаагч, хураагчийн энэ хуулийн 86.1-д заасан зөрчлийн улмаас татвар төлөгчид хохирол учруулсан уг хохирлыг гэм буруутай албан хаагч хариуцна.

87 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

87.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.19 дүгээр зүйл.Татварын хууль тогтоомж зөрчих

“1.Татварыг хуулиар тогтоосон хугацаанд нь төлөөгүй бол хүн, хуулийн этгээдийг хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

2.1.хуулиар татвар төлөх, суутгах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд татвар төлөгчөөр бүртгүүлэх;

2.2.татварын албанд хувийн хэрэг нээлгэх;

2.3.татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд тушаах;

2.4.орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч, эсхүл эзэмшигч нь уг зүйлийг өмчилж, эсхүл эзэмшиж эхэлснээс хойш хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд мэдэгдэх, хувийн хэрэг нээлгэх, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;

2.5.санхүүгийн тайлан, бүртгэлийг Татварын ерөнхий хуульд заасан журмын дагуу хөтлөх;

2.6.Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, төлбөрийн баримтын цаас, пос терминал машин хэрэглэх;

2.7.төлбөрийн баримтыг татварын нэгдсэн системийн санд илгээх үүргээ биелүүлээгүй хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

3.1.үл хөдлөх эд хөрөнгө худалдах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн өдрөөс хойш хуульд заасан хугацаанд харьяалагдах татварын албанд мэдэгдэх;

3.2.хуулийн этгээдийн мэдээлэл, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх бүрд өөрчлөлт орсноос хойш хуульд заасан хугацаанд татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэх;

3.3.татварын албанаас олгосон бүртгэлийн дугаарыг татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан, мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн, эсхүл шаардлагатай бусад баримтад тусгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

4.1.байнга, эсхүл түр оршин суугаа, аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаягаа буруу тодорхойлсон;

4.2.татварын албанаас дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй;

4.3.шүүх тухайн татвар төлөгчийг сураггүй алга болсонд тооцоогүй байхад хаана оршин суугаагаа үл мэдэгдэж татвар, алданги, торгууль төлөхөөс зайлсхийсэн;

4.4.татварын хяналт шалгалтын зорилгоор шаардсан магадалгаа, баримтын хуулбар, банкны гүйлгээний хуулгыг хугацаанд нь ирүүлээгүй;

4.5.татварын өр хураах зорилгоор хөрөнгө битүүмжлэхэд саад учруулсан бол татварыг нөхөн төлүүлж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтны битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг:

5.1.үрэгдүүлсэн;

5.2.дур мэдэн бусдад шилжүүлсэн;

5.3.гэмтээсэн;

5.4.зөвшөөрөлгүйгээр худалдсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд:

6.1.шаардлагатай нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын мэдээ, холбогдох баримт бичгийг гаргаж өгөөгүй;

6.2.байр, агуулахад нь нэвтрэн орох боломж олгоогүй;

6.3.тооллого хийлгээгүй;

6.4.ажлын зураг авалт, үзлэг, хөрөнгө барьцаалах, эсхүл битүүмжлэх үйл ажиллагааг хийлгээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Татвар төлөгч хүн, хуулийн этгээд, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж:

7.1.татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдөөгүй;

7.2.татвар төлөгч ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд ажил олгогч нь түүний ажлаас гарсан өдрөөс хойш хуульд заасан хугацаанд татварын өрд суутгасан мөнгөний хэмжээ, хаана шилжсэнийг тэмдэглэж, төлбөрийн хуудсыг татварын албанд буцаах үүргээ биелүүлээгүй;

7.3.татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

7.4.татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах талаарх хуулиар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгийн бирж, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Бараа, ажил, үйлчилгээ борлуулж байгаа хүн, хуулийн этгээд:

8.1.төлбөрийн баримт олгоогүй бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн хоёр хувь;

8.2.төлбөрийн баримтыг борлуулалтын үнийн дүнгээс зөрүүтэй олгосон бол тайлант сарын хугацаанд олсон орлогын үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Татварын нэгдсэн сангийн мэдээллийг хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол төлбөл зохих татварыг нөхөн төлүүлж, хүнийг нөхөн төлүүлэх татварын 10 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээтэй холбоотой үнэ шилжилтийн тайланг татварын албанд хугацаанд гаргаагүй бол татварыг нөхөн төлүүлж:

11.1.улс бүрээр тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээ бол нийт дүнгийн дөрвөн хувь;

11.2.ерөнхий үнэ шилжилтийн тайлан, эсхүл дотоод үнэ шилжилтийн тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн гурван хувь;

11.3.үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлангийн хувьд харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн хоёр хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Татварын тайланг гаргасан, эсхүл тайлан гаргахад оролцож гарын үсэг зурсан этгээд, татварыг суутган авч төсөвт төлөөгүй талаар мэдэж байсан, эсхүл мэдэх ёстой байсан удирдах ажилтан, татвар суутган авч төсөвт төлөх асуудал хариуцсан удирдах албан тушаалтан, ерөнхий нягтлан бодогч хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас энэ зүйлд заасан зөрчил үйлдэгдсэн бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Татварын албанаас мэдээлэл харилцан солилцох зорилгоор шаардсан мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, хууль болон хэлэлцээрийг зөрчиж мэдээллийг шууд болон шууд бусаар бусад этгээдэд дамжуулсан, худал мэдүүлэг өгсөн, мэдээллийг устгасан, өөрчилсөн бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгуулийн хэмжээ нь төлөх татварын хэмжээний 10 хувиас хэтрэхгүй байна.

-Татварын алба татвар төлөх хугацааг сунгаж хөнгөлөлт үзүүлсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа хэтрүүлсэнд тооцохгүй.

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсгийн “30 хувь” гэснийг “50 хувь” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.3 дугаар зүйл. Татвар төлөхөөс зугтах

1.Татвар төлөгч татвар төлөхөөс зугтах зорилгоор их хэмжээний татвар ногдуулах орлого, эд хөрөнгийг зориуд худал тодорхойлсон, нуусан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж үлэмж хэмжээний татвар төлөхөөс зугтсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.5.1 дэх заалтын “гэм хорыг арилгуулах” гэсний дараа “татварын өрийг хураах” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 41.4.16 дахь заалт нэмсүгэй:

“41.4.16.татварын албанаас татварын өр хураах зорилгоор төрийн байгууллагаас гаргуулж буй лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг баталгаажуулах, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны бүртгэлтэй холбоотой үйлчилгээ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “дүгнэлтийг” гэсний дараа “, татварын өрөө төлөхгүй удаа дараа зайлсхийсэн тохиолдолд татварын албаны хүсэлтийг тус тус” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “санхүүгийн байгууллагад” гэсний дараа “, эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн татварын өрийг хураах зорилгоор татварын албанд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/49 дүгээр зүйлийн 49.12 дэх хэсэг:

“49.12.Татварын ерөнхий хуулийн 6.1.50-д заасан эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг Татварын ерөнхий хуулийн 25.11, 25.12, 25.13-д заасны дагуу харьяалах татварын албанд мэдэгдэнэ.”

2/56 дугаар зүйлийн 56.1.11 дэх заалт:

“56.1.11.Татварын ерөнхий хуулийн 25.11, 25.12, 25.13-т заасны дагуу холбогдох байгууллагад үнэн зөв мэдээлээгүй бол.”

3 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.8 дахь заалтын “16.14 дэх” гэснийг “18.8, 30.6 дахь” гэж, 56 дугаар зүйлийн 56.1.10 дахь заалтын “16.11, 16.14” гэснийг “18.8, 30.6” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дампуурлын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн “мөнгөн хөрөнгийг” гэсний дараа “хуваарилахдаа татварын өрийг барагдуулсны дараа” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.12 дахь заалт, 11.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Малын генетик нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтын “4.1.3” гэснийг “4.1.6” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 30.3 дахь хэсэг нэмсүгэй:

“30.3.Татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгнө.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.1.8, 33.1.9 заалт нэмсүгэй:

“33.1.8.Татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээллийг гаргаж өгөх;

33.1.9.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татварыг хураах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төв банк /Монгобанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

“6/татварын хууль тогтоомжийн дагуу арилжааны банкнаас мэдээлэл гаргуулах талаар шаардлага хүргүүлж, албадлагын арга хэмжээ авах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.2.10 дахь заалт:

“7.2.10.Татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцох талаарх Монгол Улсын олон улсын гэрээний дагуу татварын албаны шаардсан мэдээллийг.”

2/11 дүгээр зүйлийн 11.6 дэх хэсэг:

“11.6. Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан албан татвар, төлбөр, хураамж төвлөрүүлэх гүйлгээнээс арилжааны банк үйлчилгээнд хөлс тооцохгүй.”

3/27 дугаар зүйлийн 27.1.7 дахь заалт:

“27.1.7.энэ хуулийн 7.2.8-д заасан харилцагчид хамаарах мэдээллийг татварын албанд гаргаж өгөөгүй үйлдэл нь харилцагчийн татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдэх нөхцөл болсон нь тогтоогдож, энэ зөрчил нь удаа дараа давтагдсан бол.”

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.8 дахь заалтын “өр, төлбөрийг төлүүлэхээр” гэснийг дараа “, болон татварын хяналт шалгалт хийхээр” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмсүгэй:

“18.2.Энэ хуулийн 18.1 дэх хэсэгт татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалтын “баримт” гэсний дараа “, нэхэмжлэл” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “байгууллагын” гэсний дараа “болон Авлигатай тэмцэх газрын” гэж, 13.1.17 дахь заалтын “борлуулсан” гэсний дараа “, дамжуулан борлуулсан” 13.2 дахь хэсгийн “13.1.20” гэсний дараа “13.1.12, 13.1.22, 13.1.29” гэж, 13.5.7 дахь заалтын “зээлийн хүү,” гэсний дараа “засгийн газрын бондын хүү,” 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалтын “арьс шир,” гэсний дараа “ноос” гэж, 15 дугаар зүйлд “15.3.5.албан татвар төлөгчийн импортлосон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварт хамаарахгүй.” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.5.4 дэх заалт:

“13.5.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.6-д заасан санхүүгийн хэрэгслийг анхдагч болон хоёрдогч зах зээлд борлуулах, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаа болон тэдгээрт баталгаа гаргах үйлчилгээ,”

2/14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалт:

“14.1.5.Үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг дараах хугацаагаар хувь тэнцүүлэн хасагдуулна:

14.1.5.а.барилга, байгууламж 10 жилээр;

14.1.5.б.тоног төхөөрөмж, хайгуулын үйл ажиллагааны зардал 5 жилээр;

14.1.5.в.энэ хуулийн 14.1.5.а-14.1.5.б-д зааснаас бусад үндсэн хөрөнгийг шууд.”

3/15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг:

“15.4.Татварын алба нь энэ хуулийн 15.2.1-д заасны дагуу тухайн улиралд олгох буцаан олголтын дүнг дараа сарын 10-ны өдрийн дотор албан татвар төлөгч бүрээр бүртгэлийн системээс гаргаж, баталгаажуулан, албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.”

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6.а дэд заалтын “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд” гэснийг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.3-т” гэж, 4.1.6.б дэд заалтын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5.4-т заасан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд” гэснийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.5-д” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “зөвхөн өөртөө хэрэглэх зориулалтаар” гэснийг “хувийн хэрэглээнд” гэж, 5 дугаар зүйлийн 5.5, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “4.1.19” гэснийг “4.1.8” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “дүнгээр” гэснийг “дүнгээс”, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “12.1.1” гэснийг “12.1” гэж, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “14.9” гэснийг “14.6.3” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын “хянаж баталгаажуулан,” гэснийг “хянан шалгаж, баталгаажуулахаар” гэж, 15.2.1 дэх заалтын “татварын жилд” гэснийг “улиралд” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “, 16.4” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 16.5.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Захиргааны ерөнхий хуулийн 97 дүгээр зүйлийн 97.1.2 дахь заалтын “албан” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 293¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“293¹ дүгээр зүйл. Гаалийн болон бусад татвар төлөхөөс зугтах

293¹.1.Гаалийн үнэ, барааны тоо хэмжээ, гаалийн бүрдүүлэлтийн горим, барааны нэр төрөл, марк, зориулалт, ангилал, гарал үүслийг худал мэдүүлэх, гаалийн бичиг баримтыг солих, засварлах зэрэг аргаар гаалийн болон бусад татвар төлөхөөс санаатайгаар зугтсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол буруутай этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө татварын хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл хэвээр үйлчилнэ.

2 дугаар зүйл. 2008 оны 05 дугаар сарын 20-ний өдөр баталсан Татварын ерөнхий хуулиар хяналт шалгалтад хамруулахаар хуваарьт оруулсан боловч шинэ батлагдсан Татварын ерөнхий хуулиар эрсдэлд тооцогдохгүй нөхцөл байдалтай татвар төлөгчийг хяналт шалгалтад хамруулахгүй.

3 дугаар зүйл. 2008 оны 05 дугаар сарын 20-ний өдөр баталсан Татварын ерөнхий хуулиар хяналт шалгалтыг эхлүүлсэн бол уг хяналт шалгалтыг зогсоохгүй үргэлжлүүлнэ.

4 дүгээр зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө татварын хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдийн гэм бурууг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш илрүүлж, хариуцлага хүлээлгэх бол 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөх Татварыг ерөнхий хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5 дугаар зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө үүссэн татварын өрийг 2008 оны 05 дугаар сарын 20-ний өдөр баталсан Татварын ерөнхий хуульд заасны дагуу хураана.

6 дугаар зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу тогтоосон татварын зөрчилд холбогдох шийтгэлийн хуудастай холбоотой гомдлыг татварын маргаан таслах зөвлөл 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих Татварын ерөнхий хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн татварын өрийг татварын алба хураана.

8 дугаар зүйл. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө үүссэн татварын хяналт шалгалттай холбоотой татварын хөөн хэлэлцэх хугацааг тоолох, хугацааны тасалдлыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих Татварын ерөнхий хуульд заасны дагуу тогтооно.

9 дүгээр зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 24.5 дахь хэсэг нэмсүгэй:

“24.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улсын иргэнийг бүртгэхдээ татвар төлөгчийн дугаарыг олгоно. Татвар төлөгчийн дугаарын тоон агуулга, хэлбэрийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийн “Татварын ерөнхий хуулийн 71.3-т заасны дагуу” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн “Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд” гэснийг “Татварын ерөнхий хууль болон Зөрчлийн тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.6 дахь заалтын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6.1.1-6.1.3-т” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс 1992 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш орчин цагийн татварын тогтолцооны сууриа тавьсан. Энэхүү 25 жилийн хугацаанд татвар төлөгчийн орлогоос татвар хураах асуудлыг л хуульчилж ирсэн бөгөөд татварын алба, татвар төлөгчийн эрх ашгийг тэнцвэржүүлэх асуудлыг төдийлөн сайн зохицуулаагүй байна. Иймээс ч татварын алба, татвар төлөгчийн хоорондын харилцааг тэнцвэржүүлэх, татвар төлөгчийн хөндөгдөж буй эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх нөгөө талаас татварын албаны хууль ёсны эрх ашгийг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг дахин хуульчлах зайлшгүй шаардлагатай юм.

Монгол Улс 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллагад (BEPS - Base Ersion Profit Shifting) элсэн орсон. Татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн эсрэг арга хэмжээнд нэгдэн орсноор цаашид татварын зорилгоор бусад улстай мэдээлэл солилцох хамтран ажиллах томоохон гарц боломж бий болж байгаа хэдий ч энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор татварын хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 89 дүгээр зүйлд татвар төлөгч болон татварын албаны хооронд үүсдэг маргааныг хянан шийдвэрлэх журмыг хуульчлах, одоо үйлчилж байгаа хуулийн хоёрдмол утга санаатай зохицуулалтыг ойлгомжтой болгох зорилгоор Татварын ерөнхий хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна.

Иймээс татварын албаны үйл ажиллагаанд удирдлага болгох татвар ногдуулалт, төлөлт, хяналт шалгалт, хураалтад баримтлах суурь зарчмыг олон улсын жишигт нийцүүлж, татвар төлөгч болоод татварын албаны эрх, үүргийг тэнцвэржүүлэх хуулийн зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлагатай байна.

Татварын ерөнхий хууль нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын¹ /цаашид Аргачлал гэх/ 1.3-т заасан хүрээнд хамаарахгүй тул урьдчилан тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Манай улсын хувьд татвар ногдуулах, нөхөн ногдуулах, төлөх, тайлагнах, татвар хураах зэрэг татварын процессыг хуульчилсан боловч эдгээр процесс ажиллагааг хялбаршуулах, түүнд тавих хяналтыг нарийвчлан зохицуулаагүй, шинэ төрлийн нийгэм, эдийн засгийн харилцаа бий болохын хэрээр татвар төлөгч, татварын албаны хооронд үл ойлголцол байнга гарч, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Түүнчлэн, татвар хураалтын процесс ажиллагаанд татвар төлөгч татвараа төлөхгүй, хөрөнгөө шилжүүлэх явдлууд түгээмэл тохиолдолд төсвийн орлого тэр хэмжээгээр биелэхгүй байх бодит нөхцөл байдал тулгараад байна.

¹Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Татварын ерөнхий хууль батлагдаад 9 жилийн хугацаанд нийт 24 удаа нэмэлт, өөрчлөлт орсон нь хуулийн анхны хэлбэрийг ихээхэн өөрчлөх нөхцөл болсон байна. Иймд хуулийг бүхэлд нь өөрчлөх шаардлагатай байна.

Түүнчлэн, Татварын ерөнхий хуулийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршдог. Энэ агуулгаар, татвар төлөгчийн эрх, үүрэг нь татварын ногдуулалт, тайлагнал, төлөлтөд хэрхэн хамаарах, татварын албанаас татварын ногдлыг шууд бусаар тодорхойлох, тайланг хүлээн авах, түүнийг хянан шалгах, татвар хураах зэрэг ажиллагаанд ямар эрх, үүрэгтэй оролцох талаарх өнөөгийн хуулийн хэрэгжилтийг судлахад энэхүү тандан судалгааны зорилго оршино.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Татварын ерөнхий хуульд туссан татвар төлөгчийн эрх үүрэг нь татварын албаны эрх үүрэгтэй харилцан урвуу хамааралтай байх ёстой боловч өнөөгийн мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжид энэхүү хамаарал алдагдаж, татвар төлөгч, татварын албаны хоорондын эрх үүргийн тэнцвэр алдагдаад байна. Иймд, Татварын ерөнхий хуульд туссан дээрх эрх, үүргийн тэнцвэрийг хангах зорилгоор холбогдох зохицуулалтыг бүхэлд нь шинэчлэх зайлшгүй шаардлагатай байна. Түүнчлэн татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцох бусад эрх бүхий этгээдийн эрх, үүргийг энэхүү хуулиар тодорхойлох бөгөөд тэдгээрийн чиг үүрэг, хариуцлагыг хуульд тодорхой тусгах нь зүйтэй байна.

Энэ хуулийн хүрээнд дараах этгээдийн эрх ашиг хөндөгдөнө:

1/татвар төлөгч болох хувь хүн, хуулийн этгээд,

2/татварын алба, татварын албаны ажилтан, албан хаагч,

3/татварын албатай мэдээлэл солилцох чиг үүрэгтэй төрийн болон хувийн өмчит хуулийн этгээдүүд хамаарна.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Татварын ерөнхий хуульд туссан тодорхой асуудлууд нь нэг талаас татвар төлөгчийн эрх ашгийг бүрэн хангахгүй нөгөө талаас татварын албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байгаа юм. Тодруулбал,

1/ Татвар ногдуулалт, тайлагналын хүрээнд татвар төлөгчийн тайлангийн боловсруулалт хийх процесс ажиллагаа тодорхойгүйгээс татвар төлөгчид үйлчлэх татварын албаны үйлчилгээ бүрэн хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл, татварын тайлагналд зөвлөмж өгөх ажиллагааны дэс дараалал хуульд тодорхойгүй байна.

2/ Санхүүгийн тайланд 1 жилийн хугацаанд засвар хийдэг ч татварын тайланд засвар хийх асуудал хуульчлагдаагүй нь бизнес эрхлэгчдэд алдаагаа засварлах боломжийг олгодоггүй байна.

3/ Өнгөрөгч оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу татварын хяналт шалгалт, түүнд ногдуулах хариуцлагын зохицуулалт ихээхэн хүндрэлтэй болоод байна. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий хуулийн дагуу татварын хяналт шалгалтаар акт тавьж хариуцлага тооцох ёстой хэдий ч хариуцлагын заалт нь Зөрчлийн тухай хуулиар тодорхойлогдсон тул татварын хяналт шалгалтыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар тогтоож, шийтгэлийн хуудас үйлдэх шаардлагатай болж байна. Түүнчлэн, уг тогтоосон акт буюу шийтгэлийн хуудаст гомдол гаргах журам нь Татварын ерөнхий хуулиар маргаан таслах зөвлөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар татварын албаны дарга эсхүл прокурорын харьяалал болж байна.

Эндээс харвал хууль хоорондын зөрчлөөс болж, татварын хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлэх, ямар бичиг баримт үйлдэх, хэрхэн гомдол гаргах зэрэг ажиллагаа нь тодорхойгүй байдалд хүрээд байна.

4/ Татвар төлөгчийн өөрөө тодорхойлсон ногдуулалт болон хяналт шалгалтын хүрээнд тодорхойлсон нөхөн ногдуулалтын дагуу төлөх ёстой татвар үүсдэг. Энэхүү татварыг хугацаанд нь төлөх боломжгүй болсон тохиолдолд татварын албанаас өр төлөх хугацааг 2 сараар сунгадаг нь татвар төлөгчид үзүүлэх бодитой дэмжлэг болж чаддаггүй байна. Өөрөөр хэлбэл, 2 сарын хугацаанд татвар төлөгч татвараа төлж чадах бодит чадамжтай нөхөн сэргэх хугацаа биш байна.

5/ Татвар төлөгч татварын өрөө хугацаанд нь төлөхгүй тохиолдолд татварын алба шүүхэд нэхэмжлэл гаргах замаар татварын өрийг гаргуулахаар хуульчилсан байна. Гэвч, иргэний хэргийн 3 шатны шүүхийн маргаан дунджаар 2 жилийн хугацаагаар үргэлжилдэг тул уг хугацаанд татвар төлөгч өөрийн хөрөнгөө бусдад шилжүүлэх, үнэ цэнийг алдуулах зэргээр татвар төлөх боломжгүй болж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар албан татвар бол иргэн бүр төлөх ёстой үндсэн үүрэг юм. Энэ ч агуулгаар, Үндсэн хуулиар тодорхойлсон үүргийг төлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэх нь зохисгүй юм.

Нөгөө талаар, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.“шүүх” гэж Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг хэлнэ гэж заасан. Энэ агуулгаар шүүхийн шийдвэрлэх асуудал нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг. Гэвч, татварын өр төлөх асуудал нь өөрөө заавал төлөгдөх шинжтэй бөгөөд уг төлөх ёстой дүнтэй маргаж байгаа тохиолдолд захиргааны хэргийн журмаар эцэслэн шийдвэрлэгддэг. Татвар төлөгч өөрөө тодорхойлж, тайлагнасан татварын хувьд маргаан үүсэхгүй юм. Иймээс ч иргэний хэргийн шүүхэд шийдвэрлэгддэг татварын маргаанд төлөх татварын хэмжээнд өөрчлөлт ордоггүй шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар асуудлыг шийдвэрлүүлэх эрх л олгох шинжтэй харилцаа явж байна. Энэ нь нэг талаас төр татварын өр барагдуулах институтээ тодорхойлох асуудал бөгөөд, шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр татварын өрийг барагдуулахын тулд багадаа 2 жил хүлээж, барагдуулалтын 10 хувиар шийдвэр гүйцэтгэгчид төлбөр төлөх нөхцөл болж байна. Гэвч, татвар бол баялгийн дахин хуваарилалт бөгөөд энэхүү мөнгө нь төсвийн нэг хэсэг юм.

6/ Татварын хариуцлага шударга байх ёстой. Гэвч, Зөрчлийн тухай хуулиар татвараас зайлсхийж, татвараа нуусан этгээд нь 30 хувийн торгууль төлөх бол, татвараа үнэн зөвөөр тайлагнасан ч татвараа хугацаанд нь төлөөгүй этгээд хугацаа хэтрүүлсэн хоногт тутамд 0.1 хувийн торгууль төлөхөөр байгаа нь банкны хүүгийн системтэй адил хязгааргүй үргэлжлэх боломжтой торгууль байна.

Өөрөөр хэлбэл, үнэн зөвөөр тайлангаа гаргасан этгээд 1 жилийн хугацаанд татвараа төлж чадаагүй бол татвараа нуусан этгээдээс илүү өндөр хариуцлага хүлээхээр байгаа нь шударга ёсны зарчимд нийцэхгүй байна.

7/ Татварын ерөнхий хуулиар татвар төлөгчийн эрх, үүрэг болон татварын албаны эрх, үүргийг нарийвчлан тодорхойлдог. Гэвч, одоо үйлчилж буй хуулиар татвар төлөгч болон татварын албаны эрх үүргийг тус тусад нь бүлэг, зүйл болгон хуульчилсан боловч татварын ногдуулалт, төлөлт, тайлагнал зэрэг процессын зохицуулалтад татвар төлөгч болон татварын албаны эрх үүргийг давхардуулан заасан нь хуулийн заалт хоорондын давхардал, зөрчлийг үүсгэж байна.

8/ Татварын тэгш, шударга зарчмыг бэхжүүлэх, татварын бааз суурийг өргөтгөх, татвар хураалтыг сайжруулах, татвар төлөхөөс зайлсхийх явдалтай үр дүнтэй тэмцэх зорилгоор өнөөгийн мөрдөгдөж буй татварын хуулиудад туссан зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

9/ Олон улсын татварын зохицуулалтуудыг шинэчлэх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх, татварын өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагааг үр дүнтэй хийх зайлшгүй шаардлага тулгараад байна. Тодруулбал, Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээрийн хүрээнд хэлэлцэн тохирогч талууд нь харилцан туслалцаа үзүүлж, мэдээлэл солилцох чиг үүрэгтэй боловч манай өнөөгийн хууль эрх зүйн зохицуулалтаас болж мэдээлэл солилцох хүрээ, эрх хэмжээ тодорхойгүйгээс энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөлтэй байна.

10/ Татварын албаны хүний нөөцийг илүү оновчтой удирдах, татвар төлөгчийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардлыг бууруулах үүднээс татварын хялбаршуулсан тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага байна. Түүнчлэн, татварын хяналт шалгалтыг эрсдэлд үндэслэн хийх, татварын хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй, татвар төлөгчид чирэгдэл багатай хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж, татварын албаны хэрэгжүүлэх чиг үүрэг, татварын хяналт шалгалтын үйл явцыг эдгээр хуультай нийцүүлж холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Эрх зүйн зохицуулалтын хувьд татвар бий болгох, хөнгөлөх, чөлөөлөх, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах зэрэг асуудлыг зохицуулсан боловч татвараас зайлсхийх, татварын ногдлыг тодорхойлох боломжгүй болох тохиолдолд татварын албанаас асуудлыг хэрхэн хэрэгжүүлэх, татвар төлөгчийн эрхийг хангах асуудал нь хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж байна.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт: *“Татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлж, тайлагнаж, төлөх, нөгөө талаас татварын алба татварын тайланг хүлээх авах, түүнийг хянаж, нөхөн ногдуулах, хураах ажиллагааг ил тод, шударгаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг сайжруулах”*

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу *“Татвар төлөгч татвараа өөрөө тодорхойлж, тайлагнаж, төлөх, нөгөө талаас татварын алба татварын тайланг хүлээх авах, түүнийг хянаж, нөхөн ногдуулах, хураах ажиллагааг ил тод, шударгаар хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчинг сайжруулах”* зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан зохицуулах замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул төрөөс санхүүгийн интервенц хийх замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул хуулиар эрх олгогдоогүй тохиолдолд захиргааны шийдвэр гаргах замаар зорилгод хүрэх боломжгүй.	Зардал гарахгүй. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул хуулийн төсөл боловсруулах замаар зорилгод хүрэх боломжтой.	Одоо үйл ажиллагаа явуулж буй татварын албаны нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх учир нэмэлт зардал гарахгүй. Татвар хураалтыг гүйцэтгэлийн эрх мэдлийг нэвтрүүлснээр	Үр дүнтэй

			татвар хураалтын зардал буурч, татварын суурь өргөжиж, төсвийн орлого нэмэгдэнэ.	
--	--	--	-------------------------------------------------------------------------------------------	--

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 7 дугаар хэсэгт зааснаар албан татварын бодлогыг тодорхойлох нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн асуудал гэж, Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт татварыг зөвхөн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй хэмээн тус тус заасан байдаг. Иймд татварын харилцааг шинэчлэн сайжруулах асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас бусад дээр дурдсан хувилбараар шийдвэрлэх боломжгүй юм.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгон, одоо үйл ажиллагаа явуулж буй татварын албаны нөөц бололцоонд тулгуурлан шаардлагатай бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх учир нэмэлт зардал гарахгүй. Татвар хураалтыг гүйцэтгэлийн эрх мэдлийг нэвтрүүлснээр татвар хураалтын зардал буурч, татварын суурь өргөжиж, төсвийн орлого нэмэгдэнэ.

Хувилбаруудын эерэг, сөрөг талын харьцуулалтын үр дүнгийн дагуу сонгосон хувилбарт “Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг цогцоор нь шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах” хувилбар багтаж байгаа тул Аргачлалд заасны дагуу тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн хийж байна.

Иймд тухайн хуулийн төслийн агуулга, зохицуулалтын хэлбэрийг дараах байдлаар ерөнхийлөн томъёолж байна.

Тус хуулиар татвар төлөгч татварын ногдлоо үнэн зөв тодорхойлох, түүнийг алдаатай гаргасан бол засварлах эрхийг олгож байгаа нь татвар төлөгч татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөх зардлыг бууруулж, хариуцлагад татагдахаас сэргийлнэ. Түүнчлэн, татвар төлөгч тайлангаар илэрхийлсэн татвараа төлж чадахгүй нөхцөл байдал үүсэхэд өрийн дарамтыг хөнгөлж татвар төлөх хугацааг 2 жилээр сунгах эрхийг олгож байна.

Харин, татварын албаны зүгээс татвар төлөгчийн үйлдэл бүрийг хянах бус эрсдэлтэй тохиолдолд хянадаг тогтолцоонд шилжиж байгаа нь татвар хураалтын үр ашигтай хэлбэрт шилжиж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хувилбарын хүрээнд татварын алба, татвар төлөгчийн хоорондын харилцааны балансыг барьж, татвар төлөгчдийн тэгш бус, ялгамжтай байдлыг арилгаж татварын хуулиа дагаж мөрддөг татвар төлөгчид татварын дэмжлэгийг үзүүлэх, татвараас зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгосноор хүний эрхийг дэмжих, хангахад чиглэсэн зохицуулалтыг бий болгоно.

Татвараас зайлсхийх зорилгоор хөрөнгөө бусдад шилжүүлсэн тохиолдолд энэ нь Иргэний хуулийн агуулгаар хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцогдохоор байна. Иймд татвараас зайлсхийсэн үйлдэлтэй холбогдуулж, татвар төлөгчийн

бусдад шилжүүлсэн хөрөнгөөс татварын өрийг гаргуулах нь ялгаварлан гадуурхалт биш юм. Түүнчлэн, маргаан таслах зөвлөлд гомдол гаргахад маргаж буй татварын дүнгийн 10 хувийг төлөх нь Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан татвар төлөх тухай актын биелэлтийг түдгэлзүүлэхгүй байх суурь зарчимтай нийцэх бөгөөд татвар төлөгчид татвараа төлөхгүй байх хугацаа хожих зорилгоор маргаан таслах зөвлөлд гомдол гаргах зөрчил үндсэндээ алга болно.

Иймд эдгээр асуудлыг цогцоор шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах нь илүү нөлөөтэй байна.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Сонгосон хувилбар нь татвар төлөгчийн бизнесийн орчинг дэмжихийн зэрэгцээ, татвар хураалтын зардлыг бууруулж, татварыг үр ашигтай хураах механизм бүрдэж, татвар хураалтын суурь нэмэгдэнэ.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг татвар төлөгчдийн хувьд бодитой дэмжлэг болох бөгөөд харин татвараа нуудаг, зайлсхийдэг татвар төлөгчдөд тооцох хариуцлага өндөр болж байгаа. Үүнтэй холбогдуулж, татварын улсын байцаагчийн хариуцлага ч мөн өндөр болж байгаа ба татварын алба, татвар төлөгчийн зүгээс аль аль нь илүү хуулийн хүрээнд ажиллах сонирхлыг төлөвшүүлнэ.

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн олон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан. Мөн Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван долдугаар зүйлийн 17.1.3-т зааснаар хуулиар ногдуулсан албан татварыг төлөх нь Монгол Улсын иргэний үндсэн үүрэг бөгөөд энэхүү татварыг ногдуулах эрх хэмжээ нь УИХ хэрэгжүүлдэг байхаар хуульчилсан байна. Энэ агуулгаар аваад үзэхэд татварын хууль тогтоомж нь УИХ-аас батлагддаг байх ёстой бөгөөд татвар төлөх үүрэг нь зайлшгүй байж, энэ нь нийгмийн харилцааг зохицуулах төсвийн суурь болдог.

Түүнчлэн, Монгол Улс 2017 оны 12 дугаар сард Татварын суурь бууруулах ашиг шилжүүлэх эсрэг олон улсын байгууллагад нэгдэн орсноор татварын зорилгоор мэдээлэл солилцох үүрэг, амлалтыг аваад байгаа. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Иймд Татварын ерөнхий хуулийг шинэчлэн найруулах нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Татварын ерөнхий хуулийг батлан хэрэгжүүлэх нь татвар төлөгчийн эрх ашгийг татварын албаны эрх, үүрэгтэй тэнцвэржүүлж, татварын хууль тогтоомжийг энгийн ойлгомжтой болгож, хэрэгжүүлэх нөхцөл боломж бүрдэх бөгөөд татварын ногдлыг бүрэн тодорхойлж, түүнийг бүрэн хураах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна. Гэвч шинээр хуульд тусгах зохицуулалтуудыг оновчтой хэлбэрээр хуульчлахгүй бол нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэмэгдүүлэх эрсдэл учирч болох юм.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах хүрээнд энэ чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны мэдээлэл, олон улсын туршлагыг судаллаа.

Татварын ил тод байдлыг хангах, татвараас зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 350 дугаар тогтоолын дагуу элсэн орж, үүрэг амлалт хүлээсэн “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага”, “Татварын зорилгоор ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форум” зэрэг байгууллагын стандарт, тавигддаг шаардлага, татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын шинэ дүрмүүдийг хуулийн төсөлд тусгалаа. Тухайлбал, үнэ шилжилтийн тайлагналын стандартыг хууль боловсруулахад ашигласан болно.

Түүнчлэн, Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Азийн хөгжлийн банкны татварын бодлогын чиглэлээр гаргасан судалгааны материал, харьцуулсан судалгаа, уулзалт, хурлуудаар тавигдсан илтгэл, Монгол Улсад өгч байсан зөвлөгөөг судалж, зөвшилцсөний үндсэнд хуулийн төслийг боловсруулсан.

Мөн татварын чиглэлээр мэргэшсэн олон улсын томоохон байгууллага болох Монгол Улс дахь Эрнст энд Янгийн болон ПрайсУотерхаусКүперс компанийн мэргэжилтнүүдтэй уулзаж, санал солилцсон. Эдгээр судалгаагаар дэлхийн бүх улс орнуудын татварын албаны удирдлага зохицуулалтын горим буюу татварын тайлагнал, төлөлт, хяналт шалгалт, хураалтын процессыг харьцуулан нэгтгэсэн байдаг.

Дээрхээс гадна дараах судалгааны материалуудыг ашиглалаа:

- Татварын ерөнхий хуулийн шинэчлэлийн талаарх нэмэлт тайлбар, ОУВС-ийн Төсвийн асуудал эрхлэх газар, хуулийн газар, 2017.07 Жон Брондоло, Ирвинг Оув, Сюзан Бэттс, Аннетт Чуи, Исаис Коэлхо, Робэрт Оулдинг, Майкл Смитсон

- Хууль тогтоомж мөрдөлтийг сайжруулах стратегиудын хэрэгжилт, Татварын ерөнхий хуулийн шинэчлэл ба Татварын хялбаршуулсан тогтолцооны загвар боловсруулалт, ОУВС-ийн Төсвийн асуудал эрхлэх газар, хуулийн газар, 2017.07 Жон Брондоло, Ирвинг Оув, Сюзан Бэттс, Аннетт Чуи, Исаис Коэлхо, Роберт Оулдинг, Майкл Смитсон
- Assessment of the Current Mongolian Taxation environment, GIZ international service, Sebastian Merriman, Enkhjavkhlan Tseyen, 15th June, 2015
- Mongolia, Follow –up on Selected tax policy issues, Technical Assistance Report, IMF, Fiscal affairs department, Geerten Michiles and Wendela van den Brink, October 2017
- Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдэд өгөх зөвлөмж, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Косака Мицүрү, 2017.10.25
- Япон Улсын олон улсын татварын үйл ажиллагаа, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Кодера Тошинари, 2017.8 сар
- Татварын ерөнхий хууль, П.Одгэрэл
- Монгол Улсын татварын орчинд хийсэн дүн шинжилгээ, түүнийг сайжруулах талаарх зөвлөмж, 2018 оны 12 сар

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Татварын ерөнхий хуульд туссан тодорхой асуудлууд нь нэг талаас татвар төлөгчийн эрх ашгийг бүрэн хангахгүй нөгөө талаас татварын албаны чиг үүргийг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байгаа бөгөөд татварын хууль тогтоомжийг олон улсын жишигт нийцүүлж хуульчлах зорилгоор асуудлыг дараах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1/ Татвар ногдуулалт, тайлагналын хүрээнд татвар төлөгчийн тайлангийн боловсруулалт хийх процесс ажиллагааг тодорхой болгож, татварын алба, татвар төлөгчийн эрх, үүргийг хуульд тодорхой, хугацаатайгаар тусгах.

2/ Татварын тайланд тайлангаас өмнөх нэг жилийн хугацаанд засвар хийх эрхийг олгох.

3/Татварын хяналт шалгалт, түүнд ногдуулах хариуцлагын зохицуулалтыг Татварын ерөнхий хуулиар, харин татварын хууль шууд зөрчсөн үйлдэлд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх.

4/ Татвар төлөгчид татварын өрөө төлж чадахгүй нөхцөлд хөнгөлөлт үзүүлж, өр төлөх боломжит хугацааг хангалттай хэмжээгээр уртасгах.

5/ Татварын өр гэдэг нь татварын албаны хувьд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд улсын авлага юм. Иймд улс нэгэнт татвар төлөгчийн төлөхийг хүлээн зөвшөөрсөн татварын өр буюу авлагыг заавал шийдвэр гүйцэтгэлийн байгууллагаар биш татварын албаараа шууд хэрэгжүүлэх нь мөнгөний үнэ цэнийг алдуулахгүй, татвар хураалтын ажиллагааг үр ашигтай болгох юм.

6/ Татварын хариуцлага нь гэм буруугаас хамаарч тодорхой байх ёстой.

7/Татварын процесс ажиллагааг бүлэг, бүлгээр тодорхой бичиж зохицуулах

8/ Татвар хураалтын гүйцэтгэлийн бие даасан эрхийг татварын албанд олгох.

9/Олон улсын гэрээний үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай суурь заалтыг татварын хуульд тусгах.

10/Татварын хялбаршуулсан тогтолцоог бий болгож, татвар төлөгчийн татварын үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хэмнэх нь зүйтэй.

-----oOo-----

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Татварын харилцаанд тэгш шударга байх зарчмыг баримтлан хуульчилна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Нийтийн ашиг сонирхлын үүднээс аж ахуйн нэгжүүдийн татвар ногдуулах, тайлагнах харилцааг тодорхой шалгуураар ялгаатай тогтоох боловч энэ нь ялгаварлан гадуурхсан зохицуулалт биш.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд бүрэн нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, татвар төлөгч зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Татварын ил тод, шударга байдал сайжирснаар татвар төлөгчдийн эрхийг хангах, тэгш шударга байх зарчимд дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Бүрэн нийцнэ.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Татварын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг энэ хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар зохицуулах.Түүнчлэн, татвар төлөгчийн нууцыг задрүүлсан, татвар төлөгчид үндэслэлгүй акт	

				тавьсан татварын улсын байцаагчид хариуцлага тооцно.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Татварын өр барагдуулах зорилгоор татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, түүнийг захиран зарцуулах, үндэслэлгүйгээр бусдад шилжүүлсэн тохиолдол уг этгээдээс өрийг гаргуулах харилцааг тусгасан. Энэ нь хуулиар тогтоогдсон бөгөөд төлөх нь тодорхой өрийн хувьд хэрэгжих байх тул хүний өмчлөх эрхийн зөрчил биш болно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Татвараа төлөхгүй зугтах, зайлсхийх, бусдад хөрөнгөө хууль бусаар шилжүүлж байгаа тохиолдолд хэрэглэгдэнэ.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Татвар төлөгч, Татварын алба Татварын зорилгоор мэдээлэл хүргүүлэх бусад этгээд
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлал байхгүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Татвараа төлөх боломжтой болох хүртэл хугацаа өгч, татвар төлөгчид дэмжлэг үзүүлж байна.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Татвар төлөх боломжгүй нөхцөл байдалд хүрсэн татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлнэ.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Татвар төлөгч, Татварын алба Татварын зорилгоор мэдээлэл хүргүүлэх бусад этгээд
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендэрийн үзэл баримтлал татварын суурь зарчим тул тусгагдсан
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Татвар төлөгчийг хүйсээр үл ялгаварласан.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй. Олон улсын татварын нийтлэг зарчмын дагуу татвар ногдуулна.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Дотоодын татвар төлөгчдийн чадавхыг нэмэгдүүлэх болон олон улсын хэмжээний татвараас зайлсхийхийн эсрэг дүрмүүдийг нэвтрүүлснээр зарим нэг нөлөөллөөс сэргийлж чадна.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх			
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Татварын ер нь улсын авлага тул татвар төлөгчийн хөрөнгөөс өр гаргуулах асуудал нь өмчлөх эрхийн зөрчил биш юм.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Төсвийн орлого нэмэгдэнэ.

байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Олон улсын татварын хүрээнд мэдээлэл харилцан солилцох чиглэлээр нууцлалын баталгаа бүхий мэдээлэл солилцох чиг үүрэг бий болно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Эдийн засгийн чадавхыг үндэслэн төлөх татварыг хөнгөлж, хугацаа сунгах бодит боломж олгогдоно.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нийцэж байгаа ба Давхар татварын хэлэлцээр, Татварын суурийг багасгах ашиг шилжүүлэхийн эсрэг арга хэмжээ болон Татварын асуудлаар харилцан тусалцаа үзүүлэх хэлэлцээрийн хүрээнд холбогдох хуулийн төслийг нийцүүлсэн.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Татвар төлөгчдөд боломж олгосноо үйлдвэрлэл, худалдааны салбарт ажил эрхлэлт нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мэдээлэл харилцан солилцох зорилгоор олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжийг суурилуулна.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагууд хоорондоо мэдээлэл харилцан солилцох талаарх чиг үүргийг нэмэгдүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Татварын улсын байцаагчийн нууцлалын баталгаа хангах, хяналт шалгалтыг бодитой үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлаар хариуцлагыг нэмэгдүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Татварын албаны үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирснаар гэмт хэргийн гаралт буурч, эерэг нөлөө гарна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

-----o0o-----

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, хэсэг, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь шинэчлэн найруулсан хуулийн төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Ойлгомжтой байдал;

¹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

² 25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.1.өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол;

25.1.2.хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.3.хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох бол;

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон. Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйл.

³Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

⁴Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 "... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно".

5. Харилцан уялдаа зэрэг болно.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

1.Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухай хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

2.Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төсөлд бичил, жижиг бизнес эрхлэгчдийн татвар ногдуулах ажиллагааг хялбаршуулах, бичил, жижиг бизнес эрхлэгчдийн татварын тайлагналыг хялбаршуулах, татвар төлөгчийг алдаа гаргахаас урьдчилан сэргийлж тайлан боловсруулалтад зөвлөмж өгөх, тайлангийн алдааг 1 жилийн дотор залруулж болох, нэг шатлалтай Маргаан таслах зөвлөлтэй болсноор гомдлыг шуурхай шийдвэрлэх зохицуулалтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Энэхүү зохицуулалт нь татварын албаны зүгээс болон татварын эрх зүйн харилцаанд оролцогч этгээд хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулах, татварын өр хураах үйл ажиллагаа, татварын албанд эрсдэл тооцох зэрэгт татвар төлөгчийн хандах хандлагыг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

3.Ойлгомжтой байдал:

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

4.Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомж болон төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Татварын ерөнхий хууль татварын харилцааг иж бүрнээр нь зохицуулаагүй, зарим зохицуулалт нь орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай төдийлөн уялдахгүй байгаа ба татварын эрх зүйн суурь харилцааг голчлон зохицуулахад чиглэгдсэн бөгөөд татварын хялбаршуулсан горим, олон улсын татварын асуудал, үнэ шилжилт, татварын албанд эрсдэл тооцох, татварын өр хураах үйл ажиллагаатай

⁵Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁶Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

холбоотой харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан байгаа нь хуулийг амьдралд хэрэгжүүлэхэд бодит хүндрэлүүдийг үүсгэсээр байна.

Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар татварын эрх зүйн зөрчлийг шалгах журмыг тодорхойлсон боловч тэдгээрийн өөр хоорондын уялдаа, хэрэгжүүлэх механизм хангалтгүй байна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг, Арванхоёрдугаар бүлэг.	Татвар төлөгч, татварын чиглэлээр мэргэшсэн байгууллага, нягтлан бодох бүртгэлийн чиглэлийн мэргэшсэн байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1.Зорилгод хүрэх байдал

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, татварын алба, татвар төлөгч, бусад этгээдийн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний татвар төлөх үндсэн үүргийг хэрэгжүүлэх зорилготой байна.

Энэ зорилгын хүрээнд дараах зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ.

1. Татварын хялбаршуулсан горим буюу татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааг нэвтрүүлэх.
2. Олон улсын татварын зарчмын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу харилцан тохиролцох журам, мэдээлэл харилцан солилцоо, үнэ шилжилт зэрэг нэр томъёог олон улсын чиг хандлагад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжид нутагшуулах, суурь зохицуулалтыг бий болгох,
3. Татварын өр хураах үйл ажиллагааны хүрээнд татварын давуу эрхийн зарчмыг тодорхойлж, татвар төлөгчийн тайлагнасан татварыг татварын алба бие даан хураан барагдуулах, түүнчлэн өр барагдуулах процесс

ажиллагааг нарийвчлан тодорхойлсон нь татвар хураах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх,

4. Татварын маргаан таслах зөвлөлийг нэг шатлалтай болгож, зөвлөлийн шийдвэрийг Татварын албаны дарга баталгаажуулдаг байсныг өөрчилсөн, зөвлөлийн шийдвэрийг ил тод, цахим хуудсаар тухай бүр мэдээлэх.

Дээр дурьдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Зорилт-1.Татварын хялбаршуулсан горим буюу татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааг нэвтрүүлэх

- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд Татварын хялбаршуулсан горимын эрх зүйн үндсийг зохицуулсан байна.

Эндээс үзэхэд тус хуулийн төслөөр татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлтийн тусгайлсан үйл ажиллагааг хялбаршуулсан журмаар эрх зүйн үндсийг тодорхойлсон гэж дүгнэж байна.

Зорилт-2. Олон улсын татварын зарчмын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу харилцан тохиролцох журам, мэдээлэл харилцан солилцоо, үнэ шилжилт зэрэг нэр томъёог олон улсын чиг хандлагад нийцүүлэн үндэсний хууль тогтоомжид нутагшуулах, суурь зохицуулалтыг бий болгох.

- Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт Татварын суурийг багасгаж ашиг шилжүүлэхийн эсрэг байгууллага /BEPS/-ийн тусгай шаардлага, Татварын зорилгоор мэдээлэл солилцоо, ил тод байдлын “Олон улсын форум”-аас тавьдаг шаардлагад нийцүүлсэн байна.

Зорилт-3.Татварын өр хураах үйл ажиллагааны хүрээнд татварын давуу эрхийн зарчмыг тодорхойлж, татвар төлөгчийн тайлагнасан татварыг татварын алба бие даан хураан барагдуулах, өр барагдуулах процесс ажиллагааг нарийвчлан зохицуулж татвар хураах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх

- Хуулийн төслийн арван хоёрдугаар бүлэгт татварын өр хураах үйл ажиллагаанд татварын өр төлөх хугацаа 2 сар байгааг 24 сар хүртэл сунгахаар, илүү төлсөн татварыг нэн тэргүүнд буцаан олгох, татварын албаны өр барагдуулах, хууль ёсны татвар хураах эрхийг нэмэгдүүлэх хүрээнд эрсдэлтэй өрийг түрүүлж хураах, татвар төлөх хоёрдогч этгээдийн үүрэг, хөрөнгө битүүмжлэх журам, дуудлага худалдаа, түүнээс олсон орлогыг хуваарилах зэрэг зохицуулалтыг тусгажээ.

Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Төслийн 4, 12 дүгээр бүлэгт заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд татвар төлөхөөс зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээ, татварын өр хураах үйл ажиллагаа, түүн дотор татварын давуу эрхийн зарчим, татвар төлөх хоёрдогч этгээдийн үүрэг, хөрөнгө битүүмжлэх, дуудлага худалдааны орлогыг хуваарилах зохицуулалтын талаар татвар төлөгч,

татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ эрхэлдэг этгээдийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж санал хүсэлтийг хүлээн авсан.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос ирүүлсэн саналаас үзэхэд татварын өр төлөх хугацааг 24 хүртэл сунгахыг дэмжсэн бол "Татварын алба татварын өр хураах зорилгоор битүүмжилсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар, эсхүл шууд гэрээгээр борлуулж мөнгийг төсөвт төвлөрүүлнэ" гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", 3 дахь хэсэгт "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэж заасан ба Арван зургадугаар зүйлийн 3-т "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах, хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно.", 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй" гэсэн заалтыг зөрчиж болохоор байна.

Нэр бүхий иргэдийн зүгээс "Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталж, тус хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт "Газар барьцаалах гэрээнд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1-д заасан журмаар гаргуулахаар талууд харилцан тохиролцож болно" гэсэн нэмэлт оруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчиж буй талаар мэдээлэл Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан байдаг. Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Барьцаалуулагч болох өмчлөгч нь газраа барьцаалж гэрээ байгуулахдаа хожим нь түүний эрх зөрчигдөх эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй байхад барьцаалагчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн барьцааны зүйл болох газраа үл маргах журмаар дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч Үндсэн хуулиар олгосон шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж болохоор хуульчилснаараа гэрээний талуудын эрх тэгш байдал зөрчигдөх, барьцаалуулагчийн эрх илтэд дордож болох нөхцөл үүсгэхээр байна. Иймд Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.4, 53.5 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасныг зөрчсөн гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна" гэсэн тогтоол гарсан.

Үүнээс үзэхэд татвар төлөгчийн хөрөнгийг битүүмжлэх, дуудлага худалдааны орлого хуваарилах журмын зохицуулалтыг дахин нягталж зохих өөрчлөлтийг хийх нь зүйтэй гэж дүгнэв.

3.Ойлгомжтой эсэх

"**Ойлгомжтой байдал**" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд "Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга"-ын төсөл боловсруулалтын хувьд Хууль

тогтоомжийн тухай хуулийн 26, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ. Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, дүн шинжилгээ хийсэн болно.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалд санал авахаар Засгийн газрын бүх гишүүд /13 яамд/-ээс санал авах тухай албан бичгийг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын хамтаар хавсарган хүргүүлж, санал авсан.

Яамдаас ирүүлсэн саналаас хуулийн төслийн үзэл баримтлалын ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад хуулийн төсөлд холбогдох саналыг тусган оруулсан.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, татварын алба, татвар төлөгч, бусад этгээдийн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн суурь зохицуулалтыг агуулсан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 14 бүлэг, 83 зүйлтэй, хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн бүтэц, хэлбэрт нийцсэн байна.

Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог цэгцлэх, найруулгыг ойлгомжтой томъёолох, логик дараалалд оруулах шаардлагатай байна. Тухайлбал, Монголын татварын албаны тогтолцоог Арвангуравдугаар бүлэг буюу хуулийн төслийн 71 дүгээр зүйлд зохицуулсан нь оновчгүй байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Татварын ерөнхий хуулийн бүтэц нь ХБНГУ-ын Татварын ерөнхий хуулийн бүтэцтэй төстэй бөгөөд шинэчлэн боловсруулсан төсөл нь нэг нь нөгөөгөөсөө урган гарах логик уялдаагүй бичигдсэн гэж дүгнэхээр байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.3.2-д заасан “үйлдвэрийн хүчин чадлыг 30-аас дээш хувиар өөрчлөх шаардлага бий болсон” гэж техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах шаардлагад тусгаж өгсөн байна. Тухайн үйлдвэрийн хүчин чадлыг 30-аас дээш хувьд өөрчлөлт орсныг хэн хяналт тавьж ажиллах, хуулийн этгээд шударгаар энэхүү өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн эсэх зэргийг томъёолох шаардлагатай байна.

Хуулийн төсөлд холбогдох мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн нөхөрлөлөөс ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдал, логик уялдааг сайжруулах тал дээр ирүүлсэн саналыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоосон байдал

Тус шалгуурын хүрээнд Татварын алба татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг харьцуулан шинжлэх замаар татвар төлөгчийн болон

татварын албаны үйл ажиллагааны эрсдэлийг тооцох зохицуулалтыг сонгож авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана”, Шинэ төрлийн татвар бий болгохгүй ба үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 1.5 тэрбум төгрөгөөс бага жилийн орлоготой аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 1 хувь болгон бууруулна. Аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татварыг орлогын төвшингээс хамаарсан шатлалтай болгоно. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, “Үндэсний хөрөнгө оруулагчдыг бүхий л талаар дэмжиж, эхний хөрөнгө оруулалтаа нөхөх хүртэл орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, “Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ” гэж тусгасан.

Үүнтэй холбогдуулан энэ хуульд хамрагдах ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц заалтыг доорх хүснэгтээр авч үзье.

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал/ сонгосон зүйл, заалт	Шаардагдах мэдээлэл баримт бичгүүд
1	Залилалангийн гэмт хэргийн хүрээнд татвар төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй	Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1-д Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэж залилах үйлдлийг гэмт хэрэгт тооцсон учраас Татварын ерөнхий хуулиар эрүүгийн шинжтэй зохицуулалтыг хийх нь буруу юм.
2	Мөнгө угаах болон терроризмын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой байж болохуйц сэжиг бүхий гүйлгээ гарсан тухай бүр татварын албанд өгөх	Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд мэдээлэх үүрэгтэй этгээдэд банк 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй. гэж заасан тул сэжиг бүхий гүйлгээ гарсан тухай бүр татварын албанд өгөх шаардлагагүй гэж үзэж байна.
3	42.2 Энэ хуулийн 42.1-д заасан гомдлыг дараах харьяаллын дагуу нэг шатны Маргаан таслах зөвлөл шийдвэрлэнэ.	Захиргааны ерөнхий хуулийн 93.1.Иргэн, хуулийн этгээд гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллагын дээд шатны захиргааны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана гэсэнтэй нийцэж байна.

Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д дурдагдсан нийтлэг шаардлагуудаас харилцан уялдаатай холбогдох 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т заасан нийтлэг шаардлагууд болон Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан шалгах хэрэгслийн дагуу үнэллээ:

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:*

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Татварын өр хураах үйл ажиллагаа Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглээгүй бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчсөн байж болзошгүй.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зөрчилдөөгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг иш татах, энэ тохиолдолд ишлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Энэхүү хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулиудтай давхардаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад хуулиас иш татсан байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 21, хүчингүй болсонд тооцох тухай 1, дагаж мөрдөх журмын тухай 1 хуулийн төслийг тус тус боловсруулсан байна.

- *Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан уялдаа холбоог шалгах хэрэгсэлд дурдагдсан шалгуурыг хангасан эсэх:*

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.28-д “эцсийн эзэмшигч” гэсэн нэр томьёог Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.26-д “бенефициар өмчлөгч” гэж хуульд заасны дагуу номинал эзэмшигчийн нэр дээр өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг бүртгүүлсэн, тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрхтэй жинхэнэ өмчлөгчийг гэж тайлбарласан байх бөгөөд хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “ногдуулсан татварыг хорогдуулах” гэсэн нэр томьёог юу гэж ойлгох нь тодорхойгүй, хуулийн нэр томьёотой давхардуулан тодорхойлсон байгааг дахин нягтлан үзэх шаардлагатай.

4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал дүн шинжилгээний хүрээнд илрээгүй болно.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Зөрчилтэй зохицуулалт илэрснийг өмнө дурдсан.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд байх бүхий л зохицуулалтыг тусгасан гэж ойлгож байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тийм	Хяналтаар төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх зохицуулалт илрээгүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм/ Үгүй	Татварын харилцааг зохицуулах хууль ерөнхий хууль
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдсан болно.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо зөрчилдөөгүй байх бөгөөд төслийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй байх бөгөөд үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгын дүн шинжилгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн⁷ 17 дугаар зүйлд заасны дагуу хийв. Шинэчлэн найруулсан Татварын ерөнхий хуулийн төсөл нь олон улсын татварын шинэлэг зарчмыг нэвтрүүлэх, татварын албыг чадавхжуулах, татвар төлөгчийн эрх ашгийг хамгаалах, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжих чиглэлд тодорхой зохицуулалт тусган боловсруулжээ.

Татварын эрх зүй нь Захиргааны эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд Татварын ерөнхий хуулиар татварын ойлголт, зарчим, суурь зохицуулалтуудыг эрх зүйн онол болон хуулийн тогтолцооны хувьд нэгдмэл байдлаар зохицуулах ёстой. Хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн төслийн бүтэцтэй харьцуулахад логик уялдаа муутай бичигдсэн гэж үзэхээр байна. Татварын эрх зүйн судлаачид одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг зөв бүтэцтэй гэж дүгнэснийг анхаарч үзэх шаардлагатай байв.

Төсөлд татварын тодорхойлолтыг тусгасан боловч төлбөр, хураамжтай хамтатган авч үзсэнийг анхаарах шаардлагатай. Онолын талаасаа татвар болон төлбөр, хураамж нь тус тусдаа ялгаатай ойлголт бөгөөд татвар хариу төлбөргүй, хураамж, төлбөр нь хариу төлбөртэй байдгаараа ялгаатай. Хураамж төсвийн орлогыг бүрдүүлэхэд зориулагдаагүйг анхаарах нь чухал юм.

Татварын шинэчлэлийн хүрээнд эдгээр онолын шинжтэй асуудлыг хуульчлах нь шинэчлэлийн мөн чанарыг илэрхийлнэ.

Татварын өр хураах ажиллагааг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтад нийцсэн байдлаар эрх мэдэл хуваах онолын үүднээс холбогдох өөрчлөлтийг хийх нь зүйтэй гэж дүгнэж байна.

4.2. Зөвлөмж

Санхүү, эдийн засаг, хууль зүйн шинжлэх ухаан харилцан шүтэлцээтэй хөгждөг салбарууд бөгөөд Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд татварын эрх зүй судлаач эрдэмтэд өөрсдийн санал дүгнэлтийг гаргах нь хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөнд чухал ач холбогдолтой гэсэн зөвлөмжийг өгч байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль

Монгол Улсын Эрүүгийн хууль 2017.

Татварын ерөнхий хууль 2008.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль 2013.

Сурах бичиг

Одгэрэл.П, Татварын эрх зүйн ерөнхий анги УБ., 2017

Бусад

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөр.

⁷Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://legalinfo.mn/law/details/11119?lawid=11119>.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу боловсрууллаа.

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зорилт нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын Татварын алба (цаашид “Татварын алба” гэх), татвар төлөгч, энэ хуультай холбогдсон бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах бөгөөд уг хуулийн харилцаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцсон болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор уг хуулийн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн зүгээс гарах зардлыг аргачлалд зааснаар дараахь үе шаттайгаар тооцлоо. Үүнд:

1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Татварын ерөнхий хууль нь татвартай холбоотой бүхий л процессын эрх зүйн үндсийг тогтоож, татварын алба, татвар төлөгч болон энэ хуультай холбогдсон бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах бөгөөд татвар төлөгчийн зүгээс дараахь нийтлэг үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Татвар төлөгчөөр бүртгүүлэх;
- б) Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлөх;
- в) Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа Татварын албанд тушаах.
- г) Татварын хяналт шалгалтад хамрагдах

Дээр дурдсан нийтлэг үүргүүдээс “б”, “в”-д заасан үүргийг Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 29.8, 30.2-т тус тус зааснаар тухайн төрлийн татварын хуулиар зохицуулах бөгөөд “а”, “г”-д заасан үүргийг Татварын ерөнхий хуулийн хүрээнд гүйцэтгэнэ.

Хуулийн төсөлд татвар төлөгч хуулийн этгээдэд шинээр нэмж үүрэг хүлээлгээгүй, хуулийн зүйл заалтуудыг тодорхой, ойлгомжтой болгож татварын хялбаршуулсан зохицуулалтыг шинээр бий болгож эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр тусгасан нь татвар төлөгч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг багасгасан нь шинээр хүний нөөц нэмэгдүүлэх шаардлага гаргахгүй.

1.2. Зардлыг тооцох:

Татварын ерөнхий хуулиар зохицуулсан татвар төлөгчөөр бүртгүүлэх, хяналт шалгалтад хамрагдахтай холбоотой үүрэг гүйцэтгэх чиг үүрэг бүхий хуулийн этгээдийн эрх бүхий албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос зарласан 2017 оны сарын цалингийн дундаж хэмжээ болох 980,125 төгрөгөөр тооцлоо.

Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотойгоор 2017 онд шинээр бүртгэл нэмүүлсэн 61136, бүртгэлээс хасалт хийлгэсэн 21717, нийт 82,853 тохиолдолд 575,048 минут зарцуулсан нь нэг хуулийн этгээдэд 4.9 минут ногдож байна. Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой асуудал нь хуулийн төсөлд өөрчлөгдөөгүй тул уг статистик мэдээг тооцоонд шууд ашиглав.

Мөн 2016-2017 онд дунджаар 5124 татвар төлөгч хуулийн этгээд татварын хяналт шалгалтад хамрагдсан бөгөөд татварын хяналт шалгалтад хамрагдахад хуулийн этгээдийн зүгээс дунджаар 260 минут зарцуулна.

Уг статистик мэдээнүүдэд үндэслэн хуулийн этгээдийн ажиллах хугацаа, ажлын хөлсийг тооцоолов.

Татвар төлөгчийн бүртгэл – 4.9 минут

Татварын хяналт шалгалт – 260 минут

Ажлын хөлс=Үндсэн цалин × Ажиллах хугацаа

$$980,125₮ = 980,125₮/\text{сар} \times 1 \text{ сар}$$

Зардал = Хугацаа × Ажлын хөлс

$$\text{Бүртгэлтэй холбоотой зардал } 477₮ = 4.9 \text{ минут} \times 980,125₮$$

$$\text{Хяналт шалгалттай холбоотой зардал } 25,281₮ = 260 \text{ минут} \times 980,125₮$$

1.3. Тоон үзүүлэлтийг тооцох:

Тохиолдлын тоог 2017 оны жил эцсийн байдлаар хуулийн этгээдийн статистик тоо мэдээллээр 177,215 гэж тооцов.

Татвар төлөгчийн бүртгэл болон хяналт шалгалттай холбоотой асуудал нь ялгаатай үйл ажиллагаа тул тус тусад нь тооцоолов.

Хуулийн этгээдүүд 2017 онд татвар төлөгчийн бүртгэлд 82853 удаагийн өөрчлөлт нэмэх, хасах өөрчлөлт хийсэн бөгөөд уг тоон үзүүлэлтийг нийт хуулийн этгээдийн тоонд харьцуулж давтамжийн тоог 0.47 гэж, Хяналт шалгалтын үйл ажиллагаа нь нэг аж ахуйн нэгжид дунджаар 5 жилд нэг удаа давтагдах бөгөөд нэг жилд ногдох давтамжийн тоог 0.2 гэж тодорхойлон тооцоонд ашиглав.

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

$$\text{Бүртгэлтэй холбоотой тоон үзүүлэлт } 82,853 = 177,215 \times 0.47$$

$$\text{Хяналт шалгалттай холбоотой тоон үзүүлэлт } 35,443 = 177,215 \times 0.2$$

1.4. Нийт зардлын дүнг тооцох:

Нийт зардал=Зардал × Тоон үзүүлэлт

$$\text{Бүртгэлтэй холбоотой тоон үзүүлэлт } 39,523,016₮ = 477₮ \times 82,853$$

Хяналт шалгалттай холбоотой тоон үзүүлэлт

$$896,034,553.3\text{₮}=25,281\text{₮}\times 35,443$$

$$\text{Нийт зардал} = \text{Зардал}_{\text{бүрт}} + \text{Зардал}_{\text{хш}}$$

$$935,557,569\text{₮}=39,523,016\text{₮}+896,034,553\text{₮}$$

1.5. Хялбарчлах боломж:

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор татвар төлөгч хуулийн этгээдийг үүрэгжүүлсэн татвар төлөгчийн бүртгэл хийлгэх, татварын хяналт шалгалтад хамруулахтай холбоотой хуулийн эдгээдийн зардлыг бууруулах боломжийг дараахь шалгууруудаар тодорхойлъё. Үүнд:

а) Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Бүх хуулийн этгээдийг хуулийн этгээдийн хэлбэр, үйл ажиллагааны онцлогоос нь хамааруулж холбогдох татварын төрлүүдээр татвар төлөгчөөр бүртгэх шаардлагатай тул бүртгэлтэй холбоотойгоор татвар төлөгчийн тоог бууруулах боломжгүй. Татварын хяналт шалгалтад хамруулах хуулийн этгээдийг эрсдэлд суурилан сонгон авахаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд одоогийн зохицуулалттай харьцуулахад хамрагдах хуулийн этгээдийн тоо буурна.

б) Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төсөлд татварын хялбаршуулсан горимын талаар шинээр зохицуулалт нэмсэн бөгөөд холбогдох шаардлага хангасан хуулийн этгээд хялбаршуулсан горимоор татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал, төлөлт, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд татвар төлөгчийн хувьд татварын албатай харилцах бүхий л төрлийн харилцаатай холбоотой зардал буурна.

в) Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

Хуулийн төсөлд тусгаснаар татвар төлөгч хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгээгүй бөгөөд татварын хялбаршуулсан горимтой холбоотойгоор холбогдох татвар төлөгч хуулийн этгээдийн үүрэг буурна.

1.6. Нэмэлт зардлыг тооцох.

Аж ахуй нэгжийн зүгээс Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох албан хаагчид гаргах материаллаг зардлын хэмжээг аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын хэмжээнээс нь хамааруулж тодорхойлоход нийт 132,513 хуулийн этгээд нэг жилд 568.18 сая төгрөгийн материаллаг зардал гаргахаар байна.

Ажил олгогчоос төлөх ЭМД, НДШ-ийн зардал

ЭМД, НДШ-ийн хэмжээ = Нийт цалингийн зардал × ЭМД, НДШ-ийн хувь хэмжээ

$$112.27 \text{ сая } \text{₮} = 935.58 \text{ сая } \text{₮} \times 12\%$$

Нэмэлт зардал = материаллаг зардал + ЭМД, НДШ-ийн хэмжээ

$$680.45 \text{ сая } \text{₮} = 568.18 \text{ сая } \text{₮} + 112.27 \text{ сая } \text{₮}$$

Нийт бүх зардал = нэмэлт зардал + нийт зардал

$$1,616.0 \text{ сая } \text{₮} = 680.45 \text{ сая } \text{₮} + 935.56 \text{ сая } \text{₮}$$

ХОЁР. ИРГЭНИЙ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор уг хуулийн харилцаанд оролцогч иргэний буюу татвар төлөгч хувь хүний зүгээс гарах зардлыг аргачлалд зааснаар дараахь үе шаттайгаар тооцлоо. Үүнд:

2.1. Хувь хүний гүйцэтгэх үүргийг тогтоох:

Татварын ерөнхий хууль нь татвартай холбоотой бүхий л процессын эрх зүйн үндсийг тогтоож, татварын алба, татвар төлөгч болон энэ хуультай холбогдсон бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах бөгөөд татвар төлөгчийн зүгээс дараахь нийтлэг үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

- а) Татвар төлөгчөөр бүртгүүлэх;
- б) Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлөх;
- в) Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа Татварын албанд тушаах.
- г) Татварын хяналт шалгалтад хамрагдах

Дээр дурдсан нийтлэг үүргүүдээс “б”, “в”-д заасан үүргийг Татварын ерөнхий хуулийн төслийн 29.8, 30.2-т тус тус зааснаар тухайн төрлийн татварын хуулиар зохицуулах бөгөөд “а”, “г”-д заасан үүргийг Татварын ерөнхий хуулийн хүрээнд гүйцэтгэнэ.

Хуулийн төсөлд татвар төлөгч хувь хүнд шинээр нэмж үүрэг хүлээлгээгүй, хуулийн зүйл заалтуудыг тодорхой, ойлгомжтой болгож татварын хялбаршуулсан зохицуулалтыг шинээр бий болгож эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр тусгасан нь татвар төлөгч хувь хүний гүйцэтгэх үүргийг багасгасан.

2.2. Зардлыг тооцох:

Татварын ерөнхий хуулиар зохицуулсан татвар төлөгчөөр бүртгүүлэх, хяналт шалгалтад хамрагдахтай холбоотой үүрэг гүйцэтгэхэд татвар төлөгч хувь хүний үндсэн цалингийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос зарласан 2017 оны сарын цалингийн дундаж хэмжээ болох 980,125 төгрөгөөр тооцлоо.

2017 онд 382,154 татвар төлөгчийн бүртгэл хийгдсэнээс 254,464 нь буюу 67.4 хувийг нь автотээврийн хэрэгслийн бүртгэл эзэлж байгаа бол үлдэх хувийг бусад төрлийн татварын бүртгэл эзэлж байна. Уг бүртгэл хийлгэхтэй холбоотойгоор татвар төлөгч хувь хүний зүгээс 759,604 минут зарцуулсан нь нэг хувь хүнд 0.72 минут ногдож байна. Татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой асуудал нь хуулийн төсөлд өөрчлөгдөөгүй тул уг статистик мэдээг тооцоонд шууд ашиглав. Мөн хувь хүний татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийхэд татвар төлөгч хувь хүний зүгээс дунджаар 78 минутын хугацааг зарцуулахаар тооцов.

Уг статистик мэдээнүүдэд үндэслэн хуулийн этгээдийн ажиллах хугацаа, ажлын хөлсийг тооцоолов.

Татвар төлөгчийн бүртгэл – 0.72 минут

Татварын хяналт шалгалт – 78 минут

Ажлын хөлс=Үндсэн цалин × Ажиллах хугацаа

$980,125\text{₮} = 980,125\text{₮}/\text{сар} \times 1 \text{ сар}$

Зардал = Хугацаа × Ажлын хөлс

Бүртгэлтэй холбоотой зардал $70\text{₮}=0.72 \text{ минут} \times 980,125\text{₮}$

Хяналт шалгалттай холбоотой зардал $7,584\text{₮}=78 \text{ минут} \times 980,125\text{₮}$

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох:

Тохиолдлын тоог бүртгэлийн хувьд татвар төлөгч 1,053,052 иргэнээр, хяналт шалгалтын хувьд ХХОАТ-ын болон холбогдох бусад төрлийн татвар төлөгчөөр бүртгэлтэй тайлан тушаасан 118416 иргэнээр тооцов.

Хуулийн этгээдүүд 2017 онд татвар төлөгчийн бүртгэлд 382,154 удаагийн өөрчлөлт нэмэх, хасах өөрчлөлт хийсэн бөгөөд уг тоон үзүүлэлтийг нийт татвар төлөгч хувь хүний тоонд харьцуулж давтамжийн тоог 0.363 гэж, хяналт шалгалтын үйл ажиллагаа нь нэг аж ахуйн нэгжид дунджаар 5 жилд нэг удаа давтагдах бөгөөд нэг жилд ногдох давтамжийн тоог 0.2 гэж тодорхойлон тооцоонд ашиглав.

Тоон үзүүлэлт=Тохиолдлын тоо × Давтамжийн тоо

Бүртгэлтэй холбоотой тоон үзүүлэлт $382,154 = 1,053,052 \times 0.363$

Хяналт шалгалттай холбоотой тоон үзүүлэлт $35,443 = 177,215 \times 0.2$

2.4. Нийт зардлын дүнг тооцох:

Нийт зардал=Зардал × Тоон үзүүлэлт

Бүртгэлтэй холбоотой тоон үзүүлэлт $29,808,012\text{₮}=78\text{₮} \times 382,154$

Хяналт шалгалттай холбоотой тоон үзүүлэлт $179,620,508\text{₮}=7,584\text{₮} \times 23,683$

Нийт зардал= Зардал_{бүрт}+ Зардал_{хш}

$209,428,520\text{₮}=29,808,012\text{₮}+179,620,508\text{₮}$

2.5. Хялбарчлах боломж:

Татварын ерөнхий хуулийн төсөлтэй холбоотойгоор татвар төлөгч хувь хүнийг үүрэгжүүлсэн татвар төлөгчийн бүртгэл хийлгэх, татварын хяналт шалгалтад хамруулахтай холбоотой хувь хүний зүгээс гарах зардлыг бууруулах боломжийг дараахь шалгууруудаар тодорхойлъё. Үүнд:

а) Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Татварын харилцаанд орж буй хувь хүмүүсийг холбогдох татварын төрлүүдээр татвар төлөгчөөр бүртгэх шаардлагатай тул бүртгэлтэй холбоотойгоор татвар төлөгчийн тоог бууруулах боломжгүй. Татварын хяналт шалгалтад хамруулах хуулийн этгээдийг эрсдэлд суурилан сонгон авахаар хуулийн төсөлд тусгасан бөгөөд одоогийн зохицуулалттай харьцуулахад хамрагдах хуулийн этгээдийн тоо буурна.

б) Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төсөлд татварын хялбаршуулсан горимын талаар шинээр зохицуулалт нэмсэн бөгөөд холбогдох шаардлага хангасан хувь хүн хялбаршуулсан горимоор татварын бүртгэл, ногдуулалт, хувь хэмжээ, тайлагнал,

төлөлт, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд татвар төлөгчийн хувьд татварын албатай харилцах бүхий л төрлийн харилцаатай холбоотой зардал буурна.

в) Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

Хуулийн төсөлд тусгаснаар татвар төлөгч хувь хүнд шинээр үүрэг хүлээлгээгүй бөгөөд татварын хялбаршуулсан горимтой холбоотойгоор холбогдох татвар төлөгч хувь хүний үүрэг буурна.

2.6. Нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн төсөлд тусгаснаар татвар төлөгч хувь хүнийг үүрэгжүүлсэн зохицуулалттай холбоотойгоор аливаа нэмэлт зардал гарахгүй болно.

ГУРАВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Татварын ерөнхий хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор татварын албаны зүгээс гарах зардлыг аргачлалд зааснаар дараахь үе шаттайгаар тооцлоо.

3.1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох:

а) Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах;

б) Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

в) Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

3.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Татварын ерөнхий хуулийн төсөлд татварын албыг шинээр үүрэгжүүлээгүй бөгөөд албаны үйл ажиллагааг хялбарчилсан боловч татвар төлөгчийн тоо өдөр ирэх тутам нэмэгдэж байна.

Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэх хүний нөөцийг одоогийн төвшинд хадгалж, орон тоог нэмэгдүүлэхгүйгээр хуулийг хэрэгжүүлэх боломжтой.

3.2.ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Татварын ерөнхий хуулийн төслийг хэрэгжүүлэх хүний нөөцийн хэрэгцээг албан хаагчдыг чиг үүрэг, тухай үүргийг гүйцэтгэх үүрэг бүхий албан хаагчдын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн баримжаалан тооцоход 380 хүн/жил буюу нийт албан хаагчдын 20 хувь уг хуулийг хэрэгжүүлэхэд нийт ажлын цагаа зарцуулсан байх бөгөөд хүний нөөцийн хэрэгцээ 380 байхаар байна.

Хүний нөөцийн хэрэгцээ = Тоо (баримжаагаар)

Хүний нөөцийн хэрэгцээ = 380

3.3. Гарах зардлыг урьдчилан тооцох;

Татварын албаны зүгээс дотоод зохион байгуулалт хийж хүний нөөцийн болон бусад материаллаг зардлыг нэмэгдүүлэхгүйгээр одоогийн төвшинд барьж ажиллах боломжтой.

-Хүний нөөцийн цалингийн зардал:

Албан хаагчийн үндсэн цалингийн хэмжээг дунджаар дараахь байдлаар тооцъё.

Үндсэн цалин төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-6 зэрэглэлийн 2-р шатлалаар 580,710₮;

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг, төрийн албанд 11-15 жил ажилласан гэж үзэж 10%-ийн нэмэгдэл олгохоор;

Зэрэг дэвийн хувьд гутгаар зэргийн дэс түшмэл гэж үзэж 17%-ийн нэмэгдэл олгохоор.

Цалингийн зардал = (үндсэн цалинг + нэмэгдлүүд)

$737,501.7₮/сар=580,710₮+580,710₮*10\%+580,710₮*17\%$

$737,501.7₮/сар \times 12 сар=8,850.020.0₮/ жил$

Ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл $1,062,002₮ = 8,850,020₮ \times 12\%$

Нийт цалинтай холбоотой зардал $9,912,023₮ = 8,850,020₮ + 1,062,002₮$

Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс цалин, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотойгоор дунджаар нэг албан хаагчид 9.91 сая төгрөгийн зардал гаргахаар байна.

-Материаллаг зардал:

Татварын алба 2017 онд 1905 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд ажлын байр, хөрөнгө оруулалттай холбоотой 4,303.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

Нэг албан хаагчид ногдох материаллаг зардлыг тооцож үзвэл

$4,303.6 сая ₮ /1905 = 2,259,134.5₮$

-Бусад зардал

Татварын албаны жилийн төсөвт зардлаас цалин хөдөлбөрийн хөлстэй холбоотой зардлыг цалингийн зардал хэсэгт, үлдэх зардлыг материаллаг зардал тооцоход хамруулан тооцсон тул хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөвт зардлаас илүү гарах бусад зардал гарахгүй болно.

3.4. Зардлыг нэгтгэн тооцох;

Нийт зардал = (хүний нөөцийн зардал + материаллаг зардал + бусад зардал) × хүний нөөцийн хэрэгцээ

$4,625,039,660₮ = (9,912,023₮+2,259,134₮+0) \times 380$

Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу татварын албаны зүгээс 380 хүний нөөцөд тулгуурлан 4,625.0 сая төгрөгийн зардал гаргахаар байна.

3.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Татварын ерөнхий хуулийн төсөлд тусгасан өр барагдуулах үйл ажиллагааг татварын алба бие дааж барагдуулах, татварын зорилгоор бусад улсуудтай мэдээлэл солилцох зохицуулалттай холбоотойгоор татварын албанд хүний нөөцийн хэрэгцээ шаардлага гарч, зардал өсөх хандлагатай боловч хуулийн төсөлд тусгасан эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо нэвтрүүлэх, татварын албаны үйл ажиллагааг цахимжуулах зэрэг зохицуулалттай

холбоотойгоор татварын албаны хүний нөөц, зардлын хэмжээг одоогийн төвшингээс нэмэгдүүлэхгүйгээр, дотоод зохицуулалт хийж хуулийг хэрэгжүүлж ажиллах боломжтой.

--oo00oo--

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЪЁОГ, ҮР ДҮН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.5, 38 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Сангийн яам, Татварын ерөнхий газар хамтран татварын шинэчлэлийн хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл нийт 32 хоногийн хугацаанд улс орон даяар өргөн хүрээтэй зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн саналыг хүлээн авлаа. Энэ хугацаанд татвар төлөгч, иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтэд, татварын байцаагчдын дунд Улаанбаатар хот болон бүх аймаг, дүүрэгт нийт 39 удаагийн танхимын хэлэлцүүлгийг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 4,790 хүн оролцож санал бодлоо илэрхийлсэн байна.

Түүнчлэн, Сангийн сайд, Сангийн яам, Татварын албаны цахим хаяг, фейсбүүк хуудас, твиттерээр дамжуулан хуулийн төслүүдтэй холбоотой санал сэтгэгдлүүдийг цахимаар хүлээн авч нэгтгэн боловсрууллаа.

Энэхүү олон нийтийн хэлэлцүүлгийн хүрээнд нийт 5,549 санал ирсэн бөгөөд үүнээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 2,142 санал, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1,349 санал, Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1,182 санал, дагалдах бусад хуулийн төсөлд нийт 876 саналыг тус тус ирүүлсэн байна.

Нийт ирүүлсэн саналыг нэг бүрчлэн судалж үзээд 1,783 саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан бол 1,891 саналыг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Мөн үлдсэн 1,875 санал нь сэтгэгдэл, асуулт хэлбэртэй байлаа. Ирсэн саналын дийлэнх нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын тайлагнал, хувь хэмжээ, хялбаршуулсан горим болон татварын ерөнхий орчинтой холбоотой байв.

Утга	Нийт	Хуулийн төслөөр					Санал тусгагдсан байдал			Саналын хандлага	
		ААНОАТ	ХХОАТ	ТЕХ	НӨАТ	Дагах	Авсан	Аваагүй	Сэтгэгдэл	Дэмжсэн	Дэмжээгүй
Хөнгөлөлт, чөлөөлөлт	901	135	665	12	83	6	301	383	217	139	26
Ерөнхий	854	145	158	399	44	108	349	182	323	279	24
Тайлагнал	519	136	89	127	162	5	111	144	264	38	19
Хялбаршуулалт	478	390	47	38	3	0	6	84	388	382	5
Хувь хэмжээ	475	177	190	3	92	13	104	230	141	54	44
Х тайлан	294	293	0	1	0	0	66	218	10	56	114
Хариуцлага	221	0	1	190	0	30	66	84	71	11	13
Босго	219	69	0	0	150	0	28	43	148	0	1
Хасагдах зардал	217	198	19	0	0	0	146	59	12	4	0
Өр барагдуулалт	171	0	0	169	0	2	49	47	75	38	4
Элэгдэл	164	164	0	0	0	0	77	77	10	21	3
Орлого	110	14	93	0	2	1	44	57	9	1	0
Бусад	926	421	87	243	171	4	436	283	207	40	7
НИЙТ	5,549	2,142	1,349	1,182	707	169	1,783	1,891	1,875	1,063	260

Бизнес эрхлэгчид Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан 3 тэрбум төгрөгийн босгыг 5, 6, 10, 15 болон 20 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэх санал гаргасныг нарийвчлан судлан үзэж,

ирүүлсэн саналын дагуу босгыг 6 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж төсөлд тусгасан. Түүнчлэн, хөрөнгийн биржээр нээлттэй арилжаалах бондын хүүгийн орлогод 5 хувиар ногдуулж байгааг банк, дотоод, гадаад гэж ялгалгүй нэгэн ижил мөрдөх санал гаргасныг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан. Түүнчлэн, Ахмад настныг дэмжих тухай хуулиар заасан санд төвлөрүүлсэн хөрөнгийг хасагдах зардлаар хүлээн зөвшөөрдөг болох, хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогын албан татвараас чөлөөлөх зэрэг нийгмийн шинж чанартай саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан болно.

Эцсийн эзэмшигчийн тодорхойлолт, татвар ногдуулах, төлөх, тайлагнах харилцаа ойлгомжгүй, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа талаар хэлэлцүүлгийн явцад нэлээдгүй санал гаргасан тул энэ асуудлаар тусгайлсан хэлэлцүүлэг хийж, холбогдох зохицуулалтыг энгийн, ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар болгосон.

Үнэ шилжилтийн асуудал нь зөвхөн татвар төлөгч аж ахуйн нэгжийн асуудал биш тул энэ зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар бус Татварын ерөнхий хуулийн дагуу зохицуулах нь зүйтэй гэсэн саналыг хэлэлцүүлгийн явцад гаргаж байсныг хүлээн авсан. Энэ асуудалтай холбоотойгоор үнэ шилжилтийн тохируулга хийх зарчмыг олон улсын туршлага, жишиг, стандартад нийцүүлэн хуулийн төсөлд тусгасан.

Татвар төлөгчийн эрхийг хамгаалах зорилгоор татварын хариуцлагатай холбоотой зохицуулалтыг Зөрчлийн тухай хуулиар биш Татварын ерөнхий хуулиар хариуцлага ногдуулж, прокурорын хяналтгүй захиргааны журмаар асуудлыг шийдвэрлэхээр холбогдох хуулиудад өөрчлөлт оруулсан болно.

Татварын маргаан таслах зөвлөлд гомдол гаргахдаа нөхөн ногдуулсан татварын 10 хувийг төлөхөөр байгааг бууруулах, эсхүл тодорхой хязгаар тогтоож оруулах саналыг хэлэлцүүлгийн явцад иргэд, хуулийн этгээдээс гаргасан тул энэ саналыг хүлээн авч тус зөвлөлд гомдол гаргах барьцааны хэмжээг 100 сая төгрөгөөр хязгаарлаж өгсөн болно.

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг дэмжих, зээлийн хүүг бууруулах зорилгоор санхүүгийн хэрэгслийг НӨАТ-аас чөлөөлөх саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан болно.

Харин, хялбаршуулсан татвар ногдуулах босгыг нэмэгдүүлэх, НӨАТ ногдуулах босгыг бууруулж бүх иргэд аж ахуйн нэгжийг НӨАТ-д хамруулах саналыг хүлээн аваагүй болно. Хувь хүний шууд бус орлогыг албан татвараас чөлөөлөх, мал бүхий этгээд, малчин өрхөөс малын хөлийн татвар саналыг дэмжээгүй.

Татварын тэгш, шударга зарчмыг баримтлах үүднээс иргэд, аж ахуйн нэгжээс хэлэлцүүлгийн явцад гаргасан зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэмэгдүүлэх саналыг хүлээн аваагүй болно.



Эхлэл / Мэдээ, Мэдээлэл / ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГҮҮД - I

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ


ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГҮҮД - I

Мэдээлэл нийтлэсэн: Сангийн яам

Нийтлэсэн огноо: 2018 оны 04 сарын 27

ЖИРГЭХ

ХУВААЛЦАХ



ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

2018-02-23-ААС 2018-03-27 ӨДРИЙГ ХҮРТЭЛ НИЙТ **32 ХОНОГИЙН** ХУГАЦААНД УЛС ОРОН ДАЯАР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНҮҮЛЖ НИЙТ **5,549** САНАЛ ХҮЛЭЭН АВЛАА

39 удаагийн танхимын хэлэлцүүлэгт 4,790 хүн оролцож 3,638 санал өглөө	ЦАХИМ СҮЛЖЭЭ БОЛОН БИЧГЭЭР НИЙТ 1,911 САНАЛ ХҮЛЭЭН АВЛАА
--------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------

- Бизнес эрхлэгчдийн төлөөлөл:**
МУХАУТ, CEO клуб, Монголын бизнесийн зөвлөл болон компаниудын төлөөлөл
- Хөрөнгө оруулагч, олон улсын байгууллагын төлөөлөл:**
Гадаад улс орнуудын худалдааны танхимууд, олон улсын байгууллагууд.
- Иргэдийн төлөөлөл:**
Үйлдвэрчний эвлэл, олон нийтийн байгууллага, иргэд.
- Төрийн бус байгууллагын төлөөлөл:**

www.mof.gov.mn

facebook.com/Hurelbaatarc

facebook.com/MOFMongolia


[@KhurelbaatarCh](https://twitter.com/KhurelbaatarCh)




САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИРСЭН САНАЛЫН ХАНДЛАГА

Ирсэн саналын ангилал



Саналын хандлага



САНГИЙН ЯАМ

ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕЭР ХАМГИЙН ИХ ХӨНДӨГДСӨН АСУУДЛУУД

№	Утга	Нийт	Хуулийн төслөөр					Санал тусгагдсан байдал			Саналын хандлага	
			ААНОАТ	ХХОАТ	ТЕХ	НӨАТ	Дагах	Авсан	Аваагүй	Сэтгэгдэл	Дэмжсэн	Дэмжээгүй
1	Хөнгөлөлт, чөлөөлөлт	901	135	665	12	83	6	301	383	217	139	26
2	Ерөний санал	854	145	158	399	44	108	349	182	323	279	24
3	Тайлан	519	136	89	127	162	5	111	144	264	38	19
4	Хялбаршуулалт	478	390	47	38	3	0	6	84	388	382	5
5	Хувь хэмжээ	475	177	190	3	92	13	104	230	141	54	44
6	Х тайлан	294	293	0	1	0	0	66	218	10	56	114
7	Хариуцлага	221	0	1	190	0	30	66	84	71	11	13
8	Босго, шатал	219	69	0	0	150	0	28	43	148	0	1
9	Хасагдах зардал	217	198	19	0	0	0	146	59	12	4	0
10	Эр барагдуулалт	171	0	0	169	0	2	49	47	75	38	4
11	Энэгдэл	164	164	0	0	0	0	77	77	10	21	3
12	Орлого	110	14	93	0	2	1	44	57	9	1	0
13	Бусад	926	421	87	243	171	4	436	283	207	40	7